Мөн хүнсний бус бараа, үйлчилгээний зарлагын 13.0 (265.2 мянга) хувийг тээврийн хэрэгслийн шатахуун, сэлбэг, засвар, үйлчилгээний зардал, 10.5 (214.2 мянга) хувийг бэлэн хувцас, гутал, 6.9 (140.6 мянга) хувийг эм, эмнэлгийн хэрэгсэл, үйлчилгээний зардал, 6.8 (137.9 мянга) хувийг харилцаа холбооны үйлчилгээний зардал, 6.1 (123.8 мянга) хувийг хувь хүнд хандсан бараа, үйлчилгээний зардал, 5.4 (110.0 мянга) хувийг боловсролын зардал эзэлж байна.

**ХҮСНЭГТ 12.** **ХҮНСНИЙ БУС БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САРЫН ДУНДАЖ ЗАРЛАГА, гол нэр төрлөөр, төгрөгөөр**

| Хүнсний бус бараа, үйлчилгээний гол нэр төрөл | 2024 X-XII | 2025 VII-IX | 2025 X-XII |
|---|---|---|---|
| Тээврийн хэрэгслийн шатахуун, сэлбэг, засвар | 178 585 | 205 940 | 219 463 |
| Эм, эмнэлгийн хэрэгсэл, үйлчилгээ | 113 462 | 125 946 | 140 617 |
| Бэлэн хувцас | 147 241 | 130 983 | 140 520 |
| Харилцаа холбооны үйлчилгээ | 113 851 | 126 343 | 137 881 |
| Хувь хүнд хандсан бараа, үйлчилгээ | 111 060 | 118 155 | 123 786 |
| Боловсрол | 81 226 | 114 910 | 110 030 |

| | | | |
|---|---|---|---|
| Гутал, хос | 75 414 | 74 478 | 73 701 |
| Чөлөөт цаг болон соёлын үйлчилгээ | 59 623 | 62 672 | 72 196 |
| Сууцны төлбөр | 45 273 | 62 266 | 69 211 |
| Цахилгаан | 38 133 | 50 065 | 48 674 |
| Тээврийн үйлчилгээ | 46 470 | 41 420 | 45 704 |
| Түлш | 43 556 | 39 212 | 36 307 |

Өрхүүдийг мөнгөн зарлагаар нь бүлэглэн авч үзэхэд 2025 оны 4 дүгээр улиралд 700.0 мянган төгрөгөөс доош зарлагатай өрх 39.6 (3.7%) мянга, 700.0-1600.0 мянган төгрөгийн зарлагатай өрх 246.2 (23.0%) мянга, 1.6-3.0 сая төгрөгийн зарлагатай өрх 374.6 (35.0%) мянга, 3.0 сая төгрөгөөс дээш зарлагатай өрх 410.0 (38.3%) мянган өрх байна.

Мөнгөн зарлагын бүлэглэлт тус бүрээр өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл, 700.0 мянган төгрөгөөс доош зарлагатай өрх 15.6 мянгаар, 700.0-900.0 мянган төгрөгийн зарлагатай өрх 2.8 мянгаар, 900.0-1100.0 мянган төгрөгийн зарлагатай өрх 0.7 мянгаар, 1.1-1.6 сая төгрөгийн зарлагатай өрх 1.2 мянгаар, 2.1-3.0 сая төгрөгийн зарлагатай өрх 7.0 мянгаар тус тус буурсан бол, 1.6-2.1 сая төгрөгийн зарлагатай өрх 1.1 мянгаар, 3.0-4.0 сая төгрөгийн зарлагатай өрх 2.0 мянгаар, 4.0 сая төгрөгөөс дээш зарлагатай өрх 90.8 мянгаар нэмэгдсэн байна.

**ХҮСНЭГТ 13. МӨНГӨН ЗАРЛАГЫН БҮЛЭГЛЭЛТ, өрхийн дунд эзлэх хувь, мянган өрхөөр**

| Мөнгөн зарлагын бүлэг | 2024 X-XII | | 2025 VII-IX | | 2025 X-XII | |
|---|---|---|---|---|---|---|
| | Өрхийн тоо /мянган өрх/ | Дунд эзлэх хувь | Өрхийн тоо /мянган өрх/ | Дунд эзлэх хувь | Өрхийн тоо /мянган өрх/ | Дунд эзлэх хувь |
| 700 000 төгрөг хүртэл | 55.2 | 5.5 | 47.7 | 4.7 | 39.6 | 3.7 |
| 700 001 – 900 000 | 54.2 | 5.4 | 38.6 | 3.8 | 51.4 | 4.8 |
| 900 001 – 1 100 000 | 54.2 | 5.4 | 46.7 | 4.6 | 53.5 | 5.0 |
| 1 100 001 – 1 600 000 | 142.5 | 14.2 | 134.9 | 13.3 | 141.3 | 13.2 |
| 1 600 001 – 2 100 000 | 146.6 | 14.6 | 149.1 | 14.7 | 147.7 | 13.8 |
| 2 100 001 – 3 000 000 | 233.9 | 23.3 | 208.0 | 20.5 | 226.9 | 21.2 |
| 3 000 001 – 4 000 000 | 159.6 | 15.9 | 150.2 | 14.8 | 161.6 | 15.1 |
| 4 000 001 төгрөгөөс дээш | 157.6 | 15.7 | 239.4 | 23.6 | 248.4 | 23.2 |

Улсын хэмжээнд 2025 оны 4 дүгээр улирлын байдлаар сард 700.0 мянган төгрөг хүртэлх зарлагатай өрхийн дундаж мөнгөн зарлагын 29.0 хувийг, 700.0-1100.0 мянган төгрөгийн зарлагатай өрхийн дундаж мөнгөн зарлагын 26.6 хувийг, 1.1-1.6 сая төгрөгийн зарлагатай өрхийн дундаж мөнгөн зарлагын 24.1 хувийг хүнсний бүтээгдэхүүний зарлага эзэлж байгаа бол 2.1 сая төгрөгөөс дээш зарлагатай өрхийн дундаж мөнгөн зарлагын 15.8 хувийг хүнсний бүтээгдэхүүний зарлага, 72.6 хувийг хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага эзэлж байна.

**ХҮСНЭГТ 14. МӨНГӨН ЗАРЛАГЫН БҮЛЭГЛЭЛТ, төгрөгөөр**

| | Мөнгөн зарлагын бүлэг | Дундаж мөнгөн зарлага | Хүнсний бүтээгдэхүүний зарлага | Хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага | Бусад зарлага | Бусдад өгсөн бэлэг, тусламж |
|---|---|---|---|---|---|---|
| 2024 X-XII | 700 000 төгрөг хүртэл | 545 676 | 147 305 | 281 362 | 107 748 | 9 261 |
| | 700 001 – 1 100 000 | 897 110 | 222 489 | 472 707 | 186 724 | 15 190 |
| | 1 100 001 – 1 600 000 | 1 365 312 | 313 656 | 795 398 | 224 610 | 31 648 |
| | 1 600 001 – 2 100 000 | 1 853 818 | 370 763 | 1 156 311 | 274 345 | 52 399 |
| | 2 100 001 төгрөгөөс дээш | 3 596 259 | 595 376 | 2 576 394 | 346 786 | 77 703 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2025 X-XII | 700 000 төгрөг хүртэл | 538 901 | 156 250 | 253 943 | 116 355 | 12 353 |
| | 700 001 – 1 100 000 | 904 074 | 240 663 | 459 805 | 190 145 | 13 461 |
| | 1 100 001 – 1 600 000 | 1 367 321 | 329 952 | 746 076 | 252 734 | 38 559 |
| | 1 600 001 – 2 100 000 | 1 843 832 | 426 338 | 1 104 014 | 283 769 | 29 711 |
| | 2 100 001 төгрөгөөс дээш | 4 015 333 | 633 150 | 2 915 601 | 380 646 | 85 936 |

Ойлголт, тодорхойлолт:

Өрх:
Нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын хэрэгцээт зүйлсээ хамтран хангадаг хэсэг бүлэг хүмүүс болон ганц биеэрээ өрх болон амьдардаг хүнийг хэлнэ. Өрхийн гишүүд нь хоорондоо ураг төрлийн, хамаатан садны холбоотой, бүх гишүүд болон зарим гишүүд нь огт хамааралгүй эсвэл эдгээрийн аль алинаас бүрдсэн байж болно.

Өрхийн орлого:
Өрхийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлт, бизнес, хөрөнгө оруулалт, тэтгэвэр, тэтгэмж, халамж болон бусад эх үүсвэрээс олж буй бүх төрлийн мөнгөн болон мөнгөн бус орлогыг хэлнэ. Өрхийн нийт орлогыг тооцохдоо өрхийн мөнгөн орлого, өрхийн өөрийн аж ахуйгаас бэлтгэж хэрэглэсэн болон бусдаас үнэгүй авч хэрэглэсэн зүйлийн мөнгөн дүнгүүдийн нийлбэрээр тодорхойлдог. Өрхийн мөнгөн орлого нь цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого (хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлого, хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого) болон бусад орлогоос бүрдэнэ.

Өрхийн зарлага:
Өрхийн хэрэглээнд зориулагдан зарцуулсан бүх бараа, үйлчилгээний мөнгөн болон мөнгөн бус зардлыг хэлнэ. Үүнд: хүнс, хувцас, орон сууц, эрүүл мэнд, боловсрол, тээвэр, холбоо, ахуйн хэрэглээний бараа, үйлчилгээний төлбөр, зээлийн төлбөр зэрэг хэрэглээний зардлууд ордог. Өрхийн нийт зарлагыг тооцохдоо өрхийн мөнгөн зарлага, өрхийн өөрийн аж ахуйгаас бэлтгэж хэрэглэсэн болон бусдаас үнэгүй авч хэрэглэсэн зүйлийн мөнгөн дүнгүүдийн нийлбэрээр тодорхойлдог. Өрхийн мөнгөн зарлага нь хүнсний бүтээгдэхүүн, хүнсний бус бараа, үйлчилгээний болон бусдад өгсөн бэлэг, тусламж, бусад зарлагаас бүрдэнэ.



# ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖ

## Нэг ажиллагчид ногдох ДНБ 2025 онд 4.8 хувиар өслөө.

Нэг ажиллагчид ногдох ДНБ (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 2025 оны 4 дүгээр улиралд 6.9 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 465.5 (7.3%) мянган төгрөгөөр өссөн байна.

**ЗУРАГ 5.** **НЭГ АЖИЛЛАГЧИД НОГДОХ ДНБ, улирлаар, сая төгрөгөөр**




Томсгосон 4 салбараар авч үзвэл, нэг ажиллагчид ногдох ДНБ буюу хөдөлмөрийн бүтээмж 2025 онд өмнөх оноос хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, барилга, үйлчилгээний салбарт өссөн бол уул уурхай, олборлолтын салбарт буурсан байна.

**ЗУРАГ 6.** **НЭГ АЖИЛЛАГЧИД НОГДОХ ДНБ, салбараар, сая төгрөгөөр**




Нэг ажиллагчид ногдох нэмэгдэл өртөг 2025 онд үйлчилгээний салбарт 22.2 сая төгрөг болж, өмнөх оноос 2.0 (10.1%) сая төгрөгөөр, үйлдвэрлэл, барилгын салбарт 19.3 сая төгрөг болж, 1.0 (5.6%) сая төгрөгөөр, хөдөө аж ахуйн салбарт 10.1 сая төгрөг болж, 1.1 (11.7%) сая төгрөгөөр тус тус өссөн бол уул уурхай, олборлолтын салбарт 53.0 сая төгрөг болж 2.4 (4.4%) сая төгрөгөөр буурчээ.

Ойлголт, тодорхойлолт:

Бүтээмж нь улс оронд бий болсон үйлдвэрлэл, үйлчилгээний үр ашгийн үзүүлэлт бөгөөд бүтээмжийг үйлдвэрлэл (гарц), орцын харьцаагаар тодорхойлно.

Хөдөлмөрийн бүтээмж нь нэг ажиллагчид ногдох бодит ДНБ-ээр хэмжигдэнэ. Хөдөлмөрийн бүтээмжийн тооцоонд ашиглаж буй ДНБ-д өөрийн эзэмшлийн орон сууцны хийсвэр түрээсийг тусгаагүй болно.

Тооцох аргачлал:

Хөдөлмөрийн бүтээмжийг тооцохдоо ДНБ (нэмэгдэл өртөг)-ий хэмжээг ажиллагчдын тоонд хуваан тооцно.

$$P = \frac{Q}{L}$$

P – хөдөлмөрийн бүтээмж
Q – ДНБ (нэмэгдэл өртөг)
L – ажиллагчдын тоо

# ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН

## ДНБ 2025 онд 6.8 хувиар өслөө.

### 1. ДНБ, үйлдвэрлэлийн аргаар

ДНБ (урьдчилсан гүйцэтгэлээр оны үнээр, үйлдвэрлэлийн аргаар тооцсон) 2025 онд 89.9 их наяд төгрөг болж, өмнөх онтой харьцуулахад 9.3 (11.5%) их наяд төгрөгөөр өсөхөд хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг 2.2 (36.7%) их наяд төгрөгөөр, үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг 4.1 (11.5%) их наяд төгрөгөөр, үйлдвэрлэл, барилга 2.0 (22.4%) их наяд төгрөгөөр өссөн нь нөлөөлөв.

**ХҮСНЭГТ 15.** **ДНБ, үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр**

| Үзүүлэлт | Жил | | | 2025*/2024 | |
|---|---|---|---|---|---|
| | 2023 | 2024 | 2025* | зөрүү | хувь |
| | тэрбум төгрөг | | | | |
| ДНБ | 70 441.5 | 80 663.1 | 89 937.1 | 9 274.1 | 11.5 |
| Хөдөө аж ахуй | 6 988.2 | 5 881.1 | 8 039.3 | 2 158.2 | 36.7 |
| Уул уурхай, олборлолт | 19 814.1 | 21 980.6 | 22 747.1 | 766.5 | 3.5 |
| Үйлдвэрлэл, барилга | 8 035.3 | 8 785.0 | 10 754.4 | 1 969.5 | 22.4 |
| Үйлчилгээ | 28 911.6 | 35 766.6 | 39 879.4 | 4 112.8 | 11.5 |
| Бүтээгдэхүүний цэвэр татвар | 6 692.4 | 8 249.8 | 8 516.9 | 267.1 | 3.2 |

ДНБ (урьдчилсан гүйцэтгэлээр 2015 оны зэрэгцүүлэх үнээр, үйлдвэрлэлийн аргаар тооцсон) 2025 онд 34.3 их наяд төгрөг болж, өмнөх онтой харьцуулахад 2.2 (6.8%) их наяд төгрөгөөр өсөхөд хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг 917.8 (33.2%) тэрбум төгрөгөөр, үйлдвэрлэл, барилгын салбарынх 482.8 (11.4%) тэрбум төгрөгөөр, уул уурхай, олборлолт 453.6 (10.6%) тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлөв.

**ХҮСНЭГТ 16.** **ДНБ, үйлдвэрлэлийн аргаар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр**

| Үзүүлэлт | Жил | | | 2025*/2024 | |
|---|---|---|---|---|---|
| | 2023 | 2024 | 2025* | зөрүү | хувь |
| | тэрбум төгрөг | | | | |
| ДНБ | 30 567.1 | 32 132.7 | 34 331.9 | 2 199.1 | 6.8 |
| Хөдөө аж ахуй | 3 873.3 | 2 761.1 | 3 678.9 | 917.8 | 33.2 |
| Уул уурхай, олборлолт | 3 867.2 | 4 283.1 | 4 736.6 | 453.6 | 10.6 |
| Үйлдвэрлэл, барилга | 4 182.3 | 4 247.2 | 4 730.0 | 482.8 | 11.4 |
| Үйлчилгээ | 14 837.0 | 16 473.9 | 16 806.2 | 332.3 | 2.0 |
| Бүтээгдэхүүний цэвэр татвар | 3 807.3 | 4 367.4 | 4 380.1 | 12.7 | 0.3 |

**ЗУРАГ 7.** **ДНБ (УЛИРЛЫН НӨЛӨӨЛЛИЙГ АРИЛГАСАН)-ИЙ ӨСӨЛТ, БУУРАЛТ, хувиар, өмнөх улиралтай харьцуулснаар**




ДНБ (урьдчилсан гүйцэтгэлээр 2015 оны зэрэгцүүлэх үнээр үйлдвэрлэлийн аргаар улирлын нөлөөллийг арилган тооцсон) 2025 оны 4-р улиралд өмнөх улирлаас 0.7 хувиар өслөө.

ДНБ (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 2023 онд 7.4 хувь, 2024 онд 5.1 хувь, 2025 онд 6.8 хувиар тус тус өссөн байна.

**ЗУРАГ 8.** **ДНБ-ИЙ ӨСӨЛТ, БУУРАЛТ, хувиар (2015 оны зэрэгцүүлэх үнээр, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар)**




**ХҮСНЭГТ 17.** **ДНБ-ИЙ ӨӨРЧЛӨЛТӨД САЛБАРУУДЫН ОРОЛЦОО**

| Салбар | 2023 | 2024 | 2025* |
|---|---|---|---|
| | нэгж хувь | | |
| ДНБ-ий өсөлт, бууралт, % | 7.4 | 5.1 | 6.8 |
| Хөдөө аж ахуй | -1.3 | -3.6 | 2.9 |
| Уул уурхай, олборлолт | 2.6 | 1.4 | 1.4 |
| Үйлдвэрлэл, барилга | 0.6 | 0.2 | 1.5 |
| Боловсруулах | 0.4 | -0.3 | 0.7 |
| Цахилгаан, хий, уур, усан хангамж | 0.1 | 0.1 | 0.2 |
| Барилга | 0.1 | 0.4 | 0.5 |
| Үйлчилгээ | 4.8 | 5.4 | 1.0 |
| Бөөний, жижиглэн худалдаа | 0.8 | 1.4 | -0.6 |
| Тээвэр | 1.8 | 1.0 | 0.3 |
| Мэдээлэл, холбоо | 0.5 | 0.5 | 0.2 |
| Үйлчилгээний бусад | 1.7 | 2.5 | 1.0 |
| Бүтээгдэхүүний цэвэр татвар | 0.8 | 1.8 | 0.0 |

ДНБ (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 2025 онд 6.8 хувиар өссөний 2.9 нэгж хувийг хөдөө аж ахуйн салбар, 1.4 нэгж хувийг уул уурхай, олборлолтын салбар, 1.5 нэгж хувийг үйлдвэрлэл, барилгын салбар, 1.0 нэгж хувийг үйлчилгээний салбар бүрдүүлсэн байна.

## 2. ДНБ, эцсийн ашиглалтын аргаар

ДНБ (урьдчилсан гүйцэтгэлээр оны үнээр, эцсийн ашиглалтын аргаар тооцсон) 2025 онд 92.6 их наяд төгрөг болж, өмнөх онтой харьцуулахад 12.4 (15.4%) их наяд төгрөгөөр өслөө.

ДНБ (урьдчилсан гүйцэтгэлээр 2015 оны зэрэгцүүлэх үнээр, эцсийн ашиглалтын аргаар тооцсон) 2025 онд 34.2 их наяд төгрөг болж, өмнөх онтой харьцуулахад 2.2 (6.9%) их наяд төгрөгөөр өслөө.

**ХҮСНЭГТ 18. ЭЦСИЙН АШИГЛАЛТЫН АРГААРХ ДНБ, оны үнээр**

| Үзүүлэлт | Жил | | | 2025* / 2024 | |
|---|---|---|---|---|---|
| | 2023 | 2024 | 2025* | зөрүү | хувь |
| | тэрбум төгрөг | | | | |
| ДНБ | 71 201.6 | 80 208.4 | 92 588.1 | 12 379.8 | 15.4 |
| Эцсийн хэрэглээ | 40 524.0 | 52 355.4 | 59 451.5 | 7 096.1 | 13.6 |
| Өрхийн хэрэглээ[1] | 31 362.2 | 39 872.7 | 46 303.6 | 6 431.0 | 16.1 |
| Төрийн байгууллагын хэрэглээ | 9 161.9 | 12 482.8 | 13 147.9 | 665.1 | 5.3 |
| Хөрөнгийн нийт хуримтлал | 23 879.9 | 28 671.9 | 28 252.3 | - 419.6 | - 1.5 |
| Үндсэн хөрөнгийн нийт хуримтлал | 17 839.8 | 21 913.7 | 25 199.5 | 3 285.9 | 15.0 |
| Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт[2] | 6 040.1 | 6 758.2 | 3 052.8 | - 3 705.4 | - 54.8 |
| Цэвэр экспорт | 6 797.6 | -818.9 | 4 884.2 | 5 703.2 | - |
| Бараа, үйлчилгээний экспорт | 53 716.7 | 55 428.9 | 61 219.4 | 5 790.5 | 10.4 |
| Бараа, үйлчилгээний импорт (-) | 46 919.1 | 56 247.8 | 56 335.1 | 87.3 | 0.2 |

[1] Өрхийн хэрэглээний дунд өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээг оруулсан.
[2] Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлтийн дунд үнэт зүйлсийн хуримтлал, статистик зөрүү орсон.

**ХҮСНЭГТ 19. ЭЦСИЙН АШИГЛАЛТЫН АРГААРХ ДНБ, 2015 оны зэрэгцүүлэх үнээр**

| Үзүүлэлт | Жил | | | 2025* / 2024 | |
|---|---|---|---|---|---|
| | 2023 | 2024 | 2025* | зөрүү | хувь |
| | тэрбум төгрөг | | | | |
| ДНБ | 30 441.5 | 31 979.3 | 34 175.6 | 2 196.3 | 6.9 |
| Эцсийн хэрэглээ | 26 172.9 | 29 675.8 | 31 371.0 | 1 695.2 | 5.7 |
| Өрхийн хэрэглээ[1] | 20 268.9 | 22 931.6 | 25 040.7 | 2 109.2 | 9.2 |
| Төрийн байгууллагын хэрэглээ | 5 904.0 | 6 744.2 | 6 330.2 | - 414.0 | - 6.1 |
| Хөрөнгийн нийт хуримтлал | 12 733.0 | 15 683.0 | 14 547.7 | - 1 135.3 | - 7.2 |
| Үндсэн хөрөнгийн нийт хуримтлал | 9 616.8 | 11 768.5 | 12 828.9 | 1 060.4 | 9.0 |
| Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт[2] | 3 116.2 | 3 914.5 | 1 718.8 | - 2 195.7 | - 56.1 |
| Цэвэр экспорт | -8 464.4 | -13 379.5 | - 11 743.1 | 1 636.4 | - 12.2 |
| Бараа, үйлчилгээний экспорт | 20 500.2 | 20 653.2 | 21 931.7 | 1 278.5 | 6.2 |
| Бараа, үйлчилгээний импорт (-) | 28 964.6 | 34 032.7 | 33 674.8 | - 357.8 | - 1.1 |

[1] Өрхийн хэрэглээний дунд өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээг оруулсан.
[2] Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлтийн дунд үнэт зүйлсийн хуримтлал, статистик зөрүү орсон.

ДНБ-ий 6.9 хувийн өсөлтийн 5.3 нэгж хувь нь эцсийн хэрэглээнд, -3.6 нэгж хувь нь хөрөнгийн нийт хуримтлалд, 5.1 нэгж хувь нь цэвэр экспортод ногдож байна.

Эцсийн хэрэглээ (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 31.4 их наяд төгрөг болж, өмнөх онтой харьцуулахад 1.7 (5.7%) их наяд төгрөгөөр өссөн байна.

## ХҮСНЭГТ 20. ДНБ-ИЙ ӨӨРЧЛӨЛТӨД БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГИЙН ОРОЛЦОО

| Бүрэлдэхүүн | 2023 | 2024 | 2025* |
|---|---|---|---|
| | нэгж хувь | | |
| ДНБ-ий өсөлт, бууралт, % | 7.2 | 5.1 | 6.9 |
| Эцсийн хэрэглээ | 7.0 | 11.5 | 5.3 |
| Өрхийн хэрэглээ[1] | 6.3 | 8.8 | 6.6 |
| Төрийн байгууллагын хэрэглээ | 0.7 | 2.8 | -1.3 |
| Хөрөнгийн нийт хуримтлал | - 1.6 | 9.7 | -3.6 |
| Үндсэн хөрөнгийн хуримтлал | 1.7 | 7.1 | 3.3 |
| Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт[2] | - 3.3 | 2.6 | -6.9 |
| Цэвэр экспорт | 1.8 | - 16.1 | 5.1 |
| Бараа, үйлчилгээний экспорт | 18.0 | 0.5 | 4.0 |
| Бараа, үйлчилгээний импорт (-) | 16.2 | 16.6 | -1.1 |

[1] Өрхийн хэрэглээний дунд өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээг оруулсан.
[2] Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлтийн дунд үнэт зүйлсийн хуримтлал, статистик зөрүү орсон.

Өрхийн эцсийн хэрэглээ (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 25.0 их наяд төгрөг болж, өмнөх онтой харьцуулахад 2.1 (9.2%) их наяд төгрөгөөр өсөж, ДНБ-д 6.6 нэгж хувиар эерэг нөлөө үзүүлсэн байна.

Төрийн байгууллагын хэрэглээ (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 6.3 их наяд төгрөг болж өмнөх онтой харьцуулахад 414.0 (6.1%) тэрбум төгрөгөөр буурч, ДНБ-д 1.3 нэгж хувиар сөргөөр нөлөөлжээ.

## ЗУРАГ 9. ӨРХИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ӨСӨЛТ, БУУРАЛТ, хувиар (2015 оны зэрэгцүүлэх үнээр, өмнөх оны мөн үеэс)




[1] Өрхийн хэрэглээний дунд өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээг оруулсан.

Хөрөнгийн нийт хуримтлал (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 14.5 их наяд төгрөг болж өмнөх онтой харьцуулахад 1.1 (7.2%) их наяд төгрөгөөр буурсан байна.

Үүнд үндсэн хөрөнгийн нийт хуримтлал 12.8 их наяд төгрөг болж өмнөх онтой харьцуулахад 1.1 (9.0%) их наяд төгрөгөөр өссөн бол материаллаг эргэлтийн хөрөнгө 1.7 их наяд төгрөг болж өмнөх онтой харьцуулахад 2.2 (56.1%) их наяд төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн нийт хуримтлал буурахад нөлөөлсөн байна.

## ЗУРАГ 10. ҮНДСЭН ХӨРӨНГИЙН НИЙТ ХУРИМТЛАЛЫН ӨСӨЛТ, БУУРАЛТ, хувиар (2015 оны зэрэгцүүлэх үнээр, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар)



Бараа, үйлчилгээний цэвэр экспорт (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 2025 онд 11.7 их наяд төгрөгийн алдагдалтай гарлаа.
Бараа, үйлчилгээний экспорт (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 21.9 их наяд төгрөг болж өмнөх онтой харьцуулахад 1.3 (6.2%) их наяд төгрөгөөр өссөн бол бараа, үйлчилгээний импорт 33.7 их наяд төгрөг болж өмнөх онтой харьцуулахад 357.8 (1.1%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

**ЗУРАГ 11. БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭКСПОРТ, ИМПОРТЫН ХЭМЖЭЭ, их наяд төгрөгөөр**




Гадаад эдийн засгаас хүлээн авсан цэвэр орлого 2025 онд 10.1 их наяд төгрөгийн алдагдалтай гарсан бол хоёрдогч орлого буюу цэвэр шилжүүлэг 1.3 их наяд төгрөгийн ашигтай гарсан байна.

2025 онд үндэсний нийт орлого 79.8 их наяд төгрөг, үндэсний нийт эзэмшлийн орлого 81.1 их наяд төгрөгт хүрсэн байна.
Өмнөх онтой харьцуулахад үндэсний нийт орлого 11.5 хувиар, үндэсний нийт эзэмшлийн орлого 11.0 хувиар тус тус өслөө.

**ХҮСНЭГТ 21. ДНБ, ҮНО, ҮНЭО, оны үнээр**

| Үзүүлэлт | Жил | | | 2025* / 2024 | |
|---|---|---|---|---|---|
| | 2023 | 2024 | 2025* | зөрүү | хувь |
| | тэрбум төгрөг | | | | |
| ДНБ | 70 441.5 | 80 663.1 | 89 937.1 | 9 274.1 | 11.5 |
| Гадаад эдийн засгаас хүлээн авсан анхдагч орлого, цэвэр | - 7 725.5 | - 9 049.1 | - 10 092.6 | - 1 043.4 | 11.5 |
| ҮНО | 62 716.0 | 71 613.9 | 79 844.6 | 8 230.6 | 11.5 |
| Гадаад эдийн засгаас хүлээн авсан хоёрдогч орлого, цэвэр | 1 381.3 | 1 425.1 | 1 260.8 | - 164.3 | - 11.5 |
| ҮНЭО | 64 097.3 | 73 039.0 | 81 105.3 | 8 066.3 | 11.0 |

Ойлголт, тодорхойлолт:

Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ):
Тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд тайлант хугацаанд дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн шинээр бүтээсэн нийт нэмэгдэл өртгийн хэмжээ юм. ДНБ-ийг дараах 3 аргаар тооцно.

- Үйлдвэрлэлийн арга: Нийт үйлдвэрлэлээс завсрын хэрэглээг хасаж нэмэгдэл өртгийн нийлбэр дүнгээр тооцохыг,
- Эцсийн ашиглалтын арга: Эцсийн хэрэглээ, хөрөнгийн нийт хуримтлал, цэвэр экспортын (экспорт, импортын зөрүү) нийлбэрээр тооцохыг,
- Орлогын арга: Ажиллагчдын цалин хөлс, үндсэн хөрөнгийн хэрэглээ, үйлдвэрлэл, импортын цэвэр татвар, үйл ажиллагааны цэвэр ашиг/холимог орлого зэрэг орлогын үзүүлэлтийн нийлбэрээр тооцохыг ойлгоно.

Үндэсний нийт орлого (ҮНО):
Тухайн улсын эдийн засгийн харьяатуудын шинээр бий болгосон нэмэгдсэн өртөг бөгөөд ҮНО-ыг тооцохдоо ДНБ-ий гүйцэтгэл дээр харьяат болон харьяат бусын хооронд хийгдсэн анхдагч цэвэр орлогын хэмжээг нэмнэ. Анхдагч орлогод а.харьяат бус ажиллагчдад төлсөн цалин хөлс, түүнтэй адилтгах орлого, б.хөрөнгө оруулалтын орлого буюу харьяат, харьяат бусын хооронд харилцан шилжүүлсэн ногдол ашиг, хүүгийн орлого орно.

Үндэсний нийт эзэмшлийн орлого (ҮНЭО):
ҮНЭО-ыг ҮНО болон харьяат, харьяат бусын хооронд хийгдсэн хоёрдогч орлого буюу цэвэр шилжүүлгийн нийлбэрээр тооцно. Шилжүүлэг гэдэг нь эдийн засгийн нэг сектор нөгөө сектортоо ямар нэг хариу төлбөр авахгүйгээр өгч байгаа бараа, үйлчилгээ, санхүүгийн болон санхүүгийн бус хөрөнгө юм. Урсгал шилжүүлэг нь урсгал татвар, нийгмийн даатгалын шимтгэл, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, бусад урсгал шилжүүлгээс бүрдэнэ. Зарцуулах боломжтой орлогыг илэрхийлнэ.

# МӨНГӨ, ЗЭЭЛ

## Мөнгөний нийлүүлэлт өмнөх оны мөн үеэс 14.1 хувиар өсжээ.

Мөнгөний нийлүүлэлт (М2) 2026 оны 1 дүгээр сарын эцэст урьдчилсан гүйцэтгэлээр 46.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 5.8 (14.1%) их наяд төгрөгөөр өсөхөд төгрөгийн хадгаламж 4.3 (20.0%) их наяд төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

**ХҮСНЭГТ 22. МӨНГӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТ**

| Үзүүлэлт | Жил | | | Сар | | | 2026* I / 2025 I | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2023 | 2024 | 2025 | 2024 I | 2025 I | 2026* I | зөрүү | хувь |
| | их наяд төгрөг | | | | | | | |
| Мөнгө М2 | 36.8 | 42.6 | 47.1 | 36.6 | 41.1 | 46.9 | 5.8 | 14.1 |
| Мөнгө М1 | 9.9 | 11.7 | 11.2 | 8.7 | 10.8 | 11.1 | 0.3 | 2.6 |
| Төгрөгийн харилцах | 8.9 | 10.7 | 10.2 | 7.8 | 10.0 | 10.2 | 0.2 | 2.1 |
| Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө | 0.9 | 1.0 | 1.0 | 0.9 | 0.9 | 1.0 | 0.1 | 8.1 |
| Бараг мөнгө | 27.0 | 30.9 | 35.8 | 27.9 | 30.2 | 35.7 | 5.5 | 18.3 |
| Төгрөгийн хадгаламж | 17.1 | 22.0 | 26.0 | 17.1 | 21.6 | 26.0 | 4.3 | 20.0 |
| Валютын хадгаламж | 5.0 | 4.9 | 5.7 | 4.9 | 4.8 | 5.6 | 0.8 | 16.1 |
| Валютын харилцах | 4.9 | 4.0 | 4.1 | 5.8 | 3.7 | 4.2 | 0.4 | 11.4 |
| Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө | 1.2 | 1.2 | 1.2 | 1.2 | 1.1 | 1.2 | 0.1 | 5.1 |

Бага мөнгө (М1) 2026 оны 1 дүгээр сарын эцэст урьдчилсан гүйцэтгэлээр 11.1 их наяд төгрөгт болж, өмнөх оны мөн үеэс 279.5 (2.6%) тэрбум төгрөгөөр өсөж, өмнөх сараас 115.3 (1.0%) тэрбум төгрөгөөр буурчээ.

Бага мөнгө (М1)-ний 10.2 (91.4%) их наяд төгрөг нь төгрөгийн харилцах, 950.4 (8.6%) тэрбум төгрөг нь хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө байна.

Бараг мөнгө 2026 оны 01 дүгээр сарын эцэст урьдчилсан гүйцэтгэлээр 35.7 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 5.5 (18.3%) их наяд төгрөгөөр өсөж, өмнөх сараас 93.2 (0.3%) тэрбум төгрөгөөр буурчээ.

Бараг мөнгөний 26.0 (72.7%) их наяд төгрөг нь төгрөгийн хадгаламж, 5.6 (15.7%) их наяд төгрөг нь валютын хадгаламж, 4.2 (11.6%) их наяд төгрөг нь валютын харилцах байна.

## ЗУРАГ 12. МӨНГӨНИЙ ЖИЛИЙН ӨӨРЧЛӨЛТ







Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 2026 оны 1 дүгээр сарын эцэст урьдчилсан гүйцэтгэлээр 1.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 58.3 (5.1%) тэрбум төгрөгөөр өсөж, өмнөх сараас 47.1 (3.8%) тэрбум төгрөгөөр буурчээ.

Төгрөгийн хадгаламж 2026 оны 1 дүгээр сарын эцэст урьдчилсан гүйцэтгэлээр 26.0 их наяд төгрөг хүрч, өмнөх оны мөн үеэс 4.3 (20.0%) их наяд төгрөгөөр өсөж, өмнөх сараас 52.1 (0.2%) тэрбум төгрөгөөр буурчээ.

Төгрөгийн хадгаламжийн 21.6 (83.0%) их наяд төгрөг нь иргэдийн хадгаламж, 4.4 (17.0%) их наяд төгрөг нь аж ахуйн нэгж, байгууллагын хадгаламж байна.

Валютын хадгаламж 5.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 777.7 (16.1%) тэрбум төгрөгөөр өсөж, өмнөх сараас 123.5 (2.2%) тэрбум төгрөгөөр буурчээ.

## ЗУРАГ 13. ХАДГАЛАМЖ




## ЗУРАГ 14. МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ, байршуулалт талаас




**Гадаад болон дотоод цэвэр актив.** 2026 оны 1 дүгээр сарын эцэст урьдчилсан гүйцэтгэлээр мөнгөний нийлүүлэлтийн 18.8 хувийг гадаад цэвэр актив, 81.2 хувийг дотоод цэвэр актив бүрдүүлж байна.

Гадаад цэвэр актив 2026 оны 1 дүгээр сарын эцэст урьдчилсан гүйцэтгэлээр 8.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 2.1 (31.5%) их наяд төгрөгөөр, өмнөх сараас 125.8 (1.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Дотоод цэвэр актив 38.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 3.7 (10.7%) их наяд төгрөгөөр өсөж, өмнөх сараас 334.4 (0.9%) тэрбум төгрөгөөр буурчээ.

## ЗУРАГ 15. ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЛИЙН ЖИЛИЙН ӨӨРЧЛӨЛТ, төрлөөр







Нийт зээлийн үлдэгдэл 2026 оны 1 дүгээр сарын эцэст 44.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 6.8 (18.2%) их наяд төгрөгөөр, өмнөх сараас 156.6 (0.4%) тэрбум төгрөгөөр өсжээ.

Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 60.1 хувь нь иргэд, 38.7 хувь нь хувийн байгууллага, 0.4 хувь нь төрийн байгууллага, 0.7 хувь нь санхүүгийн байгууллага болон бусад байна.

## ЗУРАГ 16. ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЭЛ, салбараар







Хэвийн зээлийн өрийн үлдэгдэл 2026 оны 1 дүгээр сарын эцэст 40.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 6.2 (18.3%) их наяд төгрөгөөр, өмнөх сараас 80.9 (0.2%) тэрбум төгрөгөөр өсжээ. Хэвийн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 91.5 хувийг эзэлж байна.

Анхаарал хандуулах зээлийн өрийн үлдэгдэл 2026 оны 1 дүгээр сарын эцэст 1.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 210.0 (16.0%) тэрбум төгрөгөөр, өмнөх сараас 13.3 (0.9%) тэрбум төгрөгөөр өсжээ. Анхаарал хандуулах зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 3.4 хувийг эзэлж байна.

Чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 2026 оны 1 дүгээр сарын эцэст 2.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 356.6 (18.5%) тэрбум төгрөгөөр, өмнөх сараас 62.4 (2.8%) тэрбум төгрөгөөр өсжээ. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 5.1 хувийг эзэлж байна.

Арилжааны банкнууд болон Монголын Ипотекийн корпорацаас иргэдэд олгосон ипотекийн зээлийн үлдэгдэл 2025 оны 12 дугаар сарын эцэст 11.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 2.0 (21.7%) их наяд төгрөгөөр, өмнөх сараас 250.0 (2.2%) тэрбум төгрөгөөр өсжээ. Ипотекийн зээлийн үлдэгдлийн 97.8 (11.2 их наяд төгрөг) хувийг хэвийн зээл, 1.4 (158.6 тэрбум төгрөг) хувийг анхаарал хандуулах зээл, 0.8 (95.6 тэрбум төгрөг) хувийг чанаргүй зээл эзэлж байна.

## ЗУРАГ 17. ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙН ЖИЛИЙН ӨӨРЧЛӨЛТ, төрлөөр




Монголбанкнаас зарласан төгрөгийн америк доллартой харьцах сарын дундаж ханш 2026 оны 1 дүгээр сард 3561.03 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 129.3 төгрөгөөр, өмнөх сараас 11.8 төгрөгөөр суларсан байна.

Төгрөгийн евротой харьцах сарын дундаж ханш 2026 оны 1 дүгээр сард 4179.53 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 627.4 төгрөгөөр, өмнөх сараас 24.5 төгрөгөөр суларсан байна.

Төгрөгийн рубльтэй харьцах сарын дундаж ханш 2026 оны 1 дүгээр сард 45.64 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 12.0 төгрөгөөр, өмнөх сараас 0.4 төгрөгөөр суларсан байна.

Төгрөгийн юаньтай харьцах сарын дундаж ханш 2026 оны 1 дүгээр сард 511.00 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 41.0 төгрөгөөр, өмнөх сараас 7.1 төгрөгөөр суларсан байна.

## ЗУРАГ 18. ТӨГРӨГИЙН ГАДААД ВАЛЮТТАЙ ХАРЬЦАХ ХАНШ, жилийн өөрчлөлт



Ойлголт, тодорхойлолт:

Бага мөнгө (М1):
Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө болон төгрөгийн харилцах дансан дахь мөнгөний нийлбэрээр тодорхойлно.

Мөнгөний нийлүүлэлт /М2/:
Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө, төгрөгийн болон валютын харилцах, хадгаламж, цэвэршүүлсэн алтны харилцах, хадгаламжийн сертификатын нийлбэрээр тодорхойлно. Өөрөөр хэлбэл, бага мөнгө болон бараг мөнгөний нийлбэрээр тодорхойлно. Зөвхөн цэвэршүүлсэн алтны харилцах дансны үлдэгдлийг хамруулах бөгөөд бусад үнэт металлын харилцах дансны үлдэгдлийг хамруулахгүй.

Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө:
Төв банкнаас гүйлгээнд гаргасан цаасан болон зоосон мөнгөнөөс банкнуудын эзэмшиж буй цаасан болон зоосон мөнгийг хасна.

Бараг мөнгө:
Төгрөгийн болон гадаад валютын хадгаламж, валютын харилцах, цэвэршүүлсэн алтны харилцах, хадгаламжийн сертификатын нийлбэрээр тодорхойлно.

Валютын харилцах:
Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын валютын харилцах дансны үлдэгдлийн нийлбэрээр тодорхойлно.

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө:
Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө болон банкны касс дахь бэлэн мөнгөний нийлбэрээр тооцно.

Төгрөг болон валютын хадгаламж:
Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төгрөг, валютын хадгаламжийн үлдэгдлийн нийлбэрээр тодорхойлно.

Хэвийн зээл:
Төлөвлөгдсөн хугацаанд байгаа зээл, түүний хүүг ойлгоно.

Хугацаа хэтэрсэн зээл:
Зээл, хүүгийн хугацаа 90 хүртэл хоног хэтэрсэн зээлийг хамруулна.

Чанаргүй зээл:
Хэвийн бус, эргэлзээтэй, муу зээл буюу зээл, хүүгийн хугацаа 91-ээс дээш хоног хэтэрсэн зээлийг хамруулна.

# ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ

## Үнэт цаасны гүйлгээ өмнөх оны мөн үеэс 61.5 тэрбум төгрөгөөр өсжээ.

Үнэт цаасны зах зээлийн арилжаагаар 2026 оны 1 дүгээр сард 133.7 тэрбум төгрөгийн гүйлгээ хийж, өмнөх оны мөн үеэс 61.5 (85.2%) тэрбум төгрөгөөр өсжээ.

Үнэт цаасны нийт гүйлгээний 65.3 (87.4 тэрбум төгрөг) хувь нь анхдагч зах зээлийн гүйлгээ, 34.7 (46.4 тэрбум төгрөг) хувь нь хоёрдогч зах зээлийн гүйлгээ байна.

Үнэт цаасны гүйлгээний 55.3 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, 16.0 хувийг компанийн хувьцаа, 15.9 хувийг Засгийн газрын бонд, 12.7 хувийг компанийн бонд, 0.1 хувийг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх тус тус эзэлж байна.

### ХҮСНЭГТ 23. ҮНЭТ ЦААСНЫ ГҮЙЛГЭЭ

| Үзүүлэлт | Жил | | | Сар | | | 2026 I / 2025 I | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2023 | 2024 | 2025 | 2024 I | 2025 I | 2026 I | | |
| | тэрбум төгрөг | | | | | | зөрүү | хувь |
| Үнэт цаасны гүйлгээ | 725.9 | 1 478.5 | 1 133.3 | 70.8 | 72.2 | 133.7 | 61.5 | 85.2 |
| Анхдагч зах зээл | 486.8 | 890.5 | 474.2 | 15.0 | 23.7 | 87.4 | 63.7 | 3.7** |
| Хоёрдогч зах зээл | 239.1 | 587.9 | 659.0 | 55.8 | 48.5 | 46.4 | -2.2 | -4.5 |

Арилжсан үнэт цаас 2026 оны 1 сард  48.3 сая ширхэг болж, өмнөх оны мөн үеэс 19.2 (28.4%) сая ширхгээр буурчээ.

Нийт арилжсан үнэт цаасны 1.8 (880 мянган ширхэг) хувь нь анхдагч зах зээлд арилжигдсан, 98.2 (47.4 сая ширхэг) хувь нь хоёрдогч зах зээлд арилжигдсан байна.

### ХҮСНЭГТ 24. АРИЛЖСАН ҮНЭТ ЦААС

| Үзүүлэлт | Жил | | | Сар | | | 2026 I / 2025 I | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2023 | 2024 | 2025 | 2024 I | 2025 I | 2026 I | | |
| | сая ширхэг | | | | | | зөрүү | хувь |
| Арилжсан үнэт цаас | 725.9 | 1 478.5 | 1 133.3 | 42.0 | 67.5 | 48.3 | -19.2 | -28.4 |
| Анхдагч зах зээл | 486.8 | 890.5 | 474.2 | 0.2 | 0.1 | 0.9 | 0.7 | 6.3** |
| Хоёрдогч зах зээл | 239.1 | 587.9 | 659.0 | 41.8 | 67.3 | 47.4 | -19.9 | -29.6 |

ТОП-20 дундаж индекс 2026 оны 1 дүгээр сард 54871.4 нэгж болж, өмнөх оны мөн үеэс 3110.2 нэгжээр, өмнөх сараас 2209 нэгжээр тус тус өссөн байна.

Хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа хувьцаат компаниудын үнэт цаасны зах зээлийн нийт үнэлгээ 2026 оны 1 дүгээр сард 14.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 986.8 (7.4%) тэрбум төгрөгөөр, өмнөх сараас 364.0 (2.6%) тэрбум төгрөгөөр өсжээ.

Зах зээлийн нийт үнэлгээний 99.9 (14.2 их наяд төгрөг) хувийг Монголын хөрөнгийн бирж, 0.1 (18.7 тэрбум төгрөг) хувийг Улаанбаатар хөрөнгийн бирж тус тус эзэлж байна.

**ЗУРАГ 19.** **ТОП-20 ДУНДАЖ ИНДЕКС**




**ЗУРАГ 20.** **ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ**




## Ойлголт, тодорхойлолт:

**Үнэт цаас:**
Засгийн газар болон бусад эрх бүхий этгээдээс гаргасан өрийн бичиг /бонд/, компанийн бүх төрлийн хувьцаа, компанийн гаргасан, эсвэл гаргахаар санал болгож буй хувьцааг худалдах, худалдан авах эрхийн бичиг (опцион), хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа, түүнчлэн Санхүүгийн зохицуулах хорооноос "Үнэт цаасны зах зээлийн тухай" Монгол Улсын хуульд нийцүүлэн үнэт цаас гэж тодорхойлсон баримтыг ойлгоно.

**Хувьцаа:**
Компанид хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож санал өгөх, ногдол ашиг авах, компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдан борлуулснаас олсон орлогоос хувь хүртэх болон хуулиар тогтоосон бусад эрхийг гэрчилсэн үнэт цаасыг ойлгоно.

**Брокерын үйл ажиллагаа:**
Үнэт цаасны зах зээлд бусдын нэрийн өмнөөс үнэт цаасыг зуучлан худалдах, худалдан авах ажиллагааг ойлгоно.

**Дилерийн үйл ажиллагаа:**
Үнэт цаасны зах зээлд ашиг олох зорилгоор үнэт цаасыг өөрийн хөрөнгөөр худалдан авах, худалдах, арилжих ажиллагааг ойлгоно.

**Бүртгэлтэй компани:**
Монголын Хөрөнгийн биржид бүртгэлтэй, хувьцааны арилжааг идэвхтэй хийдэг хувьцаат компанийг тоог хамруулна.

**Хэлцэл:**
Үнэт цаасыг худалдах захиалгын үнийн саналыг худалдан авах иргэд, аж ахуйн нэгж, байгууллага зөвшөөрснөөр үнэт цаас арилжаалахыг ойлгоно.

**Зах зээлийн үнэлгээ:**
Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компанийн нийтэд гаргасан үнэт цаасны тоо, тухайн өдрийн үнэт цаасны арилжааны хаалтын ханшны үржвэрээр тодорхойлно.

**Өрийн бичиг (бонд):**
Тодорхой хугацааны дараа үндсэн төлбөр болон хүүг мөнгөн, эсвэл тодорхой эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн хэлбэрээр эргүүлэн төлөх үүргийг гэрчилсэн үнэт цаасыг ойлгоно.

**ТОП 20 индекс:**
Үнэт цаасны үнийн ерөнхий өөрчлөлтийг илэрхийлэх бөгөөд Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниудын үнэт цаасны зах зээлийн үнэлгээ, үнэт цаасны өсөлт, бууралтаар үнэт цаасны зах зээлийн ерөнхий чиг хандлагыг тодорхойлно.

**Тооцох аргачлал:**
ТОП 20 индексийг дараах томьёогоор тооцно.

$$I = \frac{P}{C} * 100$$

I - Тухайн өдрийн индекс
P - Тухайн өдрийн зах зээлийн үнэлгээ
C - Зах зээлийн суурь үнэлгээ

# ДААТГАЛ

## Даатгалын хураамжийн орлого 2025 онд өмнөх оноос 74.0 (14.5%) тэрбум төгрөгөөр өсжээ

Даатгалын хураамжийн орлого 2025 онд 584.6 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 74.0 (14.5%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Мөн даатгалын нөхөн төлбөрт 193.7 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оноос 33.3 (20.8) тэрбум төгрөгөөр өссөн байна. Даатгалын хураамжийн орлогын 88.2 хувийг сайн дурын даатгал, 10.3 хувийг албан журмын даатгал, 1.5 хувийг урт хугацааны буюу амьдралын даатгал эзэлж байгаа бол нөхөн төлбөрийн 72.9 хувийг сайн дурын даатгал, 24.7 хувийг албан журмын даатгал, 2.4 хувийг урт хугацааны буюу амьдралын даатгал тус тус эзэлж байна.

Даатгалын хураамжийн орлого 2025 оны 4 дүгээр улиралд 122.3 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 12.1 (11.0%) тэрбум төгрөгөөр өсөж, өмнөх улирлаас 94.5 (43.6%) тэрбум төгрөгөөр буурчээ. Даатгалын нөхөн төлбөрт 2025 оны 4 дүгээр улиралд 46.4 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 792.4 (1.7) сая төгрөгөөр, өмнөх улирлаас 12.6 (21.3%) тэрбум төгрөгөөр буурчээ.

**ХҮСНЭГТ 25. ДААТГАЛЫН ҮЗҮҮЛЭЛТ**

| Үзүүлэлт | Жил | | | | 2025*/2024 | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2022 | 2023 | 2024 | 2025* | зөрүү | хувь |
| | сая төгрөг | | | | | |
| Хураамжийн орлого | 300 716.6 | 392 007.7 | 510 551.7 | 584 557.3 | 74 005.5 | 14.5 |
| Нөхөн төлбөр | 94 239.0 | 120 872.2 | 160 383.9 | 193 679.0 | 33 295.1 | 20.8 |
| Даатгуулагчид, мянган нэгж | 1 343.9 | 1 546.3 | 1 604.3 | 1 815.7 | 211.4 | 13.2 |
| Хувь хүн, мянган хүн | 1 107.3 | 1 279.7 | 1 279.6 | 1 477.7 | 198.1 | 15.5 |

**ЗУРАГ 21. ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО, НӨХӨН ТӨЛБӨР**







Даатгалын хураамжийн орлого 2025 онд өмнөх оноос 74.0 (14.5%) тэрбум төгрөгөөр өсөхөд гэнэтийн осол, эмчилгээний даатгалын хураамжийн орлого 26.7 (35.3%) тэрбум төгрөгөөр, хөрөнгийн даатгалын хураамжийн орлого 17.7 (13.8%) тэрбум төгрөгөөр, авто тээврийн хэрэгслийн даатгалын хураамжийн орлого 4.7 (3.5%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ. Харин жолоочийн хариуцлагын даатгалын хураамжийн орлого 10.1 (18.3) тэрбум төгрөгөөр, агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгалын хураамжийн орлого 1.4 (14.5%) тэрбум төгрөгөөр, агаарын хөлгийн даатгалын хураамжийн орлого 529.7 (2.4%) сая төгрөгөөр буурсан байна.

Даатгалын хураамжийн нийт орлогын 25.1 хувийг хөрөнгийн даатгал, 23.8 хувийг авто тээврийн хэрэгслийн даатгал, 17.5 хувийг гэнэтийн осол, эмчилгээ даатгал, эзэлж байна.

Даатгалын нөхөн төлбөр 2025 онд өмнөх оноос 33.3 (20.8%) тэрбум төгрөгөөр өсөхөд гэнэтийн осол, эмчилгээний даатгалын нөхөн төлбөр 18.6 (69.3%) тэрбум төгрөгөөр, барилга угсралтын даатгалын нөхөн төлбөр 18.3 (200.0 дахин их) тэрбум төгрөгөөр, агаарын хөлгийн даатгалын нөхөн төлбөр 7.2 (2.4%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ. Харин мал амьтадын даатгалын нөхөн төлбөр 13.1 (99.2%) тэрбум төгрөгөөр, хөрөнгийн даатгалын нөхөн төлбөр 6.4 (43.1%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Даатгалын нийт нөхөн төлбөрийн 25.7 хувийг авто тээврийн хэрэгслийн даатгал, 24.7 хувийг жолоочийн хариуцлагын даатгал, 23.4 хувийг гэнэтийн осол, эмчилгээний даатгал эзэлж байна.

Даатгуулагчдын тоо 2025 онд 1.8 сая болж, өмнөх оноос 211.4 (1.1%) мянгаар өсжээ. Даатгуулагчдын 81.4 хувь нь иргэн, 18.6 хувь нь хуулийн этгээд буюу аж ахуйн нэгж, байгууллага байна. Нийт даатгуулагчдын 48.2 хувийг албан журмын даатгал, 46.5 хувийг сайн дурын даатгал, 5.3 хувийг урт хугацааны буюу амьдралын даатгал эзэлж байна.

<u>Ойлголт, тодорхойлолт:</u>

<u>Даатгалын нөхөн төлбөр:</u>
Гэрээний дагуу даатгалын тохиолдол үүссэн нөхцөлд даатгагчаас даатгуулагчид олгох мөнгөн хөрөнгө юм.

<u>Даатгалын үйл ажиллагаа:</u>
Даатгалын гэрээний дагуу даатгагч нь хэлэлцэн тохирсон даатгалын нөхөн төлбөрийг төлөх үүргийг тодорхой этгээдийн өмнө хүлээж буй үйл ажиллагаа юм.

<u>Даатгалын хураамж:</u>
Даатгуулагч даатгалын зүйлээ даатгуулсны төлөө даатгагчид төлөх төлбөрийг ойлгоно.

# УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ

## Төсвийн тэнцвэржүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс 2.2 хувиар өслөө.

Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2026 оны 1 дүгээр сарын урьдчилсан гүйцэтгэлээр 1.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 78.2 (4.5%) тэрбум төгрөг, тэнцвэржүүлсэн орлого тусламжийн хэмжээ 1.7 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 37.4 (2.2%) тэрбум төгрөгөөр тус тус өсжээ.

**ХҮСНЭГТ 26.** **УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, ТЭНЦЭЛ**

| Үзүүлэлт | Жил | | | Сар | | | 2026* I / 2025 I | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2023 | 2024 | 2025 | 2024 I | 2025 I | 2026* I | | |
| | тэрбум төгрөг | | | | | | зөрүү | хувь |
| Нийт орлого | 24 387.1 | 31 456.6 | 32 645.9 | 2 764.1 | 1 749.3 | 1 827.6 | 78.2 | 4.5 |
| Тэнцвэржүүлсэн орлого | 23 294.9 | 29 670.8 | 30 057.7 | 2 730.5 | 1 668.2 | 1 705.5 | 37.4 | 2.2 |
| Зарлага, цэвэр зээл | 22 509.0 | 30 591.1 | 31 289.2 | 2 054.5 | 2 160.9 | 2 130.6 | - 30.3 | -1.4 |
| **Тэнцэл** | 785.9 | - 920.2 | - 1 231.5 | 676.0 | - 492.7 | - 425.1 | 67.6 | - 13.7 |

Нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2026 оны 1 дүгээр сард 2.1 их наяд төгрөг болж, тэнцвэржүүлсэн тэнцэл 425.1 тэрбум төгрөгийн алдагдалтай гарчээ.

**ЗУРАГ 22.** **УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО, ЗАРЛАГА, ТЭНЦЭЛ**




*Урьдчилсан гүйцэтгэл

Татварын нийт орлого 2026 оны 1 дүгээр сард 1.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 135.8 (9.3%) тэрбум төгрөгөөр өсөхөд нийгмийн даатгалын орлого 54.2 (16.5%) тэрбум төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвар 173.3 (58.5%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

Харин онцгой албан татварын орлого 56.9 (50.3%) тэрбум төгрөг, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 68.6 (71.8%) тэрбум төгрөг, гадаад үйл ажиллагааны орлого 4.9 (3.4%) тэрбум төгрөгөөр тус тус буурчээ.

## ХҮСНЭГТ 27. УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО

| Үзүүлэлт | Жил | | | Сар | | | 2026* I / 2025 I | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2023 | 2024 | 2025 | 2024 I | 2025 I | 2026*I | | |
| | тэрбум төгрөг | | | | | | зөрүү | хувь |
| **Тэнцвэржүүлсэн орлого** | 23 294.9 | 29 670.8 | 30 057.7 | 2 730.5 | 1 668.2 | 1 705.5 | 37.4 | 2.2 |
| **Татварын орлого** | 21 484.2 | 27 417.4 | 27 085.9 | 2 601.2 | 1 457.3 | 1 593.1 | 135.8 | 9.3 |
| Орлогын албан татвар | 5 702.6 | 8 970.6 | 8 539.1 | 767.6 | 409.6 | 419.3 | 9.7 | 2.4 |
| НД-ын орлого | 3 950.8 | 4 731.8 | 5 624.1 | 263.3 | 328.4 | 382.6 | 54.2 | 16.5 |
| НӨАТ | 4 777.0 | 5 866.8 | 6 224.3 | 448.1 | 296.3 | 469.6 | 173.3 | 58.5 |
| Онцгой | 790.1 | 1 107.4 | 955.1 | 119.2 | 113.2 | 56.3 | - 56.9 | - 50.3 |
| Гадаад үйл ажиллагааны | 1 465.3 | 1 792.3 | 1 849.4 | 133.9 | 143.7 | 138.9 | - 4.9 | - 3.4 |
| Бусад | 4 798.3 | 4 948.5 | 3 893.8 | 869.1 | 166.1 | 126.4 | - 39.7 | - 23.9 |
| **Татварын бус орлого** | 1 810.7 | 2 253.5 | 2 971.8 | 129.3 | 210.9 | 112.5 | - 98.4 | - 46.7 |

2026 оны 1 дүгээр сард татварын нийт орлогын 26.3 хувийг орлогын албан татвар, 29.5 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 24.0 хувийг нийгмийн даатгалын орлого, 8.7 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 3.5 хувийг онцгой албан татварын орлого, 7.9 хувийг бусад төрлийн татвар, төлбөр, хураамжийн орлого тус тус бүрдүүлж байна.

Орлогын албан татварын 59.7 хувийг ААНОАТ, 40.3 хувь (буцаан олголтыг оруулсан дүнгээр)-ийг ХХОАТ-ын орлого бүрдүүлж байна.

## ЗУРАГ 23. УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ТАТВАРЫН ОРЛОГЫН БҮТЭЦ, хувиар, 2026 оны 1 дүгээр сарын эцэст




*ХАОАТ-ын буцаан олголт орсон дүн

Улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2026 оны 1 дүгээр сард 2.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 30.3 (1.4%) тэрбум төгрөгөөр буурчээ.

Зарлага буурахад хүүний зардал өмнөх оны мөн үеэс 87.8 (40.3%) тэрбум төгрөгөөр, засгийн газрын урсгал шилжүүлэг 96.6 (33.5%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Харин бараа үйлчилгээний зардал 81.9 (13.1%) тэрбум төгрөг, бусад урсгал шилжүүлэг 120.6 (17.5%) тэрбум төгрөгөөр өсжээ.

2026 оны 1 дүгээр сард нийт зардалд урсгал шилжүүлэг 46.8 хувь, бараа үйлчилгээний зардал 33.2 хувь, хөрөнгийн зардал 12.1 хувь, хүүгийн зардал 6.1 хувь, татаас 1.8 хувийг эзэлж байна.

**ЗУРАГ 24.** **УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ЗАРДЛЫН БҮТЭЦ, голлох зардлуудаар, жил бүрийн 1 дүгээр сард, дүнд эзлэх хувиар**




Хөрөнгийн зардал 2026 оны 1 дүгээр сард 257.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 38.3 (12.9%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Үүнд, барилга байгууламжийн зардал 48.3 (17.9%) тэрбум төгрөгөөр, тоног төхөөрөмжийн зардал 3.5 (27.8%) тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлжээ.

Харин их засварын зардал 8.0 (18.3 дахин) тэрбум төгрөг, бусад хөрөнгийн зардал 5.0 (36.3%) тэрбум төгрөгөөр өсжээ.

## ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

Орон нутгийн төсвийн орлого 2026 оны 1 дүгээр сард 432.4 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 19.8 (4.4%) тэрбум төгрөгөөр, нийт зарлага, цэвэр зээлийн хэмжээ 279.1 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 249.4 (47.2%) тэрбум төгрөгөөр тус тус буурчээ. Орон нутгийн төсөв 153.2 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.

**ЗУРАГ 25.** **ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, 2026 оны 1 дүгээр сарын эцэст, бүс, аймаг, нийслэлээр**



## НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН

Нийгмийн даатгалын сангийн нийт орлого 2026 оны 1 дүгээр сард 585.7 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 55.8 (10.5%) тэрбум төгрөгөөр, нийт зарлага 598.0 тэрбум төгрөг болж, 115.3 (23.9%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

### ХҮСНЭГТ 28. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА

| Үзүүлэлт | Жил | | | Сар | | | 2026* I<br>2025 I | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2023 | 2024 | 2025 | 2024 I | 2025 I | 2026*I | | |
| | тэрбум төгрөг | | | | | | зөрүү | хувь |
| **Нийт орлого** | **4 271.6** | **5 609.7** | **6 685.4** | **405.1** | **530.0** | **585.7** | **55.8** | **10.5** |
| Нийгмийн даатгалын орлого | 3 507.3 | 4 434.7 | 5 232.9 | 269.6 | 330.3 | 386.0 | 55.7 | 16.9 |
| Тусламжийн орлого | 764.4 | 1 175.0 | 1 452.5 | 135.5 | 199.7 | 199.8 | 0.1 | 0.0 |
| **Нийт зарлага** | **4 035.0** | **5 104.7** | **5 846.8** | **368.6** | **482.7** | **598.0** | **115.3** | **23.9** |
| Бараа үйлчилгээний зарлага[1] | 42.1 | 0.8 | 0.6 | - | - | - | - | -19.5 |
| Урсгал шилжүүлэг | 3 994.0 | 5 106.4 | 5 847.8 | 368.8 | 482.7 | 598.0 | 115.3 | 23.9 |
| Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл | - 1.2 | - 2.5 | - 1.6 | - 0.2 | - | - | - | - |
| **Тэнцэл** | **236.6** | **505.0** | **838.6** | **36.6** | **47.3** | **- 12.2** | **-59.6** | **-** |

[1] Төсвийн тухай хуулийн дагуу 2024 оноос бараа, үйлчилгээний зардал (бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжаас бусад) -ыг ГБХНХЯ-ны төсөвт шилжүүлсэн болно.

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САН

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 2026 оны 1 дүгээр сард 176.2 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 27.5 (13.5%) тэрбум төгрөгөөр, нийт зарлага 172.5 тэрбум төгрөг болж, 103.9 (37.6%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Нийт зардал буурахад урсгал шилжүүлгийн зардал өмнөх оны мөн үеэс 104.1 (37.7%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн байна.

### ХҮСНЭГТ 29. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА

| Үзүүлэлт | Жил | | | Сар | | | 2026* I<br>2025 I | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2023 | 2024 | 2025 | 2024 I | 2025 I | 2026*I | | |
| | тэрбум төгрөг | | | | | | зөрүү | хувь |
| **Нийт орлого** | **1 586.8** | **1 921.7** | **2 299.5** | **106.1** | **203.7** | **176.2** | **-27.5** | **-13.5** |
| ЭМД-ын хураамжийн шимтгэл | 1 586.8 | 1 921.7 | 2 299.5 | 106.1 | 203.7 | 176.2 | -27.5 | -13.5 |
| **Нийт зарлага** | **1 598.0** | **1 926.9** | **2 238.3** | **204.5** | **276.4** | **172.5** | **-103.9** | **-37.6** |
| Бараа үйлчилгээний зарлага | 50.0 | 68.3 | 12.7 | 2.4 | 0.7 | 0.7 | - | 6.9 |
| Татаас | 90.0 | - | - | - | - | - | - | - |
| Урсгал шилжүүлэг | 1 462.8 | 1 863.0 | 2 229.0 | 202.3 | 275.9 | 171.8 | -104.1 | -37.7 |
| Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл | -4.8 | -4.4 | -3.4 | -0.2 | -0.1 | - | 0.1 | - |
| **Тэнцэл** | **-11.2** | **-5.2** | **61.3** | **- 98.4** | **- 72.8** | **3.7** | **76.4** | **-** |

Ойлголт, тодорхойлолт:

Монгол Улсын нэгдсэн төсөв:
Улсын төсөв, орон нутгийн төсөв, Үндэсний баялгийн сан, эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, нийгмийн даатгалын сангийн төсвөөс бүрдэнэ.

Тэнцвэржүүлсэн орлого:
Татварын болон татварын бус орлогоос бүрдэнэ.

Орон нутгийн төсөв:
Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга бүрдүүлж, зарцуулах төсөв юм.

Татварын орлого:
Орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого, хөрөнгийн албан татвар, нэмэгдэл өртгийн албан татвар, онцгой албан татвар, тусгай зориулалтын орлого, гадаад үйл ажиллагааны орлого, бусад татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ.

Татварын бус орлого:
Нийтлэг татварын бус орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлого, улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгээс бүрдэнэ.

Төсвийн зарлагын ангилал:
Урсгал зардал, хөрөнгийн зардал, эргэн төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл гэж ангилна.

Төсвийн орлого:
Тогтворжуулалтын сан, ирээдүйн өв сан, хуримтлалын сан болон тэнцвэржүүлсэн орлогоос бүрдэнэ.

Улсын төсөв:
Улсын Их Хурлаас батлан Засгийн газар бүрдүүлж зарцуулах төсөв юм.

Урсгал зардал:
Бараа, ажил, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс бүрдэнэ.

Тэнцвэржүүлсэн тэнцэл:
Тэнцвэржүүлсэн орлогоос нийт зарлага, цэвэр зээлийг хасаж тодорхойлно.

# ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

## Төлбөрийн тэнцэл 2025 онд 1.0 тэрбум ам.долларын ашигтай гарлаа.

Төлбөрийн тэнцлийн урсгал данс 2025 онд 1.1 тэрбум ам.долларын алдагдалтай гарч, алдагдал өмнөх оноос 1.3 (54.2%) тэрбум ам.доллароор буурчээ.

Урсгал дансны алдагдал өмнөх оноос буурахад барааны худалдааны ашиг 1.1 (36.1%) тэрбум ам.доллароор нэмэгдэж, үйлчилгээний худалдааны тэнцлийн алдагдал 469.5 (14.2%) сая ам.доллароор буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Харин анхдагч орлогын дансны алдагдал өмнөх оноос 169.2 (6.3%) сая ам.доллароор өсөж, хоёрдогч орлогын дансны ашиг 64.5 (15.3%) сая ам.доллароор буурчээ.

**ХҮСНЭГТ 30.** **ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ**

| Үзүүлэлт | 2023 | 2024 | 2025* | 2025* / 2024 | |
|---|---|---|---|---|---|
| | сая ам.доллар | | | зөрүү | хувь |
| Урсгал данс | 121.3 | -2 485.4 | -1 137.4 | 1 348.1 | - 54.2 |
| Хөрөнгийн данс | 134.9 | 171.4 | 133.3 | - 38.0 | - 22.2 |
| Санхүүгийн данс | -1 476.6 | -3 329.6 | -1 682.1 | 1 647.4 | - 49.5 |
| Алдаа болон орхигдуулга | - 275.7 | - 393.2 | 356.2 | 749.4 | - |
| Нөөц хөрөнгө | 1 457.0 | 622.3 | 1 034.3 | 412.0 | 66.2 |

**ЗУРАГ 26.** **ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН БҮТЭЦ, сая ам.доллар**




Үйлчилгээний худалдааны орлого 2025 онд 2.0 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оноос 402.6 (25.1%) сая ам.доллароор өссөн байна.

Үйлчилгээний орлого өсөхөд тээврийн үйлчилгээний орлого 180.4 (29.7%) сая ам.доллароор, аяллын орлого 93.0 (14.6%) сая ам.доллароор, бусад үйлчилгээний орлого 129.2 (35.7%) сая ам доллароор тус тус өссөн нь голлон нөлөөлжээ. Үйлчилгээний орлогын 39.2 хувийг тээврийн үйлчилгээ, 36.3 хувийг аялал жуулчлалын үйлчилгээ, 24.5 хувийг бусад үйлчилгээний орлого тус тус эзэлж байна.

## ХҮСНЭГТ 31. УРСГАЛ БА ХӨРӨНГИЙН ДАНС

| Үзүүлэлт | 2023 | 2024 | 2025* | 2025* / 2024 | |
|---|---|---|---|---|---|
| | сая ам.доллар | | | зөрүү | хувь |
| **1.Урсгал данс** | **121.3** | **-2 485.4** | **-1 137.4** | **1 348.1** | **- 54.2** |
| Бараа | 4 548.7 | 3 081.5 | 4 193.7 | 1 112.3 | 36.1 |
| Экспорт | 13 914.3 | 14 749.9 | 15 224.8 | 474.9 | 3.2 |
| Импорт | 9 365.6 | 11 668.4 | 11 031.1 | - 637.4 | - 5.5 |
| Үйлчилгээ | -2 592.3 | -3 317.2 | -2 847.7 | 469.5 | - 14.2 |
| Экспорт | 1 587.0 | 1 604.3 | 2 006.9 | 402.6 | 25.1 |
| Импорт | 4 179.2 | 4 921.5 | 4 854.6 | - 66.9 | - 1.4 |
| Тээвэр | - 739.7 | - 800.9 | - 504.2 | 296.6 | - 37.0 |
| Экспорт | 673.9 | 606.6 | 787.0 | 180.4 | 29.7 |
| Импорт | 1 413.6 | 1 407.5 | 1 291.3 | - 116.2 | - 8.3 |
| Аялал | - 734.0 | - 954.5 | -1 004.2 | - 49.7 | 5.2 |
| Экспорт | 530.7 | 635.4 | 728.4 | 93.0 | 14.6 |
| Импорт | 1 264.7 | 1 589.9 | 1 732.6 | 142.7 | 9.0 |
| Бусад үйлчилгээ | -1 118.6 | -1 561.9 | -1 339.3 | 222.5 | - 14.2 |
| Экспорт | 382.4 | 362.3 | 491.5 | 129.2 | 35.7 |
| Импорт | 1 501.0 | 1 924.2 | 1 830.8 | - 93.4 | - 4.9 |
| Анхдагч орлого | -2 232.8 | -2 670.8 | -2 839.9 | - 169.2 | 6.3 |
| Экспорт | 454.5 | 558.9 | 544.0 | - 14.9 | - 2.7 |
| Импорт | 2 687.3 | 3 229.6 | 3 383.9 | 154.2 | 4.8 |
| Хоёрдогч орлого | 397.6 | 421.1 | 356.6 | - 64.5 | - 15.3 |
| Экспорт | 472.1 | 562.6 | 542.5 | - 20.1 | - 3.6 |
| Импорт | 74.5 | 141.5 | 185.9 | 44.3 | 31.3 |
| **2. Хөрөнгийн данс** | **134.9** | **171.4** | **133.3** | **- 38.0** | **- 22.2** |

Үйлчилгээний зардал 4.9 тэрбум ам.доллар болж, өмнөх оноос 66.9 (1.4%) сая ам.доллароор буурчээ.

Үйлчилгээний зардал буурахад тээврийн зардал 116.2 (8.3%) сая ам доллароор буурсан нь голлон нөлөөлсөн байна. Харин аяллын зардал 142.7 (9.0%) сая ам доллароор өссөн байна.

Үйлчилгээний зардлын 35.7 хувийг аяллын үйлчилгээ, 26.6 хувийг тээврийн үйлчилгээ, 37.7 хувийг бусад үйлчилгээний зардал тус тус эзэлж байна.

Анхдагч орлогын данс 2.8 тэрбум ам.долларын алдагдалтай гарч, өмнөх оноос алдагдал 169.2 (6.3%) сая ам доллароор өсжээ.

Үүнд, Багцын хөрөнгө оруулалтын урт хугацаат зээлийн хүүгийн төлбөр өмнөх оноос 143.8 (54.1%) сая ам.доллараар, шууд хөрөнгө оруулагчийн хувь нийлүүлсэн хөрөнгөд ногдох төлбөр 40.8 (1.8%) сая ам.доллароор өссөн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Харин санхүүгийн зуучлалын үйлчилгээний төлбөр (FIMIS) 62.0 (8.9%) сая ам.доллароор буурсан байна.

**ЗУРАГ 27. УРСГАЛ ДАНС, сая ам.доллар**




Хөрөнгийн данс 2025 онд 133.3 сая ам.долларын ашигтай гарсан хэдий ч, өмнөх оноос ашиг 38.0 (22.2%) сая ам.доллароор буурчээ.

**ХҮСНЭГТ 32. САНХҮҮГИЙН ДАНС**

| Үзүүлэлт | 2023 | 2024 | 2025 | 2025*/2024 | |
|---|---|---|---|---|---|
| | сая ам.доллар | | | зөрүү | хувь |
| **Санхүүгийн данс** | **-1 476.6** | **-3 329.6** | **-1 682.1** | **1 647.4** | **- 49.5** |
| ГШХО | -2 171.6 | -2 726.7 | -1 995.2 | 731.5 | - 26.8 |
| Актив | 75.9 | 55.5 | 15.0 | - 40.5 | - 73.0 |
| Пассив | 2 247.6 | 2 782.2 | 2 010.2 | - 772.0 | - 27.7 |
| Багцын хөрөнгө оруулалт | 817.9 | -1 104.7 | - 841.0 | 263.6 | - 23.9 |
| Актив | 21.2 | 69.9 | 83.0 | 13.1 | 18.7 |
| Пассив | - 796.6 | 1 174.6 | 924.1 | - 250.5 | - 21.3 |
| Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд | - 2.2 | - 12.8 | 7.2 | 20.1 | - |
| Актив | - 2.8 | 4.4 | 2.4 | - 2.0 | - 45.1 |
| Пассив | - 0.6 | 17.3 | - 4.8 | - 22.1 | - |
| Бусад хөрөнгө оруулалт | - 120.6 | 514.7 | 1 146.9 | 632.2 | 2.2** |
| Актив | 328.5 | 348.1 | 1 963.9 | 1 615.8 | 5.6** |
| Бэлэн мөнгө ба харилцах | 132.9 | 463.0 | 1 953.3 | 1 490.3 | 4.2** |
| Зээл | 35.5 | - 26.8 | 13.1 | 39.9 | - |
| Худалдааны зээл ба урьдчилгаа | 160.1 | - 88.1 | - 2.5 | 85.6 | - 97.1 |
| Пассив | 449.1 | - 166.5 | 817.0 | 983.5 | - |
| Бэлэн мөнгө ба харилцах | - 220.9 | - 611.8 | 261.1 | 872.8 | - |
| Зээл | 564.4 | 603.2 | 524.3 | - 79.0 | - 13.1 |
| Худалдааны зээл ба урьдчилгаа | 105.6 | - 158.0 | 31.6 | 189.7 | - |
| Алдаа болон орхигдуулга | - 275.7 | - 393.2 | 356.2 | 749.4 | - |
| **Нөөц хөрөнгө** | **1 457.0** | **622.3** | **1 034.3** | **412.0** | **66.2** |

** Дахин их

Санхүүгийн дансны тэнцэл 2025 онд 1.7 тэрбум ам.долларын ашигтай гарсан хэдийч, өмнөх оноос ашиг 1.6 (49.5%) тэрбум ам.доллароор буурсан байна.

Санхүүгийн дансны ашиг буурахад хамаарал бүхий компани хоорондын шууд хөрөнгө оруулалт өмнөх оноос 1.1 тэрбум ам.доллароор, урт хугацаат өрийн бичгийн орлого 248.3 сая ам.доллароор буурсан нь голлон нөлөөлжээ.

Харин бусад хөрөнгө оруулалт 1.2 тэрбум ам.долларын алдагдалтай гарч, алдагдал өмнөх оноос 632.2 (2.2 дахин) сая ам.доллароор өссөн байна.

Ойлголт, тодорхойлолт:

Төлбөрийн тэнцэл:
Тодорхой хугацаанд эдийн засгийн харьяат болон эдийн засгийн харьяат бусын хооронд хийсэн худалдаа, үйлчилгээ, орлого, урсгал шилжүүлэг, санхүүгийн болон хөрөнгийн урсгалын орлого, зарлагын гүйлгээг нэгтгэсэн статистикийн тайлан бөгөөд дараах 3 бүлгээр нэгтгэн боловсруулдаг.

Урсгал данс:
Эдийн засгийн харьяат болон харьяат бусын хоорондох бараа, үйлчилгээ, анхдагч орлого, орлогын дахин хуваарилалтын урсгалыг харуулах бөгөөд бараа, үйлчилгээ, орлого, урсгал шилжүүлгийн нийлбэрээс бүрдэнэ.

Хөрөнгийн данс:
Хөрөнгийн шилжүүлэг болон үйлдвэрлэгддэггүй, санхүүгийн бус активын шилжүүлэг гэсэн хоёр ангиллаар бүртгэнэ.

Санхүүгийн данс:
Монгол Улсаас бусад гадаад улсад хийсэн хөрөнгө оруулалт /актив/, бусад улсаас Монгол Улсад хийсэн хөрөнгө оруулалтын /пассив/ гүйлгээг бүртгэдэг бүх данс хамаарна. Санхүүгийн дансанд активын өсөлт пассивынхаас илүү, активын бууралт пассивынхаас бага эсвэл актив өсөж, пассив буурсан үед “+” буюу алдагдалтайг, эсрэгээр пассивын өсөлт активынхаас илүү, активын бууралт пассивынхаас илүү эсвэл актив буурч, пассив өссөн үед “-” буюу ашигтайг илэрхийлнэ.

Цэвэр нөөц:
Гадаад валютын улсын нөөцийг Олон Улсын Валютын Сангийн зээлийн үлдэгдэл болон богино хугацаат гадаад пассивын дүнгээр цэвэрлэж тооцсон нөөцийг ойлгоно.

Шууд хөрөнгө оруулалт:
Харьяат бус нь нэг ба түүнээс дээш жилийн хугацаанд үйл ажиллагааны удирдлагад нөлөөлөхүйц саналын эрх бүхий хэмжээний хөрөнгийг харьяат аж ахуйн нэгжид нийлүүлэх, салбар, харьяа нэгжийг байгуулах үйл ажиллагааг ойлгоно.

# ГАДААД ХУДАЛДАА

## Экспорт өмнөх оны мөн үеэс 71.6 хувиар өслөө.

**ХҮСНЭГТ 33.** **ЭКСПОРТ, ИМПОРТ, ТЭНЦЭЛ**

| Төрөл | Жил | | | 1 дүгээр сар | | | 2026* I / 2025* I | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2023 | 2024 | 2025* | 2024 I | 2025* I | 2026* I | зөрүү | хувь |
| | сая ам.доллар | | | | | | | |
| **Бараа эргэлт** | **24 437.1** | **27 398.0** | **27 072.9** | **2 200.9** | **1 983.5** | **2 592.4** | **608.9** | **30.7** |
| Экспорт | 15 186.9 | 15 783.4 | 15 760.8 | 1 266.4 | 1 019.3 | 1 749.4 | 730.2 | 71.6 |
| Импорт | 9 250.2 | 11 614.7 | 11 312.1 | 934.5 | 964.3 | 843.0 | - 121.3 | - 12.6 |
| **Тэнцэл** | **5 936.6** | **4 168.7** | **4 448.7** | **331.9** | **55.0** | **906.5** | **851.5** | **16.5**** |

Монгол Улс 2026 оны 1 дүгээр сард нийт 105 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 2.6 тэрбум ам.доллар болсон байна. Үүнээс экспорт 1.7 тэрбум ам.доллар, импорт 843.0 сая ам.доллар болж, тэнцэл 906.5 сая ам.долларын ашигтай гарчээ.

Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 608.9 (30.7%) сая ам.доллар, экспорт 730.2 (71.6%) сая ам.доллар, тэнцэл 851.5 (16.5 дахин) сая ам.доллароор тус тус өсөж, импорт 121.3 (12.6%) сая ам.доллароор буурсан байна.

**ЗУРАГ 28.** **ЭКСПОРТ, ИМПОРТ, ТЭНЦЭЛ**







Экспорт 2026 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 730.2 сая ам.доллароор өсөхөд зэсийн хүдэр ба баяжмал 462.3 сая ам.доллар, нүүрс 167.6 сая ам.доллар, боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт 95.5 сая ам.доллар, лаазалсан махан бүтээгдэхүүн 8.3 сая ам.доллароор тус тус өссөн нь голлон нөлөөлжээ. Харин жоншны хүдэр ба баяжмал 15.0 сая ам.доллар, цайрын хүдэр ба баяжмал 6.0 сая ам.доллар, боловсруулаагүй газрын тос 5.6 сая ам.доллар, молибдений хүдэр, баяжмал 2.5 сая ам.доллароор буурсан байна.

**ЗУРАГ 29.** **ЭКСПОРТ, ИМПОРТЫН ӨСӨЛТ, БУУРАЛТ, 2026 оны 1 дүгээр сард**




Импорт өмнөх оны мөн үеэс 121.3 сая ам.доллароор буурахад суудлын автомашин 73.1 сая ам.доллар, ачааны автомашин 36.1 сая ам.доллар, тээврийн хэрэгслийн сэлбэг, эд анги 17.6 сая ам.доллар, дизелийн түлш 13.0 сая ам.доллар, бульдозер, экскаватор зэрэг 7.5 сая ам.доллароор тус тус буурсан нь голлон нөлөөлжээ. Харин автобензин 26.8 сая ам.доллар, азотын бордоо 5.8 сая ам.доллар, тунгаар савлагдсан эм 3.5 сая ам.доллароор тус тус өссөн байна.

**ЗУРАГ 30.** **ЭКСПОРТ, ИМПОРТ, сараар**




Экспорт 2026 оны 1 дүгээр сард өмнөх сараас 215.2 (11.0%) сая ам.доллар, импорт 263.9 (23.8%) сая ам.доллароор тус тус буурсан байна.

## ЗУРАГ 31. ЭКСПОРТ, ИМПОРТЫН БҮТЭЦ, дүнд эзлэх хувиар, 2026 оны 1 дүгээр сард







Эрдэс бүтээгдэхүүн, үнэт чулуу, металл гоёлын зүйлс, үндсэн төмөрлөгийн экспорт нийт экспортын 96.7 хувийг эзэлж байгаа бол импортын 72.0 хувийг эрдэс бүтээгдэхүүн, машин механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги болон үндсэн төмөрлөг, түүгээр хийсэн бүтээгдэхүүн эзэлж байна.

## ХҮСНЭГТ 34. ЭКСПОРТЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН

| Төрөл | Хэмжих нэгж | 2025* I | | 2026* I | | 2026* I / 2025* I | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо хэмжээ | Үнийн дүн | Тоо хэмжээ | Үнийн дүн | зөрүү | хувь |
| | | сая ам.доллар | | | | | |
| Нийт | | | 1 019.3 | | 1 749.4 | 730.2 | 71.6 |
| Эрдэс бүтээгдэхүүн | | | 889.8 | | 1 507.0 | 617.3 | 69.4 |
| Чулуун нүүрс | сая т | 5.2 | 449.0 | 9.7 | 625.2 | 176.2 | 39.2 |
| Зэсийн хүдэр, баяжмал | мян.т | 135.1 | 263.5 | 221.7 | 725.9 | 462.3 | 2.8** |
| Төмрийн хүдэр, баяжмал | мян.т | 560.8 | 41.5 | 702.2 | 49.6 | 8.1 | 19.5 |
| Боловсруулаагүй газрын тос | мян.барр | 284.1 | 21.6 | 282.6 | 16.1 | - 5.6 | - 25.7 |
| Жоншны хүдэр, баяжмал | мян.т | 183.6 | 43.4 | 185.5 | 28.4 | - 15.0 | - 34.6 |
| Цайрын хүдэр, баяжмал | мян.т | 16.1 | 25.9 | 11.8 | 19.9 | - 6.0 | - 23.0 |
| Молибдены хүдэр, баяжмал | мян.т | 0.6 | 10.4 | 0.5 | 7.8 | - 2.5 | - 24.4 |
| Хүрэн нүүрс | мян.т | 628.7 | 23.9 | 421.1 | 15.2 | - 8.6 | - 36.1 |
| Сувд, үнэт ба хагас үнэт чулуу | | | 72.6 | | 168.3 | 95.8 | 2.3** |
| Алт | т | 0.8 | 71.1 | 1.1 | 166.5 | 95.5 | 2.3** |
| Мөнгө | т | - | - | 0.3 | 0.8 | 0.8 | - |
| Нэхмэл эдлэл | | | 5.7 | | 15.6 | 9.8 | 2.7** |
| Самнасан ноолуур | т | 6.5 | 0.8 | 103.0 | 8.9 | 8.1 | 11.8** |
| Хонины ноос | мян.т | 0.1 | 0.1 | 0.3 | 0.4 | 0.2 | 3.2** |
| Амьд мал, амьтад | | | 12.7 | | 7.9 | - 4.7 | - 37.2 |
| Хонь, ямааны мах | мян.т | 1.0 | 3.6 | 0.5 | 1.9 | - 1.7 | - 47.2 |
| Адууны мах | мян.т | 1.9 | 6.8 | 1.6 | 5.2 | - 1.6 | - 23.8 |
| Богийн өлөн гэдэс | т | 43.7 | 1.4 | 23.6 | 0.4 | - 1.0 | - 72.5 |
| Бусад мал, амьтад | тол | - | - | 2.0 | 0.0 | 0.0 | - |
| Ургамлын гаралтай | | | 17.1 | | 0.0 | - 17.0 | - 99.8 |
| Рапс | мян.т | 16.3 | 9.3 | - | - | - 9.3 | - |
| Самар | мян.т | 0.5 | 6.3 | - | - | - 6.3 | - |

| Төрөл | Хэмжих нэгж | 2025* I | | 2026* I | | 2026* I / 2025* I | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо хэмжээ | Үнийн дүн | Тоо хэмжээ | Үнийн дүн | зөрүү | хувь |
| | | сая ам.доллар | | | | | |
| **Хүнсний бэлэн бүтээгдэхүүн** | | | 7.2 | | 15.7 | 8.5 | 2.2** |
| Лаазалсан махан бүтээгдэхүүн | мян.т | 1.4 | 6.6 | 3.3 | 14.8 | 8.3 | 2.3** |
| Бусад хүнсний бүтээгдэхүүн | | | 0.2 | | 0.4 | 0.2 | 85.4 |
| Үр тарианы хаягдал | мян.т | - | - | 0.5 | 0.1 | 0.1 | - |
| **Бусад** | | | 14.3 | | 34.8 | 20.5 | 2.4** |
| Тунгаасан зэс ба хайлш | мян.т | 0.6 | 5.5 | 0.7 | 7.8 | 2.3 | 42.2 |
| Суудлын автомашин | ш | 7.0 | 0.0 | 19.0 | 0.3 | 0.2 | 5.7** |
| Бульдозер, экскаватор зэрэг | ш | 1.0 | 0.9 | 1.0 | 0.0 | - 0.9 | - 98.3 |

**ЗУРАГ 32.** **ЭКСПОРТЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН, биет хэмжээгээр, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар**




**ЗУРАГ 33.** **ЭКСПОРТЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХИЛИЙН ДУНДАЖ ҮНЭ**









2026 оны 1 дүгээр сарын хилийн дундаж үнийн үзүүлэлт: Алтны үнэ өмнөх оны мөн үеэс унц тутамд 1972.9 ам.доллар, зэсийн хүдэр, баяжмалын үнэ тонн тутамд 1324.0 ам.доллароор тус тус өсөж, төмрийн хүдэр, баяжмалын үнэ тонн тутамд 3.4 ам.доллар, нүүрсний үнэ тонн тутамд 17.8 ам.доллароор буурсан байна.

## ХҮСНЭГТ 35. ЭКСПОРТ, гол түнш улсаар

| Улс | 2024 I | | 2025* I | | 2026* I | |
|---|---|---|---|---|---|---|
| | Дүн | Эзлэх хувь | Дүн | Эзлэх хувь | Дүн | Эзлэх хувь |
| | сая ам.доллар | | | | | |
| **Дүн** | **1 266.4** | **100.0** | **1 019.3** | **100.0** | **1 749.4** | **100.0** |
| БНХАУ | 1 203.7 | 95.0 | 927.7 | 91.0 | 1 555.7 | 88.9 |
| Швейцар | 20.9 | 1.6 | 71.1 | 7.0 | 126.7 | 7.2 |
| АНУ | 0.3 | 0.0 | 1.6 | 0.2 | 41.5 | 2.4 |
| Бразил | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 9.1 | 0.5 |
| Иран | 8.5 | 0.7 | 1.2 | 0.1 | 3.2 | 0.2 |
| Бусад | 33.0 | 2.6 | 17.8 | 1.7 | 13.1 | 0.7 |

БНХАУ-д экспортолсон барааны 41.2 хувийг нүүрс, 46.7 хувийг зэсийн хүдэр, баяжмал эзэлж байгаа бол Швейцар улсад экспортолсон барааны 99.3 хувийг боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт эзэлж байна.

## ЗУРАГ 34. АЛТНЫ ЭКСПОРТЫН ХИЛИЙН ДУНДАЖ ҮНЭ, унц




2026 оны 1 дүгээр сарын байдлаар алтны экспортын хилийн дундаж үнэ унци тутам 4463.9 ам.доллар болж, өмнөх сараас унц тутамд 513.0 ам.доллароор өссөн байна.

## ХҮСНЭГТ 36. ИМПОРТЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН

| Төрөл | Хэмжих нэгж | 2025* I | | 2026* I | | 2026* I / 2025* I | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо хэмжээ | Үнийн дүн | Тоо хэмжээ | Үнийн дүн | зөрүү | хувь |
| | | сая ам.доллар | | | | | |
| **Нийт** | | | **964.3** | | **843.0** | **-121.3** | **-12.6** |
| **Эрдэс бүтээгдэхүүн** | | | **230.8** | | **258.4** | **27.6** | **12.0** |
| Нефтийн бүтээгдэхүүн | мян.т | 263.6 | 206.5 | 270.2 | 217.6 | 11.2 | 5.4 |
| Цахилгаан эрчим хүч | сая квт.ц | 337.6 | 20.8 | 239.2 | 21.0 | 0.2 | 1.2 |
| Цемент | мян.т | 7.4 | 0.5 | 15.1 | 1.0 | 0.4 | 77.4 |
| **Машин, механик төхөөрөмж** | | | **199.2** | | **182.8** | **-16.4** | **-8.2** |
| Цахилгаан шуудан утасны аппарат | мян.ш | 99.2 | 28.4 | 97.8 | 23.2 | -5.2 | -18.4 |
| Бульдозер, экскоВатор зэрэг | мян.ш | 0.1 | 22.5 | 0.1 | 15.0 | -7.5 | -33.3 |
| Шороо, чулуу ялгах, холих машин | мян.ш | 12.5 | 18.3 | 11.5 | 16.1 | -2.2 | -12.0 |
| Компьютер, түүний бүрдэл хэсэг | мян.ш | 17.0 | 6.1 | 14.9 | 5.6 | -0.5 | -7.5 |
| **Тээврийн хэрэгсэл, эд анги** | | | **250.2** | | **108.9** | **-141.3** | **-56.5** |
| Суудлын автомашин | мян.ш | 15.9 | 139.3 | 6.0 | 66.1 | -73.1 | -52.5 |
| Ачааны автомашин | мян.ш | 2.6 | 59.0 | 1.3 | 22.9 | -36.1 | -61.2 |
| Тээврийн хэрэгслийн сэлбэг, эд анги | мян.ш | 158.8 | 23.2 | 99.0 | 5.5 | -17.6 | -76.1 |
| **Үндсэн төмөрлөг** | | | **57.5** | | **56.5** | **-0.9** | **-1.6** |
| Арматур, катанка | мян.т | 24.0 | 13.6 | 15.0 | 8.2 | -5.4 | -39.6 |
| Хар төмөр бүтэц, эд анги | | | 10.3 | | 9.8 | -0.5 | -5.2 |
| **Бусад** | | | **226.6** | | **236.3** | **9.7** | **4.3** |
| Тун хэлбэрт савлагдсан эм | | - | 6.8 | - | 10.3 | 3.5 | 51.7 |
| Бусад хүнсний бүтээгдэхүүн | | - | 9.7 | - | 8.9 | -0.8 | -8.2 |
| Амтлаг гурилан зүйлс | мян.т | 2.4 | 7.4 | 2.0 | 7.3 | -0.1 | -2.0 |
| Шинэ дугуй | мян.ш | 29.4 | 6.9 | 25.5 | 7.7 | 0.8 | 11.4 |
| Янжуур | сая ш | 231.9 | 4.7 | 155.3 | 3.3 | -1.4 | -30.7 |

Импортын дүнд 2026 оны 1 дүгээр сарын байдлаар БНХАУ 37.1%, ОХУ 31.1%, Япон Улс 8.9%, ХБНГУ 2.8%, БНСУ 2.7%, Энэтхэг 2.2 хувийг тус тус эзэлж, нийт импортын 84.9 хувийг бүрдүүлж байна.

## ХҮСНЭГТ 37. ИМПОРТ, гол түнш улсаар

| Улс | 2024 I | | 2025* I | | 2026* I | |
|---|---|---|---|---|---|---|
| | Дүн | Эзлэх хувь | Дүн | Эзлэх хувь | Дүн | Эзлэх хувь |
| | сая ам.доллар | | | | | |
| **Дүн** | **934.5** | **100.0** | **964.3** | **100.0** | **843.0** | **100.0** |
| БНХАУ | 364.3 | 39.0 | 318.7 | 33.1 | 313.1 | 37.1 |
| ОХУ | 242.2 | 25.9 | 258.2 | 26.8 | 262.4 | 31.1 |
| Япон | 124.9 | 13.4 | 140.8 | 14.6 | 74.9 | 8.9 |
| ХБНГУ | 21.2 | 2.3 | 28.9 | 3.0 | 23.5 | 2.8 |
| БНСУ | 31.6 | 3.4 | 29.7 | 3.1 | 23.0 | 2.7 |
| Энэтхэг | 13.7 | 1.5 | 7.2 | 0.7 | 18.9 | 2.2 |
| Бусад | 136.7 | 14.6 | 180.7 | 18.7 | 127.1 | 15.1 |

2026 оны 1 дүгээр сарын байдлаар ОХУ-аас импортолсон барааны 78.8 хувийг нефтийн бүтээгдэхүүн, Япон Улсаас импортолсон барааны 74.0 хувийг суудлын автомашин, БНХАУ-аас импортолсон барааны 5.3 хувийг телефон, цахилгаан шуудан утасны холбооны аппаратууд тус тус эзэлж байна.

## ЗУРАГ 35. АВТОБЕНЗИН БОЛОН ДИЗЕЛИЙН ТҮЛШНИЙ ИМПОРТЫН БИЕТ ХЭМЖЭЭ, сараар




Автобензины импорт 2026 оны 1 дүгээр сард 116.6 мян.тн болж, өмнөх оны мөн үеэс 40.5 хувиар өссөн бол дизелийн түлшний импорт 147.0 мян.тн болж, 13.4 хувиар буурсан байна.

## ХҮСНЭГТ 38. ЭКСПОРТ, ИМПОРТ, боомтоор, 2026 оны 1 дүгээр сард

| Боомт | Экспорт | | Импорт | |
|---|---|---|---|---|
| | Дүн | Эзлэх хувь | Дүн | Эзлэх хувь |
| | сая ам.доллар | | | |
| Нийт | 1 749.4 | 100.0 | 843.0 | 100.0 |
| Алтанбулаг | - | - | 0.1 | 0.0 |
| Арцсуурь | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| Баянхошуу | 14.3 | 0.8 | - | - |
| Бичигт | 29.9 | 1.7 | 1.8 | 0.2 |
| Боршоо | 0.1 | 0.0 | 4.5 | 0.5 |
| Булган | - | - | 5.4 | 0.6 |
| Бургастай | - | - | 0.0 | 0.0 |
| Буянт-Ухаа | 0.5 | 0.0 | - | - |
| Гашуун сухайт | 969.5 | 55.4 | 48.4 | 5.7 |
| Замын-Үүд | 283.7 | 16.2 | 459.7 | 54.5 |
| Сүхбаатар | 1.5 | 0.1 | 236.2 | 28.0 |
| Тэс | - | - | 0.0 | 0.0 |
| Хавирга | 0.6 | 0.0 | 1.0 | 0.1 |
| Ханги | 74.0 | 4.2 | 2.1 | 0.2 |
| Ховд | 7.4 | 0.4 | - | - |
| Цагаандэл уул | - | - | 0.0 | 0.0 |
| Цагааннуур | 0.6 | 0.0 | 7.8 | 0.9 |
| Чингис хаан | 172.6 | 9.9 | 62.3 | 7.4 |
| Шивээ хүрэн | 177.9 | 10.2 | 9.3 | 1.1 |
| Эрээнцав | 16.8 | 1.0 | 4.2 | 0.5 |

2026 оны 1 дүгээр сард экспортын 55.4 хувь Гашуунсухайт, 16.2 хувь Замын-Үүд боомтоор хийгдсэн нь нийт экспортын 71.6 хувийг эзэлж байна. Импортын 54.5 хувийг Замын-Үүд, 28.0 хувийг Сүхбаатар боомтоор тус тус хийсэн нь нийт импортын 82.6 хувийг эзэлж байна.

Ойлголт, тодорхойлолт:

Гадаад худалдааны барааны нийт эргэлт:
Экспорт, импортын нийлбэрээр тодорхойлно.

Гадаад худалдааны тэнцэл:
Нийт экспортоос импортыг хассан зөрүүгээр тэнцлийг тодорхойлно. Тэнцэл (-) тэмдэгтэй бол алдагдалтай, (+) тэмдэгтэй бол ашигтай гэж үзнэ.

Барааны импорт:
Улсын материаллаг нөөцийг нэмэгдүүлэн, хилийн чанадаас эдийн засгийн нутаг дэвсгэрт оруулж байгаа барааг тооцно. Нийт импортод гадаадын барааны шууд импорт, дотоодын барааны реимпорт багтана.

Барааны реимпорт:
Өмнө нь экспортод бүртгэгдсэн дотоодын барааны импортыг ойлгоно.

Барааны экспорт:
Улсын материаллаг нөөцийг хорогдуулан, эдийн засгийн нутаг дэвсгэрээс хилийн чанадад гаргаж байгаа барааг тооцно. Нийт экспортод дотоодын барааны шууд экспорт, гадаадын барааны реэкспорт багтана.

Барааны реэкспорт:
Өмнө нь импортод бүртгэгдсэн гадаадын барааны экспортыг ойлгоно.

Дотоодын бараа:
Гаалийн нутаг дэвсгэрт боловсруулалт хийснээс бусад Монгол Улсад үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн, эсхүл Монгол Улсын нутаг дэвсгэр дээр чөлөөт эргэлтэд байгаа гадаадын барааг оруулна.

# ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС

## Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үеэс 7.5 хувиар өслөө.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2026 оны 1 дүгээр сард улсын хэмжээнд өмнөх оны мөн үеэс 7.5 хувиар, өмнөх сараас 1.1 хувиар тус тус өссөн байна.

**ХҮСНЭГТ 39. ХҮНСНИЙ БОЛОН ХҮНСНИЙ БУС БҮТЭЭГДЭХҮҮН, БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮЛГИЙН ҮНИЙН ИНДЕКСИЙН ӨӨРЧЛӨЛТ, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар, бүсээр, жил бүрийн 1 дүгээр сард**

| Сар | Бүлэг | Улс | Улаанбаатар | Баруун бүс | Хангайн бүс | Төвийн бүс | Зүүн бүс |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хувь | | | | | |
| 2025 I | **Ерөнхий индекс** | **8.7** | **8.8** | **10.0** | **8.3** | **8.3** | **7.5** |
| | Хүнс | 9.0 | 8.3 | 10.0 | 10.9 | 10.8 | 5.4 |
| | Хүнсний бус | 8.6 | 9.0 | 10.0 | 7.4 | 7.1 | 8.3 |
| | Бараа | 6.7 | 6.4 | 8.0 | 7.0 | 7.4 | 5.9 |
| | Үйлчилгээ | 14.9 | 14.9 | 18.9 | 14.5 | 12.7 | 14.8 |
| 2026 I | **Ерөнхий индекс** | **7.5** | **7.5** | **7.7** | **7.0** | **8.5** | **6.3** |
| | Хүнс | 12.4 | 13.0 | 11.4 | 10.3 | 13.8 | 9.6 |
| | Хүнсний бус | 5.6 | 5.5 | 6.3 | 5.8 | 5.6 | 4.9 |
| | Бараа | 7.0 | 6.4 | 7.5 | 7.0 | 9.4 | 6.6 |
| | Үйлчилгээ | 8.9 | 10.0 | 8.4 | 7.0 | 4.7 | 4.9 |

2026 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад улсын хэмжээнд барааны бүлгийн үнэ 7.0 хувь, үйлчилгээний бүлгийн үнэ 8.9 хувь, хүнсний бүлгийн үнэ 12.4 хувь, хүнсний бус бүлгийн үнэ 5.6 хувиар тус тус өссөн байна.

2026 оны 1 дүгээр сард Төвийн бүсэд барааны бүлгийн үнэ 9.4 хувь, Улаанбаатар хотод үйлчилгээний бүлгийн үнэ 10.0 хувь, Төвийн бүсэд хүнсний бүлгийн үнэ 13.8 хувь, Баруун бүсэд хүнсний бус бүлгийн үнэ 6.3 хувиар тус тус өссөн нь хамгийн өндөр байна.

**ЗУРАГ 36. ХҮНСНИЙ БОЛОН ХҮНСНИЙ БУС БҮТЭЭГДЭХҮҮН, БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮЛГИЙН ҮНИЙН ИНДЕКСИЙН ӨӨРЧЛӨЛТ, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар**



## ЗУРАГ 37. УЛСЫН ЖИЛИЙН ИНФЛЯЦЫН БҮРЭЛДЭХҮҮН, сараар




Инфляцын түвшин буюу хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2025 оны 1 дүгээр сард 8.7 хувь байсан бол 2026 оны 1 дүгээр сард 7.5 хувь болж, өсөлтийн хурдац өмнөх оны мөн үеэс 1.2 нэгж хувиар буурсан байна.

Улсын инфляцад бензин, түлшнээс бусад импортын барааны үнэ 1.6 нэгж хувиар (21.6%), мах, хатуу түлшнээс бусад дотоодын барааны үнэ 3.8 нэгж хувиар (51.3%) тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

## ХҮСНЭГТ 40. ИНФЛЯЦАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮЛГҮҮДИЙН ҮНИЙН ӨСӨЛТИЙН ОРОЛЦОО, жил бүрийн 1 дүгээр сард

| Бараа, үйлчилгээний бүлэг | 2025 I | | 2026 I | | Өмнөх сараас | |
|---|---|---|---|---|---|---|
| | хувь | оролцоо | хувь | оролцоо | хувь | оролцоо |
| **Ерөнхий индекс** | **8.7** | **100.0** | **7.5** | **100.0** | **1.1** | **100.0** |
| Хүнсний бараа, ундаа, ус | 2.5 | 28.2 | 3.4 | 44.9 | 1.0 | 85.1 |
| Согтууруулах ундаа, тамхи | 0.0 | 0.4 | 0.1 | 1.0 | 0.0 | 1.0 |
| Хувцас, бөс бараа, гутал | 1.2 | 14.2 | 0.9 | 11.5 | 0.0 | 3.2 |
| Орон сууц, ус, цахилгаан, түлш | 1.9 | 22.3 | 0.5 | 6.1 | 0.0 | -1.9 |
| Гэр ахуйн тавилга, бараа | 0.4 | 4.3 | 0.3 | 3.4 | 0.0 | 1.1 |
| Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ | 0.3 | 3.5 | 0.5 | 6.1 | 0.1 | 7.4 |
| Тээвэр | 0.1 | 0.9 | 0.3 | 4.2 | 0.0 | -0.1 |
| Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ | 0.1 | 0.8 | 0.1 | 1.0 | 0.0 | 0.0 |
| Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ | 0.1 | 1.2 | 0.1 | 1.2 | 0.0 | 0.1 |
| Боловсролын үйлчилгээ | 1.0 | 11.8 | 0.8 | 10.4 | 0.0 | 0.0 |
| Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ | 0.3 | 4.0 | 0.2 | 2.9 | 0.0 | 2.6 |
| Даатгал, санхүүгийн үйлчилгээ | 0.0 | 0.5 | 0.0 | 0.2 | 0.0 | 0.0 |
| Бусад бараа, үйлчилгээ | 0.7 | 8.0 | 0.5 | 7.1 | 0.0 | 1.5 |

Инфляцын түвшин 2026 оны 1 дүгээр сард улсын хэмжээнд 7.5 хувь гарсны 3.4 (44.9%) нэгж хувь нь хүнсний бараа, ундаа, усны бүлэг, 0.9 (11.5%) нэгж хувь нь хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнийн өсөлтөөс голлон шалтгаалсан байна.

**ЗУРАГ 38.** **БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮЛГҮҮДИЙН ҮНИЙН ӨСӨЛТ, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар, 2026 оны 1 дүгээр сард**




Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2026 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 7.5 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 12.6 хувь (согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 8.8 хувь), хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 6.6 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 5.3 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээний үнэ 6.5 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний бүлгийн үнэ 6.1 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 8.5 хувь, боловсролын үйлчилгээний бүлгийн үнэ 12.8 хувь, бусад бараа, үйлчилгээний үнэ 8.9 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2026 оны 1 дүгээр сард өмнөх сараас 1.1 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 3.5 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

**ХҮСНЭГТ 41.** **ИНФЛЯЦАД ИМПОРТЫН БАРААНЫ ҮНИЙН ӨСӨЛТИЙН ОРОЛЦОО, жил бүрийн 1 дүгээр сард**

| Үзүүлэлт | 2025 I | | 2026 I | |
|---|---|---|---|---|
| | нэгж хувь | оролцоо | нэгж хувь | оролцоо |
| **Ерөнхий индекс** | **8.7** | **100.0** | **7.5** | **100.0** |
| Импортын барааны нөлөө | 2.3 | 26.3 | 1.9 | 25.5 |

Инфляц 2026 оны 1 дүгээр сард 7.5 хувь гарсны 1.9 (25.5%) нэгж хувь нь импортын барааны үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсанд нийт 430 нэр төрлийн бараа, үйлчилгээ, Улаанбаатар хотын хэмжээнд 418 нэр төрлийн бараа, үйлчилгээний үнийг судалдаг.
Нийт 430 нэр төрлийн бараа, үйлчилгээний 238 нь импортын бараа байгаа бөгөөд энэ нь нийт сагсны 55.3 хувийг эзэлж байна.

**ЗУРАГ 39.** **ТАЛХ, ГУРИЛ, БУДАА БОЛОН МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙН ИНДЕКСИЙН ӨӨРЧЛӨЛТ, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар, сараар**







2026 оны 1 дүгээр сард мах, махан бүтээгдэхүүний бүлгийн үнэ өмнөх оны мөн үеэс 18.4 хувиар өсөхөд үхрийн махны үнэ 25.8 хувиар, хонь, ямааны махны үнэ 17.5 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Талх, гурил, будааны бүлгийн үнэ өмнөх оны мөн үеэс 6.3 хувиар өсөхөд гурил болон бусад төстэй бүтээгдэхүүний үнэ 7.7 хувиар, гоймонгийн үнэ 16.8 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

<u>Улаанбаатар хот:</u>

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ Улаанбаатар хотод 2026 оны 1 дүгээр сард өмнөх сараас 0.9 хувиар, өмнөх оны мөн үеэс 7.5 хувиар тус тус өслөө.

**ЗУРАГ 40.** **УЛААНБААТАР ХОТЫН ЖИЛИЙН ИНФЛЯЦЫН БҮРЭЛДЭХҮҮН, сараар**




Улаанбаатар хотын инфляцын түвшин буюу хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс 2025 оны 1 дүгээр сард 8.8 хувь байсан бол 2026 оны 1 дүгээр сард 7.5 хувь болж, өсөлтийн хурдац өмнөх оны мөн үеэс 1.3 нэгж хувиар буурсан байна.

Улаанбаатар хотын инфляцад бензин, түлшнээс бусад импортын барааны үнэ 1.0 нэгж хувиар (13.3%), мах, хатуу түлшнээс бусад дотоодын барааны үнэ 4.6 нэгж хувиар (61.4%) тус тус нөлөөлсөн байна.

Улаанбаатар хотод 2026 оны 1 дүгээр сард хэрэглээний сагсны 418 нэрийн бараа, үйлчилгээнээс 134 (32.1%) бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас өсөж, 37 (8.9%) бараа, үйлчилгээний үнэ буурч, 247 (59.1%) бараа, үйлчилгээний үнэ өөрчлөлтгүй байна.

**ЗУРАГ 41.** **УЛААНБААТАР ХОТОД ХУДАЛДААЛАГДАЖ БУЙ ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ДУНДАЖ ҮНЭ, сараар**




Улаанбаатар хотод худалдаалагдаж буй үхрийн цул 1 кг махны дундаж үнэ 2026 оны 1 дүгээр сард 27395 төгрөг болж, 2024 оны 1 дүгээр сараас 47.2 хувиар, 2025 оны 1 дүгээр сараас 26.6 хувиар, өмнөх сараас 10.4 хувиар (2570 төгрөгөөр) тус тус өссөн байна.

1-р зэргийн гурилын дундаж үнэ 2026 оны 1 дүгээр сард 2507 төгрөг болж, 2024 оны 1 дүгээр сараас 3.3 хувиар, 2025 оны 1 дүгээр сараас 12.8 хувиар, өмнөх сараас 0.4 хувиар (10 төгрөгөөр) тус тус өссөн байна.

Нэг литр АИ-92 бензиний дундаж үнэ 2026 оны 1 дүгээр сард 2590 төгрөг болж, 2025 оны 1 дүгээр сараас 8.4 хувь (200 төгрөгөөр) өсөж, харин өмнөх сараас өөрчлөлтгүй байна.

<u>Аймаг:</u>

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2026 оны 1 дүгээр сард бүх аймагт өмнөх оны мөн үеэс 4.8-13.3 хувиар өссөн байна. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ Сүхбаатар аймагт 4.8 хувиар өссөн нь хамгийн бага, Сэлэнгэ аймагт 13.3 хувиар өссөн нь хамгийн өндөр байна.

**ЗУРАГ 42.** **ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКСИЙН ӨӨРЧЛӨЛТ, өмнөх оны мөн үетэй харьцуулахад, 2026 оны 1 дүгээр сард**



Ойлголт, тодорхойлолт:

Хэрэглээний сагс:
Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно.

Хэрэглээний бараа, үйлчилгээний жин:
Өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувь.

Хэрэглээний үнийн индекс:
Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Тооцох аргачлал:
Хэрэглээний үнийн индексийг хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглан, хувиргасан үнийн Ласпейрсийн индексийн томьёогоор тооцно. Үүнд:

$$I_{ct}^{L} = \sum \left(\frac{P_{it}}{P_{it-1}}\right)\left(\frac{P_{it-1}}{P_{it-2}}\right)\cdots\left(\frac{P_{i2}}{P_{i1}}\right)\left(\frac{P_{i1}}{P_{i0}}\right)\frac{P_{i0}Q_{i0}}{\sum P_{i0}Q_{i0}}$$

$I_{ct}^{L}$ – тайлант үеийн хувиргасан Ласпейрсийн индекс (t)
*t* – тайлант үе
*i* – бараа, үйлчилгээ
*o* – суурь үе
$P_t^i$ - i барааны тайлант үеийн үнэ
$P_0^i$ – i барааны суурь үеийн үнэ
$Q_0^i$- i барааны суурь үеийн жин

Хэрэглээний үнийн индексийн сагсны төлөөлөх чадварыг нэмэгдүүлэх, үнэн зөв байдлыг хангах үүднээс хэрэглээний сагс, жинг 3 жилд нэг удаа шинэчилдэг.

Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсыг улсын хэмжээнд 430 бараа, үйлчилгээ (Улаанбаатар хотод 418, аймагт 333 бараа, үйлчилгээ)-ээр бүрдүүлж, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2023 оны үр дүнгээр жинг тооцон, 2023 оны дундаж үнийн суурьтайгаар 2025 оны 2 дугаар сараас эхлэн тархааж байна.

Хэрэглээний үнийн индексийг тооцохдоо бараа, үйлчилгээний геометр дундаж үнийг ашигласан. Мөн аймгийн дундаж үнийг тооцохдоо сонгогдсон 112 сумын үнийн мэдээллийг хамруулж байна.

Гол нэр төрлийн барааны үнийг сум, аймаг, дүүрэг, нийслэлээс сар бүр цуглуулж байна.

# ГАДААД ХУДАЛДААНЫ НӨХЦӨЛИЙН ИНДЕКС

**Гадаад худалдааны нөхцөлийн индекс 2025 оны 12 дугаар сард өмнөх оны мөн үеэс 11.3 хувиар өссөн байна.**

Гадаад худалдааны нөхцөлийн индекс (2015=100) 2025 оны 12 дугаар сард 155.7 болж, өмнөх сараас 3.3 хувь, өмнөх оны мөн үеэс 11.3 хувиар өссөн байна.

**ХҮСНЭГТ 42.** **ГАДААД ХУДАЛДААНЫ НӨХЦӨЛИЙН ИНДЕКС**

| Үзүүлэлт | 2022 | 2023 | 2024 | 2025 | | 2025 XII / 2024 XII | 2025 XII / 2025 XI |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | XI | XII | | |
| | 2015=100 | | | | | хувь | |
| **Гадаад худалдааны нөхцөлийн индекс** | **149.4** | **146.1** | **139.9** | **150.7** | **155.7** | **11.3** | **3.3** |
| Экспортын үнийн индекс | 183.8 | 174.1 | 163.0 | 174.5 | 186.4 | 14.4 | 6.8 |
| Импортын үнийн индекс | 123.0 | 119.2 | 116.5 | 115.8 | 119.8 | 2.8 | 3.4 |

Экспортын үнийн индекс (2015=100) 2025 оны 12 дугаар сард 186.4 хувь болж, экспортын үнэ өмнөх оны мөн үеэс 14.4 хувь, өмнөх сараас 6.8 хувиар өссөн байна. Экспортын үнийн индекс өмнөх оны мөн үеэс 14.4 хувиар өсөхөд алтны үнэ 62.6 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Импортын үнийн индекс (2015=100) 2025 оны 12 дугаар сард 119.8 хувь болж, импортын үнэ өмнөх оны мөн үеэс 2.8 хувь, өмнөх сараас 3.4 хувиар өссөн байна.

**ЗУРАГ 43.** **ГАДААД ХУДАЛДААНЫ НӨХЦӨЛИЙН ИНДЕКС (2015=100)**



## Гадаад худалдааны үнийн индексийн сарын мэдээний 2015 оны суурийг 2024 оноор шинэчилж тооцлоо.

“Гадаад худалдааны үнийн индекс тооцох аргачлал”-д сагс, жинг 5 жил тутамд шинэчлэхээр заасны дагуу Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-оос 2015 оны сагс, жинг 2024 оноор шинэчилж, тооцооллыг хийлээ.

**ХҮСНЭГТ 43. ЭКСПОРТЫН БАРААНЫ БҮЛЭГ, ЖИН, ТҮҮНИЙ ӨӨРЧЛӨЛТ, суурь оноор**

| № | Бүлэг | Жин | | Өөрчлөлт |
|---|---|---|---|---|
| | | 2015 | 2024 | |
| | **Ерөнхий** | **100.0** | **100.0** | - |
| 1 | Мал, амьтад, тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүн | 0.5 | 1.2 | 0.7 |
| 2 | Ургамлын гаралтай бүтээгдэхүүн | 0.8 | 0.3 | -0.5 |
| 3 | Хүнсний бэлэн бүтээгдэхүүн | 0.3 | 0.1 | -0.1 |
| 4 | Эрдэс бүтээгдэхүүн | 79.9 | 89.0 | 9.1 |
| 5 | Хими, химийн үйлдвэрийн бүтээгдэхүүн | 0.0 | 0.0 | 0.0 |
| 6 | Хуванцар, каучук, түүгээр хийсэн эдлэл | 0.0 | 0.0 | 0.0 |
| 7 | Түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл | 0.7 | 0.3 | -0.4 |
| 8 | Нэхмэл, нэхмэл бүтээгдэхүүн | 6.1 | 2.1 | -4.0 |
| 9 | Гутал, малгай, шүхэр, өд, хиймэл цэцэг | 0.0 | 0.0 | 0.0 |
| 10 | Үнэт, хагас үнэт чулуу, металл гоёлын зүйлс | 9.2 | 5.9 | -3.3 |
| 11 | Үндсэн төмөрлөг, түүгээр хийсэн бүтээгдэхүүн | 1.5 | 0.8 | -0.7 |
| 12 | Машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, дуу хураагч, зурагт, тэдгээрийн сэлбэг, эд анги | 0.8 | 0.2 | -0.7 |
| 13 | Авто, агаар, усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги | 0.3 | 0.1 | -0.2 |
| 14 | Хараа зүй, гэрэл, кино зураг, хэмжүүр, хяналт, эмнэлэг, мэс заслын багаж, цаг, хөгжмийн зэмсэг | 0.0 | 0.0 | 0.0 |
| 15 | Үйлдвэрийн төрөл бүрийн бараа | 0.0 | 0.0 | 0.0 |

## ХҮСНЭГТ 44. ИМПОРТЫН БАРААНЫ БҮЛЭГ, ЖИН, ТҮҮНИЙ ӨӨРЧЛӨЛТ, суурь оноор

| № | Бүлэг | Жин | | Өөрчлөлт |
|---|---|---|---|---|
| | | 2015 | 2024 | |
| | **Ерөнхий** | 100.0 | 100.0 | - |
| 1 | Мал, амьтад, тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүн | 0.7 | 0.9 | 0.2 |
| 2 | Ургамлын гаралтай бүтээгдэхүүн | 1.9 | 1.5 | -0.4 |
| 3 | Мал амьтны болон ургамлын гаралтай тос, өөх | 0.6 | 0.3 | -0.3 |
| 4 | Хүнсний бэлэн бүтээгдэхүүн | 5.7 | 5.9 | 0.2 |
| 5 | Эрдэс бүтээгдэхүүн | 29.9 | 24.5 | -5.5 |
| 6 | Хими, химийн үйлдвэрийн бүтээгдэхүүн | 5.0 | 4.2 | -0.8 |
| 7 | Хуванцар, каучук, түүгээр хийсэн эдлэл | 4.0 | 3.5 | -0.4 |
| 8 | Түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл | 0.1 | 0.1 | 0.0 |
| 9 | Мод, модон эдлэл | 1.2 | 0.0 | -1.2 |
| 10 | Цаас болон картон, тэдгээрээр хийсэн зүйлс | 1.0 | 0.7 | -0.3 |
| 11 | Нэхмэл, нэхмэл бүтээгдэхүүн | 1.0 | 0.7 | -0.3 |
| 12 | Гутал, малгай, шүхэр, ед, хиймэл цэцэг | 0.2 | 0.2 | 0.0 |
| 13 | Чулуу, гөлтгөнө, шөрмөсөн чулуу, гялтгануур болон тэдгээртэй төстэй материалаар хийсэн бүтээгдэхүүн | 3.2 | 2.1 | -1.1 |
| 14 | Сувд, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос | 0.0 | 0.0 | 0.0 |
| 15 | Үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн | 11.1 | 11.2 | 0.1 |
| 16 | Машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, дуу хураагч, зурагт, тэдгээрийн сэлбэг, эд анги | 20.0 | 19.2 | -0.9 |
| 17 | Авто, агаар, усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги | 10.7 | 23.0 | 12.3 |
| 18 | Хараа зүй, гэрэл, кино зураг, хэмжүүр, хяналт, эмнэлэг, мэс заслын багаж, цаг, хөгжмийн зэмсэг | 1.6 | 1.0 | -0.6 |
| 19 | Үйлдвэрийн төрөл бүрийн бараа | 2.1 | 1.1 | -1.0 |

## ХҮСНЭГТ 45. ГАДААД ХУДАЛДААНЫ НӨХЦӨЛИЙН ИНДЕКС, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар

| Үзүүлэлт | 2025 XII / 2024 XII | |
|---|---|---|
| | 2015=100 | 2024=100 |
| | хувь | |
| **Гадаад худалдааны нөхцөлийн индекс** | 11.3 | -4.7 |
| Экспортын үнийн индекс | 14.4 | 2.7 |
| Импортын үнийн индекс | 2.8 | 7.8 |

Гадаад худалдааны үнийн индексийн тооцоог 2024 оноор шинэчлэн тооцоход өмнөх оны мөн үеэс экспортын үнийн индекс 2.7 хувь, импортын үнийн индекс 7.8 хувиар өсөж, гадаад худалдааны нөхцөлийн индекс 4.7 хувиар буурсан байна.

Ойлголт, тодорхойлолт:

Монгол Улсын гадаад худалдааны нөхцөлийн индексийг экспортын үнийн ерөнхий индексийг импортын үнийн ерөнхий индексэд харьцуулж тооцно.

Экспортын үнийн индекс:
Монгол Улсын экспортын голлох худалдааны түнш орнуудад нийлүүлж буй барааны үнийн нэгдсэн индексийг ойлгоно.

Импортын үнийн индекс:
Монгол Улсын худалдааны түнш орнуудаас импортолж буй гол нэрийн барааны үнийн нэгдсэн индексийг ойлгоно.

Суурь үе:
Индекс тооцоход хугацааны бусад үеийн үзүүлэлтэд харьцуулж тооцох хугацаа юм.

# ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС

**Орон сууцны үнийн индекс 2026 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 12.6 хувиар өссөн байна.**

Орон сууцны үнийн индекс (2023.I=1.0) 2026 оны 1 дүгээр сард 1.39 болж, өмнөх оны мөн үеэс 12.6 хувиар, өмнөх сараас 0.7 хувиар тус тус өссөн байна.

**ХҮСНЭГТ 46. ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС***

| Үзүүлэлт | Жил | | | Сар | | | 2026 I / 2025 I |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 2023 | 2024 | 2025 | 2024 I | 2025 I | 2026 I | |
| | 2023.I=1.0 | | | | | | хувь |
| **Нийт орон сууц** | **0.99** | **1.08** | **1.38** | **1.09** | **1.24** | **1.39** | **12.6** |
| Шинэ орон сууц | 1.00 | 1.10 | 1.37 | 1.09 | 1.22 | 1.39 | 14.2 |
| Хуучин орон сууц | 0.99 | 1.05 | 1.39 | 1.09 | 1.25 | 1.40 | 11.5 |

*Орон сууцны үнийн индексийг хедоник регрессийн аргыг ашиглан тооцсон.

Орон сууцны насжилтаар авч үзвэл, шинэ орон сууцны үнэ өмнөх оны мөн үеэс 14.2 хувиар, өмнөх сараас 1.1 хувиар, хуучин орон сууцны үнэ өмнөх оны мөн үеэс 11.5 хувиар, өмнөх сараас 0.4 хувиар тус тус өссөн байна.

**ЗУРАГ 44. ОРОН СУУЦНЫ 1 МЕТР КВАДРАТ ТАЛБАЙН ДУНДАЖ ҮНЭ**

Шинэ орон сууц, сая төгрөг




Хуучин орон сууц, сая төгрөг




2026 оны 1 дүгээр сард шинэ орон сууцны 1 метр квадрат талбайн дундаж үнэ 5.05 сая төгрөг болж, Сүхбаатар дүүрэгт хамгийн өндөр буюу 6.11 сая төгрөгийн үнэтэй байна.

Шинэ орон сууцны дундаж үнэ өмнөх оны мөн үетэй харьцуулахад Баянзүрх дүүрэгт 18.0 хувь (722.4 мянган төгрөг)-аар өссөн нь хамгийн өндөр, Сонгинохайрхан дүүрэгт 0.7 хувь (24.0 мянган төгрөг)-аар өссөн нь хамгийн бага байна.

2026 оны 1 дүгээр сард хуучин орон сууцны 1 метр квадрат талбайн дундаж үнэ 4.94 сая төгрөг болж, Сүхбаатар дүүрэгт хамгийн өндөр буюу 5.83 сая төгрөгийн үнэтэй байна.

Хуучин орон сууцны дундаж үнэ өмнөх оны мөн үетэй харьцуулахад Хан-Уул дүүрэгт 16.5 хувь (776.4 мянган төгрөг)-аар өссөн нь хамгийн өндөр, Сүхбаатар дүүрэгт 0.2 хувь (10.5 мянган төгрөг)-аар өссөн нь хамгийн бага байна.

## ХҮСНЭГТ 48. ОРОН СУУЦНЫ 1 МЕТР КВАДРАТ ТАЛБАЙН ДУНДАЖ ҮНЭ

| Дүүрэг | 2024 I | 2025 I | 2026 I | 2026 I* / 2025 I | |
|---|---|---|---|---|---|
| | | | | зөрүү | хувь |
| | сая төгрөг | | | | |
| | | Шинэ орон сууцны дундаж үнэ* | | | |
| Баянгол | 3.61 | 4.12 | 4.58 | 0.5 | 11.2 |
| Баянзүрх | 3.41 | 4.01 | 4.73 | 0.7 | 18.0 |
| Сонгинохайрхан | 2.64 | 3.44 | 3.47 | 0.02 | 0.7 |
| Сүхбаатар | 4.15 | 5.82 | 6.11 | 0.3 | 5.0 |
| Хан-Уул | 4.20 | 4.56 | 5.01 | 0.5 | 10.0 |
| Чингэлтэй | 3.67 | 4.77 | 4.80 | 0.0 | 0.6 |
| | | Хуучин орон сууцны дундаж үнэ | | | |
| Баянгол | 3.20 | 3.84 | 4.20 | 0.4 | 9.3 |
| Баянзүрх | 3.52 | 4.03 | 4.51 | 0.5 | 11.8 |
| Сонгинохайрхан | 2.60 | 2.99 | 3.21 | 0.2 | 7.3 |
| Сүхбаатар | 4.45 | 5.82 | 5.83 | 0.01 | 0.2 |
| Хан-Уул | 4.19 | 4.71 | 5.49 | 0.8 | 16.5 |
| Чингэлтэй | 3.93 | 4.74 | 5.37 | 0.6 | 13.5 |

*Орон сууцны үнийн өөрчлөлтийг цуглуулагдсан үнийн мэдээллийн арифметик дунджийг ашиглан тооцсон.

Туршилт тооцоогоор, 2026 оны 1 дүгээр сард 1 өрөө орон сууцны 1 сарын түрээсийн дундаж үнэ 1.34 сая, 2 өрөө орон сууцны түрээсийн дундаж үнэ 1.87 сая, 3 өрөө орон сууцны түрээсийн дундаж үнэ 3.05 сая төгрөг байна.

## ХҮСНЭГТ 49. ОРОН СУУЦНЫ 1 САРЫН ТҮРЭЭСИЙН ДУНДАЖ ҮНЭ*, 2026 оны 1 дүгээр сард

| Дүүрэг | 1 өрөө | 2 өрөө | 3 өрөө |
|---|---|---|---|
| | сая төгрөг | | |
| Баянгол | 1.19 | 1.61 | 2.14 |
| Баянзүрх | 1.28 | 1.73 | 2.50 |
| Сонгинохайрхан | 0.98 | 1.29 | 1.53 |
| Сүхбаатар | 1.48 | 2.42 | 4.21 |
| Хан-Уул | 1.54 | 1.91 | 3.23 |
| Чингэлтэй | 1.56 | 1.82 | 2.71 |
| Дундаж | 1.34 | 1.87 | 3.05 |

*Туршилт тооцоо

# ХӨДӨӨ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ

## Нас гүйцсэн эр үхрийн үнэ Сүхбаатар аймагт хамгийн өндөр буюу 2.7 сая төгрөг байна.

Малын зах зээлийн дундаж үнийн 2026 оны 1 дүгээр сарын мэдээгээр атны үнэ 1.8 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 300.0 мянган төгрөгөөр, соёолон үрээний үнэ 1.3 сая төгрөг болж, 100.0 мянган төгрөгөөр, хязаалан гунан үхрийн үнэ 1.9 сая төгрөг болж, 300.0 мянган төгрөгөөр, эр хонины үнэ 310.0 мянган төгрөг болж, 50.0 мянган төгрөгөөр, эр ямааны үнэ 220.0 мянган төгрөг болж, 60.0 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

**ХҮСНЭГТ 50.** **НАС ГҮЙЦСЭН МАЛЫН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 1 дүгээр сард**

| Төрөл | 2023 I | 2024 I | 2025 I | 2026 I | 2026 I / 2025 I | |
|---|---|---|---|---|---|---|
| | мян.төг | | | | Зөрүү | Хувь |
| Нас гүйцсэн ат | 1 350.2 | 1 388.6 | 1 500.0 | 1 800.0 | 300.0 | 20.0 |
| Соёолон үрээ | 1 077.1 | 1 138.1 | 1 200.0 | 1 300.0 | 100.0 | 8.3 |
| Хязаалан гуна | 1 331.4 | 1 424.8 | 1 600.0 | 1 900.0 | 300.0 | 18.8 |
| Эр хонь | 198.0 | 220.8 | 260.0 | 310.0 | 50.0 | 19.2 |
| Эр ямаа | 136.6 | 144.0 | 160.0 | 220.0 | 60.0 | 37.5 |

2026 оны 1 дүгээр сард эр үхрийн үнэ Сүхбаатар аймагт хамгийн өндөр буюу 2.7 сая төгрөг, Баян-Өлгий аймагт хамгийн бага буюу 1.4 сая төгрөг байна.

**ЗУРАГ 45.** **НАС ГҮЙЦСЭН ЭР ҮХРИЙН ДУНДАЖ ҮНЭ, 2026 оны 1 дүгээр сард**




Ямааны ноолууртай арьс 2026 оны 1 дүгээр сард 58.1 мянган төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 6.4 мянган төгрөгөөр, боодолтой өвсний (20кг) дундаж үнэ 14.0 мянган төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.0 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

**ЗУРАГ 46.** **МАЛ АЖ АХУЙ, ГАЗАР ТАРИАЛАНГИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 1 дүгээр сард**




Боодолтой өвсний (20кг) үнэ 2026 оны 1 дүгээр сард Хөвсгөл аймагт хамгийн өндөр буюу 22.0 мянган төгрөг, Дорнод аймагт хамгийн бага буюу 6.0 мянган төгрөг байна.

**ЗУРАГ 47.** **БООДОЛТОЙ ӨВСНИЙ (20кг) ДУНДАЖ ҮНЭ, 2026 оны 1 дүгээр сард**




<u>Ойлголт, тодорхойлолт:</u>

Малын үнийн мэдээнд хүнсний болон ашиг шим, уналга, эдэлгээний зориулалтаар худалдан борлуулсан малын үнийг хамруулах бөгөөд харин шилмэл омгийн мах, сүүний чиглэлийн, хурдны морь зэрэг өндөр үнээр борлуулсан малын үнийг үнийн мэдээнд хамруулахгүй.

<u>Тооцох аргачлал:</u>

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн судалгааг сар бүр, сум, дүүрэг, аймаг, нийслэл, зах, худалдааны цэгүүдээс авч нэгтгэн сарын дундаж үнийг геометр дунджаар тооцно.

# АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНЭ

**Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнэ урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх оны мөн үеэс 8.8 хувиар өссөн байна.**

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс (2024=100) 2026 оны 1 дүгээр сард урьдчилсан гүйцэтгэлээр 109.5 болж, үйлдвэрлэгчийн үнэ өмнөх оны мөн үеэс 8.8 хувь, өмнөх сараас 3.6 хувиар тус тус өссөн байна.

**ХҮСНЭГТ 51. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС, дэд салбараар, 2026 оны 1 дүгээр сард**

| Дэд салбар | 2024 | 2025 | | 2026 | 2026* I / 2025 I | 2026* I / 2025 XII |
|---|---|---|---|---|---|---|
| | | I | XII | I* | | |
| | 2024=100 | | | | хувь | |
| **Еренхий индекс** | **103.1** | **100.6** | **105.7** | **109.5** | **8.8** | **3.6** |
| Уул уурхай, олборлолт | 97.7 | 93.6 | 98.1 | 103.1 | 10.1 | 5.1 |
| Боловсруулах үйлдвэрлэл | 105.9 | 106.6 | 114.7 | 116.8 | 9.6 | 1.9 |
| Цахилгаан, хий, уур, агааржуулалт | 136.5 | 136.5 | 136.5 | 136.5 | - | - |
| Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа | 102.4 | 102.4 | 117.5 | 117.5 | 14.7 | - |

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнэ 2026 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 8.8 хувиар өсөхөд металлын хүдэр олборлолтын үйлдвэрлэгчийн үнэ 62.1 хувь, бусад ашигт малтмал олборлолтын үйлдвэрлэгчийн үнэ 25.3 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнэ 2026 оны 1 дүгээр сард өмнөх сараас 3.6 хувиар өсөхөд уул уурхай, олборлолтын салбарын үйлдвэрлэгчийн үнэ 5.1 хувиар өссөн байна. Уул уурхай, олборлолтын салбарын үйлдвэрлэгчийн үнийн сарын өсөлтөд газрын тос олборлолтын үйлдвэрлэгчийн үнэ 12.9 хувь металлын хүдэр олборлолтын үйлдвэрлэгчийн үнэ 6.8 хувь, нүүрс олборлолтын үйлдвэрлэгчийн үнэ 3.1 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

**ХҮСНЭГТ 52. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКСИЙН ӨӨРЧЛӨЛТӨД ДЭД САЛБАРУУДЫН ОРОЛЦОО**

| Дэд салбар | 2025 I | | 2026 I | |
|---|---|---|---|---|
| | нэгж хувь | хувь | нэгж хувь | хувь |
| **Еренхий индекс** | **5.1** | **100.0** | **8.8** | **100.0** |
| Уул уурхай, олборлолт | -1.8 | -35.5 | 6.2 | 69.9 |
| Боловсруулах үйлдвэрлэл | 2.5 | 49.2 | 2.5 | 28.4 |
| Цахилгаан, хий, уур, агааржуулалт | 4.3 | 84.9 | - | - |
| Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа | 0.1 | 1.4 | 0.2 | 1.7 |

**ЗУРАГ 48.** **АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКСИЙН ӨӨРЧЛӨЛТӨД ДЭД САЛБАРУУДЫН ОРОЛЦОО**




Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнэ өмнөх оны мөн үеэс 8.8 хувиар өсөхөд уул, уурхай олборлолтын дэд салбар 6.2 нэгж хувь буюу 69.9 хувиар эерэг нөлөө үзүүлсэн байна.

<u>Ойлголт, тодорхойлолт:</u>

<u>Үйлдвэрлэгчийн үнийн индекс:</u>
Тухайн үйлдвэрлэгчийн үйлдвэрлэсэн болон худалдсан бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг илэрхийлнэ.

<u>Индексийн жин:</u>
Индексийн тооцоонд ашиглах жинг тухайн бүтээгдэхүүний нийт борлуулалтын хэмжээнд эзэлж буй хувийн жингээр тооцно.

<u>Тооцох аргачлал:</u>
Үйлдвэрлэгчийн үнийн индексийн тооцоонд Ласпейрсийн үнийн индексийг ашиглана.

$$I_P^L = \frac{\sum_{i=1}^{n}(p_t^i * q_0^i)}{\sum_{i=1}^{n}(p_0^i * q_0^i)}$$

Үүнд:

$I_P^L -$ $t$ тайлант үеийн Ласпейрсийн үнийн индекс

$t$ – тайлант үе

$0$ – суурь үе

$p_t^i$ – $i$ барааны тайлант үеийн үнэ

$p_0^i$ – $i$ барааны суурь үеийн үнэ

$q_0^i$ – $i$ барааны суурь үеийн худалдан авсан тоо

# ТЭЭВРИЙН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНЭ

**Тээврийн салбарын үйлдвэрлэгчийн үнэ урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх оны мөн үеэс 9.2 хувиар өссөн байна.**

Тээврийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс (2024=100) 2026 оны 1 дүгээр сард 98.5 болж, үйлдвэрлэгчийн үнэ өмнөх оны мөн үеэс 9.2 хувь, өмнөх сараас 1.5 хувиар тус тус өссөн байна.

## ХҮСНЭГТ 53. ТЭЭВРИЙН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС

| Дэд салбар | 2024 | 2025 | | 2026* I | 2026* I / 2025 I | 2026* I / 2025 XII |
|---|---|---|---|---|---|---|
| | | I | XII | | | |
| | 2024=100 | | | | хувь | |
| **Еренхий индекс** | **94.0** | **90.2** | **97.1** | **98.5** | **9.2** | **1.5** |
| Төмөр замын тээвэр | 100.2 | 105.6 | 106.5 | 106.6 | 1.0 | 0.1 |
| Хуурай замын бусад тээвэр | 89.7 | 82.2 | 89.0 | 89.7 | 9.1 | 0.7 |
| Усан замын тээвэр | 100.0 | 100.0 | 125.2 | 125.2 | 25.2 | 0.0 |
| Агаарын тээвэр | 100.6 | 100.9 | 104.5 | 111.8 | 10.8 | 7.0 |
| Агуулахын болон тээврийн туслах үйл ажиллагаа | 99.6 | 99.2 | 110.8 | 112.3 | 13.1 | 1.3 |
| Шуудан, зарлага, элчийн үйл ажиллагаа | 100.3 | 102.7 | 104.7 | 107.9 | 5.1 | 3.1 |

Тээврийн салбарын үйлдвэрлэгчийн үнэ өмнөх оны мөн үеэс 9.2 хувиар өсөхөд усан замын тээврийн салбарын үйлдвэрлэгчийн үнэ 25.2 хувь, агуулахын болон тээврийн туслах үйл ажиллагааны салбарын үйлдвэрлэгчийн үнэ 13.1 хувь, агаарын тээврийн салбарын үйлдвэрлэгчийн үнэ 10.8 хувь, хуурай замын бусад тээврийн салбарын үйлдвэрлэгчийн үнэ 9.1 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

## ХҮСНЭГТ 54. ТЭЭВРИЙН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКСИЙН ӨӨРЧЛӨЛТӨД ДЭД САЛБАРУУДЫН ОРОЛЦОО

| Дэд салбар | 2025 I | | 2026* I | |
|---|---|---|---|---|
| | нэгж хувь | хувь | нэгж хувь | хувь |
| **Еренхий индекс** | **-20.9** | **100.0** | **9.2** | **100.0** |
| Төмөр замын тээвэр | 0.5 | -2.3 | 0.1 | 1.2 |
| Хуурай замын бусад тээвэр | -21.2 | 101.1 | 4.8 | 52.1 |
| Усан замын тээвэр | - | - | 0.0 | 0.0 |
| Агаарын тээвэр | 0.0 | -0.2 | 1.2 | 13.1 |
| Агуулахын болон тээврийн туслах үйл ажиллагаа | -0.3 | 1.5 | 3.1 | 33.2 |
| Шуудан, зарлага, элчийн үйл ажиллагаа | 0.0 | -0.1 | 0.0 | 0.4 |

Тээврийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс 2026 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 9.2 хувиар өссөний 4.8 нэгж хувь (52.1%) нь хуурай замын бусад тээврийн салбарын үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.

## ЗУРАГ 49. ТЭЭВРИЙН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКСИЙН ӨӨРЧЛӨЛТӨД ДЭД САЛБАРУУДЫН ОРОЛЦОО




**Мэдээлэл, холбооны салбарын үйлдвэрлэгчийн үнэ урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх оны мөн үеэс 7.5 хувиар өссөн байна.**

Мэдээлэл, холбооны салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс (2024=100) 2026 оны 1 дүгээр сард 109.1 болж, үйлдвэрлэгчийн үнэ өмнөх оны мөн үеэс 7.5 хувь , өмнөх сараас 2.0 хувиар тус тус өссөн байна.

## ХҮСНЭГТ 55. МЭДЭЭЛЭЛ, ХОЛБООНЫ САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС

| Дэд салбар | 2024 | 2025 | | 2026* I | 2026* I / 2025 I | 2026* I / 2025 XII |
|---|---|---|---|---|---|---|
| | | I | XII | | | |
| | 2024=100 | | | | хувь | |
| **Ерөнхий индекс** | **101.0** | **101.4** | **106.9** | **109.1** | **7.5** | **2.0** |
| Эх бэлтгэх, нийтлэх үйл ажиллагаа | 100.0 | 100.0 | 104.5 | 104.6 | 4.5 | 0.1 |
| Кино, видео, телевизийн хөтөлбөрийн үйлдвэрлэл, бичлэг хийх болон хөгжим, ая зохиох үйл ажиллагаа | 100.0 | 100.0 | 102.5 | 102.6 | 2.6 | 0.1 |
| Өргөн нэвтрүүлэг бэлтгэх, дамжуулах үйл ажиллагаа | 105.5 | 107.4 | 110.1 | 110.1 | 2.5 | - |
| Цахилгаан холбоо | 100.0 | 100.0 | 109.1 | 109.2 | 9.2 | 0.1 |
| Компьютер программчлал, зөвлөгөө болон түүнд холбогдох үйл ажиллагаа | 100.0 | 100.0 | 100.0 | 109.8 | 9.8 | 9.8 |
| Мэдээллээр үйлчлэх үйл ажиллагаа | 102.5 | 104.4 | 106.2 | 106.2 | 1.7 | - |

* Урьдчилсан гүйцэтгэл

Мэдээлэл, холбооны салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс өмнөх оны мөн үеэс 7.5 хувиар өсөхөд компьютер программчлал, зөвлөгөө болон түүнд холбогдох үйл ажиллагааны дэд салбарын үйлдвэрлэгчийн үнэ 9.8 хувь, цахилгаан холбооны дэд салбарын үйлдвэрлэгчийн үнэ 9.2 хувь, эх бэлтгэх, нийтлэх үйл ажиллагааны дэд салбарын үйлдвэрлэгчийн үнэ 4.5 хувь, кино, видео, телевизийн хөтөлбөрийн үйлдвэрлэл, бичлэг хийх болон хөгжим, ая зохиох үйл ажиллагааны дэд салбарын үйлдвэрлэгчийн үнэ 2.6 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

## ХҮСНЭГТ 56. МЭДЭЭЛЭЛ, ХОЛБООНЫ САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКСИЙН ӨӨРЧЛӨЛТӨД ДЭД САЛБАРУУДЫН ОРОЛЦОО

| Дэд салбар | 2025 I | | 2026* I | |
|---|---|---|---|---|
| | нэгж хувь | хувь | нэгж хувь | хувь |
| **Ерөнхий индекс** | **3.4** | **100.0** | **7.5** | **100.0** |
| Эх бэлтгэх, нийтлэх үйл ажиллагаа | 0.0 | 0.0 | 0.1 | 1.5 |
| Кино, видео, телевизийн хөтөлбөрийн үйлдвэрлэл, бичлэг хийх болон хөгжим, ая үйлдвэрлэх үйл ажиллагаа | 0.0 | 0.0 | 0.1 | 1.0 |
| Өргөн нэвтрүүлэг бэлтгэх, дамжуулах үйл ажиллагаа | 3.2 | 94.1 | 0.4 | 5.8 |
| Цахилгаан холбоо | - | - | 4.8 | 63.7 |
| Компьютер программчлал, зөвлөгөө болон түүнд холбогдох үйл ажиллагаа | - | - | 2.0 | 27.1 |
| Мэдээллээр үйлчлэх үйл ажиллагаа | 0.2 | 5.8 | 0.1 | 0.8 |

Мэдээлэл, холбооны салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс 2026 оны 1 дүгээр сард 7.5 хувь гарсны 4.8 (63.7%) нэгж хувь нь цахилгаан холбооны үнийн өсөлтөөс хамаарч байна.

## ЗУРАГ 50. МЭДЭЭЛЭЛ, ХОЛБООНЫ САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКСИЙН ӨӨРЧЛӨЛТӨД ДЭД САЛБАРУУДЫН ОРОЛЦОО




**Ойлголт, тодорхойлолт:**

**Үйлдвэрлэгчийн үнийн индекс**:
Тухайн үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг лэрхийлнэ.

**Индексийн жин**:
Индексийн тооцоонд ашиглах жинг тухайн бүтээгдэхүүний нийт борлуулалтын хэмжээнд эзэлж буй хувийн жингээр тооцно.

**Тооцох аргачлал:**
Үйлдвэрлэгчийн үнийн индексийн тооцоонд дараах Ласпейрсийн үнийн индексийг хэрэглэнэ.

$$I_P^L = \frac{\sum_{i=1}^{n}(p_t^i * q_0^i)}{\sum_{i=1}^{n}(p_0^i * q_0^i)}$$

Үүнд:

$I_P^L$ – $t$ тайлант үеийн Ласпейрсийн үнийн индекс

$t$ – тайлант үе

$0$ – суурь үе

$p_t^i$ – $i$ барааны тайлант үеийн үнэ

$p_0^i$ – $i$ барааны суурь үеийн үнэ

$q_0^i$ – $i$ барааны суурь үеийн худалдан авсан тоо

# БАРИЛГЫН ӨРТГИЙН ИНДЕКС

**Барилгын өртгийн ерөнхий индекс 2025 оны 4 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 7.8 хувиар өссөн байна.**

Барилгын өртгийн ерөнхий индекс (2015=100) 2025 оны 4 дүгээр улиралд 282.9 болж, барилгын өртөг өмнөх оны мөн үеэс 7.8 хувь, өмнөх улирлаас 1.6 хувиар тус тус өссөн байна.

**ХҮСНЭГТ 1. БАРИЛГЫН ӨРТГИЙН ИНДЕКС, дэд салбараар**

| Дэд салбар | 2023 | 2024 X-XII | 2025 | | 2025 X-XII / 2024 X-XII | 2025 X-XII / 2025 VII-IX |
|---|---|---|---|---|---|---|
| | | | VII-IX | X-XII | | |
| | 2015=100 | | | | хувь | |
| **Ерөнхий индекс** | **248.9** | **262.3** | **278.4** | **282.9** | **7.8** | **1.6** |
| Орон сууцны барилга | 290.9 | 315 | 336.5 | 340.6 | 8.1 | 1.2 |
| Орон сууцны бус барилга | 243.6 | 254.4 | 269.6 | 274.2 | 7.8 | 1.7 |
| Инженерийн барилга, байгууламж | 165.5 | 176.5 | 185.6 | 189.2 | 7.2 | 1.9 |

Орон сууцны барилгын өртгийн индекс (2015=100) 2025 оны 4 дүгээр улиралд 340.6 болж, өртөг нь өмнөх оны мөн үеэс 8.1 хувь, өмнөх улирлаас 1.2 хувиар өссөн байна. Орон сууцны барилгын өртөг өмнөх оны мөн үеэс 8.1 хувиар өсөхөд цалингийн зардал 9.7 хувь, материалын зардал 7.6 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Орон сууцны бус барилгын өртгийн индекс (2015=100) 2025 оны 4 дүгээр улиралд 274.2 болж, өртөг нь өмнөх оны мөн үеэс 7.8 хувь, өмнөх улирлаас 1.7 хувиар тус тус өссөн байна.

Орон сууцны бус барилгын өртөг өмнөх оны мөн үеэс 7.8 хувиар өсөхөд цалин болон машин механизмын зардлын өсөлт голлон нөлөөлсөн байна.

Инженерийн барилга, байгууламжийн өртгийн индекс (2015=100) 2025 оны 4 дүгээр улиралд 189.2 болж, өртөг нь өмнөх оны мөн үеэс 7.2 хувь, өмнөх улирлаас 1.9 хувиар өссөн байна. Инженерийн барилга, байгууламжийн өртөг өмнөх оны мөн үеэс 7.2 хувиар өсөхөд цалингийн зардлын өсөлт голлон нөлөөлсөн байна.

**ЗУРАГ 1. БАРИЛГЫН ӨРТГИЙН ИНДЕКС (2015=100), улирлаар**



## Барилга, байгууламжийн өртгийн улирлын мэдээний 2015 оны суурийг 2024 оноор шинэчилж тооцлоо.

“Барилга байгууламжийн өртгийн индекс тооцох аргачлал”-д сагс, жинг 5 жил тутамд шинэчлэхээр заасны дагуу Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-оос 2015 оны сагс, жинг 2024 оноор шинэчилж, тооцооллыг хийлээ.

**ХҮСНЭГТ 2. БАРИЛГЫН ӨРТГИЙН ИНДЕКС, дэд салбараар, жин, түүний өөрчлөлт**

| Дэд салбар | Жин | | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| | 2015 | 2024 | |
| **Ерөнхий индекс** | **100.0** | **100.0** | - |
| Орон сууцны барилга | 19.3 | 36.8 | -17.5 |
| Орон сууцны бус барилга | 75.7 | 34.3 | 41.4 |
| Инженерийн барилга, байгууламж | 4.9 | 28.9 | -24.0 |

Шинэчлэн батлагдсан 2024 оны барилга, байгууламжийн өртгийн сагс болон жинг ашигласан тооцоогоор Барилгын өртгийн ерөнхий индекс 2025 оны 4 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 10.2 хувь, өмнөх улирлаас 2.4 хувиар өссөн байна. Орон сууцны барилгын өртгийн индекс өмнөх оны мөн үеэс 14.4 хувь, өмнөх улирлаас 2.0 хувиар өссөн. Орон сууцны бус барилгын өртгийн индекс өмнөх оны мөн үеэс 8.0 хувь, өмнөх улирлаас 2.1 хувиар өссөн бол инженерийн барилга, байгууламжийн өртгийн индекс өмнөх оны мөн үеэс 7.3 хувь, өмнөх улирлаас 3.3 хувиар тус тус өссөн байна.

**ХҮСНЭГТ 3. БАРИЛГЫН ӨРТГИЙН ИНДЕКС, дэд салбараар**

| Дэд салбар | 2024 X-XII | 2025 | | 2025 X-XII / 2024 X-XII | 2025 X-XII / 2025 VII-IX |
|---|---|---|---|---|---|
| | | VII-IX | X-XII | | |
| | 2024=100 | | | хувь | |
| **Ерөнхий индекс** | **102.5** | **110.3** | **112.9** | **10.2** | **2.4** |
| Орон сууцны барилга | 103.0 | 115.4 | 117.7 | 14.4 | 2.0 |
| Орон сууцны бус барилга | 102.4 | 108.3 | 110.6 | 8.0 | 2.1 |
| Инженерийн барилга, байгууламж | 102.1 | 106.1 | 109.6 | 7.3 | 3.3 |

### Ойлголт, тодорхойлолт:

**Барилгын өртгийн индекс:**
Барилга, байгууламжийг барьж байгуулахад зарцуулж буй барилгын материал, машин, механизм, цалингийн үнийн өөрчлөлтийг илэрхийлнэ.

**Барилгын төрөл:**
Барилгын төрлийг орон сууцны барилга, орон сууцны бус барилга, инженерийн барилга, байгууламж гэж хуваана.

**Тооцох аргачлал:**
Барилгын материал, цалин, машин, механизмын жинг тооцон, сонгогдсон барилгын материалын үнэ, машин, механизмын тариф, цалинг цуглуулж, тус бүрийн индексийг тооцно. Индексийг тооцохдоо Ласпейрсийн үнийн индексийн томьёог ашиглана.

$$I_1 = \frac{\sum P_1 Q_0}{\sum P_0 Q_0}$$

$P_0$ - суурь үеийн үнэ,
$P_1$ - тайлант үеийн үнэ,
$Q_0$ - суурь үеийн тоо, хэмжээ

# ЗОЧИД БУУДАЛ, БАЙР, СУУЦААР ҮЙЛЧЛЭХ, НИЙТИЙН ХООЛНЫ САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС

**Зочид буудал, байр, сууцаар үйлчлэх үйлчилгээний салбарын үйлдвэрлэгчийн үнэ өмнөх оны мөн үеэс 6.4 хувиар өссөн байна.**

Зочид буудал, байр, сууцаар үйлчлэх үйлчилгээний салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс (2024=100) 2026 оны 1 дүгээр сард 111.5 болж, үйлдвэрлэгчийн үнэ өмнөх оны мөн үеэс 6.4 хувиар өсөж, харин өмнөх сараас 1.4 хувиар буурсан байна.

**ХҮСНЭГТ 57. ЗОЧИД БУУДАЛ, БАЙР, СУУЦААР ҮЙЛЧЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС, аймаг, нийслэлээр**

| Байршил | 2024 | 2025 | | 2026 I | 2026 I / 2025 I | 2026 I / 2025 XII |
|---|---|---|---|---|---|---|
| | 2024=100 | I | XII | | хувь | |
| **Ерөнхий индекс** | 101.0 | 104.8 | 113.1 | 111.5 | 6.4 | -1.4 |
| Нийслэл | 100.6 | 104.9 | 112.1 | 110.2 | 5.0 | -1.7 |
| Аймаг | 103.1 | 104.0 | 117.5 | 117.5 | 13.0 | - |

Зочид буудал, байр, сууцаар үйлчлэх үйлчилгээний салбарын үйлдвэрлэгчийн үнэ нийслэлд өмнөх оны мөн үеэс 5.0 хувь өсөж, өмнөх сараас 1.7 хувиар буурсан байна. Аймагт өмнөх оны мөн үеэс 13.0 хувиар өсөж, өмнөх сараас өөрчлөлтгүй байна.

**ЗУРАГ 51. ЗОЧИД БУУДАЛ, БАЙР, СУУЦААР ҮЙЛЧЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС (2024=100), аймаг, нийслэлээр**



## Нийтийн хоолны салбарын үйлдвэрлэгчийн үнэ өмнөх оны мөн үеэс 11.0 хувиар өссөн байна.

Нийтийн хоолны салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс (2024=100) 2026 оны 1 дүгээр сард 117.0 болж, үйлдвэрлэгчийн үнэ өмнөх оны мөн үеэс 11.0 хувиар, өмнөх сараас 2.6 хувиар тус тус өссөн байна.

**ХҮСНЭГТ 58.** **НИЙТИЙН ХООЛНЫ САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС, дэд салбараар**

| Дэд салбар | 2024 | 2025 | | 2026 I | 2026 I / 2025 I | 2026 I / 2025 XII |
|---|---|---|---|---|---|---|
| | 2024=100 | I | XII | | хувь | |
| **Ерөнхий индекс** | **100.8** | **105.5** | **114.1** | **117.0** | **11.0** | **2.6** |
| Ресторан, хоолны явуулын үйлчилгээ | 100.6 | 102.3 | 113.7 | 114.2 | 11.5 | 0.4 |
| Тусгай үйлчилгээ, хоол бэлтгэх бусад үйл ажиллагаа | 101.6 | 115.2 | 116.5 | 127.7 | 10.8 | 9.6 |
| Ундаагаар үйлчлэх үйл ажиллагаа | 101.1 | 103.2 | 109.5 | 109.5 | 6.1 | 0.0 |

Нийтийн хоолны салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс өмнөх оны мөн үеэс 11.0 хувиар өсөхөд ресторан, хоолны явуулын үйлчилгээний дэд салбарын үйлдвэрлэгчийн үнэ 11.5 хувь, тусгай үйлчилгээ, хоол бэлтгэх бусад үйл ажиллагаа дэд салбарын үйлдвэрлэгчийн үнэ 10.8 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

**ХҮСНЭГТ 59.** **НИЙТИЙН ХООЛНЫ САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС, аймаг, нийслэлээр**

| Байршил | 2024 | 2025 | | 2026 I | 2026 I / 2025 I | 2026 I / 2025 XII |
|---|---|---|---|---|---|---|
| | 2024=100 | I | XII | | хувь | |
| **Ерөнхий индекс** | **100.8** | **105.5** | **114.1** | **117.0** | **11.0** | **2.6** |
| Нийслэл | 100.5 | 106.2 | 113.8 | 117.0 | 10.2 | 2.8 |
| Аймаг | 102.4 | 102.5 | 115.2 | 117.0 | 14.2 | 1.6 |

Нийтийн хоолны салбарын үйлдвэрлэгчийн үнэ нийслэлд өмнөх оны мөн үеэс 10.2 хувь, өмнөх сараас 2.8 хувиар, аймагт өмнөх оны мөн үеэс 14.2 хувь, өмнөх сараас 1.6 хувиар тус тус өссөн байна.

**ЗУРАГ 52.** **НИЙТИЙН ХООЛНЫ САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС (2024=100), аймаг, нийслэлээр**



Ойлголт, тодорхойлолт

Үйлдвэрлэгчийн үнийн индекс:
Тухайн үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг илэрхийлнэ.

Индексийн жин:
Индексийн тооцоонд ашиглах жинг тухайн бүтээгдэхүүний нийт борлуулалтын хэмжээнд эзэлж буй хувийн жингээр тооцно.

Тооцох аргачлал:
Үйлдвэрлэгчийн үнийн индексийн тооцоонд дараах Ласпейрсийн үнийн индексийг хэрэглэнэ.

$$I_P^L = \frac{\sum_{i=1}^{n}(p_t^i * q_0^i)}{\sum_{i=1}^{n}(p_0^i * q_0^i)}$$

Үүнд:
$I_P^L -$ $t$ тайлант үеийн Ласпейрсийн үнийн индекс
$t$ – тайлант үе
$\mathbf{0}$ – суурь үе
$p_t^i$ – $i$ барааны тайлант үеийн үнэ
$p_0^i$ – $i$ барааны суурь үеийн үнэ
$q_0^i$ – $i$ барааны суурь үеийн худалдан авсан тоо

# МАЛ АЖ АХУЙ

## Улсын хэмжээнд 26.3 мянган толгой мал хорогдсон байна.

Том малын зүй бус хорогдол 2026 оны 1 дүгээр сард улсын хэмжээнд 26.3 мянга болж, өмнөх оны мөн үеэс 9.4 (56.1%) мянгаар өссөн байна. Нийт хорогдол оны эхний малын 0.05 хувийн ээлж байна.

Том малын зүй бус хорогдлыг төрлөөр нь авч үзвэл, ямаа 12.1 мянга, хонь 8.6 мянга, үхэр 2.9 мянга, адуу 2.6 мянга, тэмээ 29 толгой хорогдсон байна. Нийт хорогдсон малын 32.6 хувийг хонь, 46.2 хувийг ямаа ээлж байна.

**ХҮСНЭГТ 60.** **ХОРОГДСОН ТОМ МАЛ, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар**

| Малын төрөл | Хорогдсон том мал | | | | Оны эхний малд том малын хорогдлын ээлэх хувь | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2023 I | 2024 I | 2025 I | 2026 I | 2023 I | 2024 I | 2025 I | 2026 I |
| | мянган толгой | | | | хувь | | | |
| **Дүн** | **284.2** | **453.9** | **16.8** | **26.3** | **0.40** | **0.70** | **0.03** | **0.05** |
| Адуу | 15.2 | 25.4 | 1.9 | 2.6 | 0.32 | 0.53 | 0.04 | 0.05 |
| Үхэр | 24.4 | 47.9 | 2.2 | 2.9 | 0.44 | 0.90 | 0.04 | 0.05 |
| Тэмээ | 0.2 | 0.1 | 0.0 | 0.0 | 0.05 | 0.03 | 0.00 | 0.01 |
| Хонь | 108.1 | 197.6 | 5.9 | 8.6 | 0.33 | 0.67 | 0.02 | 0.04 |
| Ямаа | 136.3 | 182.8 | 6.8 | 12.1 | 0.50 | 0.74 | 0.03 | 0.05 |

Хорогдлыг аймгаар авч үзэхэд 2026 оны 1 дүгээр сард Өвөрхангай аймагт 10.8 (41.0 хувь) мянга, Увс аймагт 2.9 (11.2 хувь) мянга, Баян-Өлгий аймагт 1.6 (6.1 хувь) мянга, Завхан аймагт 1.5 (5.6 хувь) мянга, Булган аймагт 1.4 (5.4 хувь) мянга, Хөвсгөл аймагт 1.4 (5.4 хувь) мянган толгой мал хорогдсон нь нийт хорогдлыг 74.7 хувийг ээлж байна.

**ЗУРАГ 53.** **ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, аймаг, нийслэлээр**



Улсын хэмжээнд 2025 оны эцэст тоологдсон 25.3 сая эх малын 3.8 мянган (0.02%) толгой нь 2026 оны 1 дүгээр сард хорогдсон байна. Баян-Өлгий, Ховд, Булган, Хөвсгөл, Увс, Өвөрхангай аймагт 181-1690 толгой хээлтэгч мал хорогдсон нь нийт хорогдсон хээлтэгчийн 73.5 хувийг эзэлж байна.

Харин нийт 181 толгой хээлтүүлэгч хорогдсоны 70 толгой нь ухна, 55 толгой нь хуц, 29 толгой нь бух, 25 толгой нь азарга, 2 толгой буур байна.

Улсын хэмжээнд 2026 оны 1 дүгээр сард 82 толгой мал өвчнөөр хорогдож, өмнөх оны мөн үеэс 12 (12.8 хувь) толгойгоор буурсан байна.

**ЗУРАГ 54. ӨВЧНӨӨР ХОРОГДСОН МАЛ, хувиар, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар**




Хорогдсон нийт том малын 11.4 хувь нь бусад буюу чоно, баавгай, ирвэс зэрэг зэрлэг амьтанд бариулах, мөсөнд цөмрөх, хад асгаас унах, өлдөх, осгох зэрэг шалтгаанаар хорогдсон бол 88.3 хувь нь аюулт үзэгдлээр, 0.3 хувь нь өвчнөөр хорогдсон байна.

<u>Ойлголт, тодорхойлолт</u>

<u>Оны эхний малд том малын зүй бус хорогдлын эзлэх хувь:</u>
Зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100 -гаар үржүүлж тооцно.

<u>Том малын зүй бус хорогдол:</u>
Гэнэтийн аюулаар буюу байгалийн аюулт үзэгдэл, өвчнөөр хорогдсон (халдвартай, халдваргүй), зэрлэг амьтанд идүүлсэн, бариулсан ба бусад шалтгаанаар хорогдсон төл малаас бусад малыг оруулна.

# БАРИЛГА

## Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэл 2025 онд 28.0 хувиар өслөө.

Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэл 2025 онд 11.7 их наяд төгрөг болж, 11.1 (94.9%) их наяд төгрөгийн ажлыг дотоодын барилгын байгууллага, 591.6 (5.1%) тэрбум төгрөгийн ажлыг гадаадын барилгын байгууллага гүйцэтгэсэн байна.

Барилга угсралт, их засварын ажил 2025 онд өмнөх оноос 2.6 (28.0%) их наяд төгрөгөөр өсөхөд дотоодын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 3.0 (36.8%) их наяд төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлөв.

**ХҮСНЭГТ 61.** **БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, гүйцэтгэгчийн төрлөөр**

| Төрөл | 2022 | 2023 | 2024 | 2025* | 2025* / 2024 | |
|---|---|---|---|---|---|---|
| | тэрбум төгрөг | | | | зөрүү | хувь |
| **Нийт** | **6 758.7** | **7 977.9** | **9 149.4** | **11 708.1** | **2 558.6** | **28.0** |
| Дотоодын байгууллага | 6 304.4 | 7 402.6 | 8 127.0 | 11 116.4 | 2 989.4 | 36.8 |
| Төрийн | 128.9 | 132.3 | 99.0 | 811.7 | 712.7 | 8.2** |
| Хувийн | 6 128.3 | 7 210.1 | 7 977.3 | 10 232.6 | 2 255.3 | 28.3 |
| Гадаадтай хамтарсан | 47.2 | 60.3 | 50.7 | 72.1 | 21.4 | 42.2 |
| Гадаадын байгууллага | 454.4 | 575.3 | 1 022.5 | 591.6 | - 430.8 | -42.1 |

** Дахин их

Дотоодын барилгын байгууллагаас хувийн байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 10.2 их наяд төгрөг болж, өмнөх оноос 2.3 (28.3%) их наяд төгрөгөөр, төрийн байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 811.7 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 712.7 (8.2 дахин) тэрбум төгрөгөөр, гадаадтай хамтарсан байгууллагынх 72.1 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 21.4 (42.2%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

**ЗУРАГ 55.** **БАРИЛГЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭСЭН БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ХЭМЖЭЭ, барилгын төрлөөр**









Энэ онд барилга угсралт, их засварын ажлын 37.8 хувийг орон сууцны барилга, 28.7 хувийг орон сууцны бус барилга, 28.4 хувийг инженерийн барилга, байгууламж, 5.1 хувийг их засварын ажил эзэлж, өмнөх оноос орон сууцны бус барилгын ажлын эзлэх хувь 4.3 нэгж хувиар буурсан бол орон сууцны барилгын ажлын эзлэх хувь 2.1 нэгж хувиар, их засварын ажлынх 1.6 нэгж хувиар, инженерийн барилга, байгууламжийнх 0.6 нэгж хувиар тус тус өссөн байна.

## ХҮСНЭГТ 62. ОРОН СУУЦНЫ БУС БАРИЛГА, барилгын төрлөөр

| Төрөл | 2022 | 2023 | 2024 | 2025* | 2025* / 2024 | |
|---|---|---|---|---|---|---|
| | тэрбум төгрөг | | | | зөрүү | хувь |
| **Орон сууцны бус барилга** | **2 059.5** | **2 811.4** | **3 022.6** | **3 360.2** | **337.6** | **11.2** |
| Үйлдвэрийн | 990.1 | 1 179.9 | 1 123.2 | 939.9 | - 183.4 | - 16.3 |
| Худалдаа, үйлчилгээний | 194.1 | 313.8 | 369.4 | 457.8 | 88.5 | 23.9 |
| Эмнэлгийн | 68.1 | 130.8 | 139.2 | 130.9 | - 8.3 | - 6.0 |
| Сургууль, соёлын | 422.3 | 660.2 | 674.2 | 1 030.0 | 355.8 | 52.8 |
| Бусад | 385.0 | 526.8 | 716.6 | 801.6 | 85.0 | 11.9 |

* Урьдчилсан гүйцэтгэл

Орон сууцны бус барилгын ажил 2025 оны гүйцэтгэлээр 3.4 их наяд төгрөг болж, өмнөх оноос 337.6 (11.2%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Төрлөөр авч үзвэл сургууль, соёлын барилгын ажил 355.8 (52.8%) тэрбум төгрөгөөр, худалдаа, үйлчилгээний барилгынх 88.5 (23.9%) тэрбум төгрөгөөр, бусад орон сууцны бус барилгынх 85.0 (11.9%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн бол үйлдвэрийн барилгынх 183.4 (16.3%) тэрбум төгрөгөөр, эмнэлгийн барилгынх 8.3 (6.0%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

**ЗУРАГ 56. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ХЭМЖЭЭ, аймаг, нийслэлээр, 2025 онд**




Улаанбаатар хотод 2025 онд 6.1 их наяд төгрөгийн барилга угсралт, их засварын ажил хийгдсэн нь улсын дүнд 53.2 хувийг эзэлж, өмнөх оноос 4.6 нэгж хувиар өссөн байна.
2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр Өмнөговь аймагт 1.2 их наяд төгрөг, Сэлэнгэ аймагт 632.3 тэрбум төгрөг, Дархан-Уул аймагт 592.7 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажлуудыг тус тус гүйцэтгэсэн нь аймгуудын барилга угсралтын ажлын дүнд 44.1 хувийг эзэлж байна.

Улаанбаатар хотод "Багахангай – Хөшигийн хөндий чиглэлийн төмөр зам"-ын ажил, авто замын их засварын ажлууд, орон сууцны барилгын ажлууд, Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, "Гашуун сухайт – Ганц мод" хил дамнасан төмөр замын ажил, Төв аймагт "Сэргэлэн дэд станц"-ын барилга угсралтын ажил, Сэлэнгэ аймагт орон сууцны бус барилгын ажлууд, Дархан-Уул аймагт орон сууцны барилгын ажлууд эрчимтэй явагдсан байна.

## ХҮСНЭГТ 63. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ҮНДСЭН ФОНД, барилгын төрлөөр

| Төрөл | 2022 | 2023 | 2024 | 2025* | 2025* / 2024 | |
|---|---|---|---|---|---|---|
| | тэрбум төгрөг | | | | зөрүү | хувь |
| **Нийт** | **5 858.4** | **4 438.4** | **8 389.5** | **8 598.3** | **208.8** | **2.5** |
| Орон сууцны барилга | 2 141.8 | 2 077.8 | 2 930.4 | 3 601.6 | 671.2 | 22.9 |
| Орон сууцны бус барилга | 1 030.2 | 1 260.5 | 1 713.6 | 2 141.0 | 427.4 | 24.9 |
| Инженерийн барилга, байгууламж | 2 492.8 | 862.9 | 3 517.3 | 2 391.0 | -1 126.3 | - 32.0 |
| Их засварын ажил | 193.7 | 237.2 | 228.3 | 464.7 | 236.5 | 2.0** |

** Дахин их

2025 онд ашиглалтад оруулсан барилга угсралт, их засварын ажил 8.6 их наяд төгрөг болж, өмнөх оноос 208.8 (2.5%) тэрбум төгрөгөөр өссөн байна.
Үүнд, орон сууцны барилга 671.2 (22.9%) тэрбум төгрөгөөр, орон сууцны бус барилга 427.4 (24.9%) тэрбум төгрөгөөр, их засварын ажил 236.5 (2.0 дахин) тэрбум төгрөгөөр тус тус өссөн бол инженерийн барилга, байгууламжийн ажил 1.1 (32.0%) их наяд төгрөгөөр буурсан байна.

Орон сууцны бус барилгын ажилд үйлдвэр, худалдаа, үйлчилгээний барилгын бүтээн байгуулалтууд ашиглалтад орсон байна.

**<u>Ойлголт, тодорхойлолт:</u>**

**Барилга угсралт, их засвар:**
Барилга байшин барих болон инженерийн зориулалтаар зам, гүүр, далан зэрэг инженерийн бусад байгууламжийг барих хэлбэрээр үндсэн хөрөнгийг бий болгох, шинэчлэх, засварлах, өргөтгөхөд чиглэсэн үйл ажиллагааг ойлгоно.

**Орон сууцны барилга:**
Нийт ашигтай талбайг бүхэлд нь эсвэл нийт ашигтай талбайн талаас илүү хувийг орон сууцны зориулалтаар хэрэглэж болохуйц байгууламжийг хамруулж ойлгоно.

**Орон сууцны бус барилга:**
Тухайн байгууламжийн нийт ашигтай талбайг бүхлээр нь орон сууцны бус зориулалтаар ашиглаж болохуйц эсвэл нийт ашигтай талбайн талаас илүү хувийг орон сууцны бус зориулалтаар ашиглаж болохуйц байгууламжийг ойлгоно.

**Инженерийн барилгын ажил:**
Төмөр зам, зам, гүүр, хурдны зам, онгоцны буудлын талбай, ус хангамж, бохирын шугам, далан хаалт, усжуулалтын байгууламж зэрэг барилга угсралтад ангилагддаггүй барилга, байгууламжийн бүх ажлыг оруулна.

# АЖ ҮЙЛДВЭР

**Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 55.0 хувиар өслөө.**

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2026 оны 1 дүгээр сарын урьдчилсан гүйцэтгэлээр 5.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.9 (55.0%) их наяд төгрөгөөр өслөө. Үүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбар 1.8 (68.0%) их наяд төгрөг, цахилгаан хий, уур агааржуулалтын салбар 95.3 (34.3%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

Уул уурхай олборлох аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2026 оны 1 дүгээр сарын урьдчилсан гүйцэтгэлээр 4.4 их наяд төгрөг болж өсөхөд металлын хүдэр олборлолтын салбар 1.4 (2.2 дахин) их наяд төгрөг, чулуун, хүрэн нүүрс олборлолтын салбар 396.4 (29.9%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

**ХҮСНЭГТ 64.** **АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, салбараар**

| Салбар | Жил | | | Сар | | | 2026* I / 2025 I | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2023 | 2024 | 2025 | 2024 I | 2025 I | 2026* I | зөрүү | хувь |
| | тэрбум төгрөг | | | | | | | |
| Нийт | 39 609.4 | 50 478.0 | 52 912.4 | 3 644.8 | 3 453.9 | 5 345.4 | 1 900.5 | 55.0 |
| Уул уурхай, олборлох аж үйлдвэр | 30 501.7 | 40 898.9 | 41 824.1 | 2 862.0 | 2 620.3 | 4 401.8 | 1 781.5 | 68.0 |
| Боловсруулах аж үйлдвэр | 7 005.0 | 7 239.7 | 8 071.2 | 543.4 | 529.4 | 553.8 | 24.5 | 4.6 |
| Цахилгаан хий, уур, агааржуулалт | 1 875.2 | 2 065.8 | 2 712.7 | 217.0 | 278.1 | 373.4 | 95.3 | 34.3 |
| Ус хангамж, сувагжилтын систем | 227.5 | 273.5 | 304.5 | 22.4 | 26.2 | 25.4 | - 0.8 | - 2.9 |

**ЗУРАГ 57.** **АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, салбараар, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар**



Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт төмрийн хүдрийн баяжмал, зэсийн баяжмал металл агуулгаараа, чулуун нүүрс, төмрийн хүдрийн биет хэмжээ өмнөх оны мөн үеэс 3.5 хувиас 2.3 дахин өсөж, харин цэвэршүүлээгүй алт, газрын тос, хайлуур жонш, хүрэн нүүрс, хайлуур жоншны баяжмал, мөнгөний баяжмал, цайрын баяжмал 2.5 – 89.1 хувиар буурчээ.

Боловсруулах аж үйлдвэрийн салбарт ус, ундаа жүүс, металл бэлдэц, шохой, ноолууран сүлжмэл эдлэл, самнасан ноолуур, цемент зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээ өмнөх оны мөн үеэс 1.8 хувиас 4.2 дахин өсөж, харин цагаан архи, шингэн сүү, гурил, цэвэр спирт, катодын зэс, янжуур тамхи, малын мах зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 1.5 – 60.4 хувиар буурсан байна.

## ХҮСНЭГТ 65. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

| Бүтээгдэхүүн | 2023 I | 2024 I | 2025 I | 2026* I | 2026* I / 2025 I | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зөрүү | хувь |
| **Уул уурхай, олборлох аж үйлдвэр** | | | | | | |
| Чулуун нүүрс, мянган тонн | 4 200 | 5 592 | 5 066 | 9 131 | 4 065 | 80.3 |
| Хүрэн нүүрс, мянган тонн | 1 161 | 1 026 | 1 464 | 1 038 | - 426 | -29.1 |
| Газрын тос, мянган баррел | 431 | 373 | 340 | 313 | - 26 | -7.8 |
| Зэсийн баяжмал, металл агуулгаараа, мянган тонн | 120 | 119 | 147 | 195 | 48 | 32.6 |
| Цэвэршүүлээгүй алт, кг | 530 | 744 | 614 | 599 | - 15 | -2.5 |
| Төмрийн хүдэр, мянган тонн | 229 | 178 | 158 | 362 | 204 | 2.3** |
| Төмрийн хүдрийн баяжмал, мянган тонн | 110 | 163 | 178 | 184 | 6 | 3.5 |
| Хайлуур жонш, мянган тонн | 22 | 23 | 41 | 37 | - 4 | -9.4 |
| Хайлуур жоншны баяжмал, мянган тонн | 5 | 5 | 19 | 13 | - 6 | -32.1 |
| Цайрын баяжмал, мянган тонн | 28 | 42 | 51 | 6 | - 45 | -89.1 |
| Мөнгөний баяжмал, тонн | 830 | 1 119 | 1 117 | 225 | - 891 | -79.8 |
| **Боловсруулах аж үйлдвэр** | | | | | | |
| Малын мах, тонн | 4 047 | 6 673 | 4 429 | 1 753 | -2 676 | -60.4 |
| Шингэн сүү, мянган литр | 4 866 | 5 044 | 5 272 | 4 852 | - 420 | -8.0 |
| Гурил, тонн | 21 661 | 21 689 | 18 747 | 16 468 | -2 279 | -12.2 |
| Цэвэр спирт, мянган литр | 905 | 1 000 | 973 | 834 | - 139 | -14.3 |
| Цагаан архи, мянган литр | 1 962 | 2 460 | 2 179 | 2 145 | - 33 | -1.5 |
| Ус, ундаа, жүүс, мянган литр | 24 499 | 35 526 | 31 347 | 31 906 | 559 | 1.8 |
| Янжуур тамхи, мянган блок | 254 | 257 | 407 | 244 | - 163 | -40.0 |
| Ноолууран сүлжмэл эдлэл, мянган ширхэг | 27 | 35 | 26 | 41 | 15 | 58.0 |
| Самнасан ноолуур, тонн | 23 | 124 | 44 | 72 | 28 | 64.0 |
| Нүүрсэн шахмал түлш, мянган тонн | 58 | 60 | 72 | - | - 72 | - |
| Цемент, мянган тонн | 3 | 38 | 8 | 34 | 26 | 4.2** |
| Шохой, тонн | 4 153 | 5 176 | 5 432 | 6 304 | 872 | 16.0 |
| Катодын зэс, тонн | 778 | 764 | 714 | 582 | - 132 | -18.5 |
| Металл бэлдэц, тонн | 3 356 | 3 343 | 3 254 | 3 328 | 74 | 2.3 |

** Дахин их

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2026 оны 1 дүгээр сарын урьдчилсан гүйцэтгэлээр 8.0 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 4.6 (2.4 дахин) их наяд төгрөгөөр өслөө. Үүнд уул уурхайн салбарын борлуулалт 4.4 (2.8 дахин) их наяд төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

**ЗУРАГ 58.** **АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛАЛТ, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар**




**ХҮСНЭГТ 66.** **АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, салбараар**

| Салбар | Жил | | | Сар | | | 2026* I / 2025 I | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2023 | 2024 | 2025 | 2024 I | 2025 I | 2026* I | зөрүү | хувь |
| | тэрбум төгрөг | | | | | | | |
| **Нийт** | **47 555.7** | **51 104.3** | **59 382.9** | **4 059.8** | **3 360.8** | **7 952.4** | **4 591.6** | **2.4**** |
| Уул уурхай, олборлох аж үйлдвэр | 36 866.8 | 39 798.7 | 46 027.7 | 3 260.2 | 2 522.1 | 6 946.6 | 4 424.5 | 2.8** |
| Боловсруулах аж үйлдвэр | 8 574.6 | 8 954.7 | 10 332.6 | 561.1 | 535.6 | 609.2 | 73.7 | 13.8 |
| Цахилгаан хий, уур, агааржуулалт | 1 878.7 | 2 065.9 | 2 711.9 | 216.0 | 276.7 | 370.4 | 93.7 | 33.9 |
| Ус хангамж, сувагжилтын систем | 235.7 | 285.0 | 310.6 | 22.4 | 26.4 | 26.1 | - 0.3 | -1.1 |

**Дахин их

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн өмнөх оны мөн үеэс 4.4 (2.8 дахин) их наяд төгрөгөөр өсөхөд металлын хүдэр олборлолтын салбарын борлуулалт 3.5 (3.7 дахин) их наяд төгрөгөөр, чулуун, хүрэн нүүрс олборлолтын салбар 907.6 (88.6%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

**ЗУРАГ 59.** **УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ АЖ ҮЙЛДВЭРИЙН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, салбараар, сараар**




Гадаад зах зээлд 2026 оны 1 дүгээр сарын урьдчилсан гүйцэтгэлээр 6.4 их наяд төгрөгийн борлуулалт хийсний 6.3 их наяд нь уул уурхай, олборлох салбарын борлуулалт байна.

Уул уурхайн бүтээгдэхүүний гадаад борлуулалтын 26.5 хувийг нүүрс олборлолтын салбар, 71.7 хувийг металлын хүдэр олборлолтын салбар, 0.9 хувийг газрын тос олборлолтын салбар, 0.9 хувийг бусад ашигт малтмал олборлолтын салбар эзэлж байна.

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн индекс (улирлын нөлөөллийг арилгасан тооцоо) 2026 оны 1 дүгээр сард 194.1 (2015=100) болж, өмнөх оны мөн үеэс 26.5 хувиар буурсан байна.

**ЗУРАГ 60.** **УЛИРЛЫН НӨЛӨӨЛЛИЙГ АРИЛГАСАН АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БИЕТ ХЭМЖЭЭНИЙ ИНДЕКС, 2015=100**



**ЗУРАГ 61.** **ӨМНӨХ САРТАЙ ХАРЬЦУУЛСАН УЛИРЛЫН НӨЛӨӨЛЛИЙН АРИЛГАСАН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БИЕТ ХЭМЖЭЭНИЙ ИНДЕКС, 2015=100**




<u>Ойлголт, тодорхойлолт:</u>

<u>Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл:</u>
Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

<u>Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн:</u>
Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

<u>Аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн (биет хэмжээний) индекс:</u>
Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг сар бүрийн мэдээлэлд хамруулан судалж, Ласпейрсийн биет хэмжээний индексийн томьёог ашиглан тооцно.

<u>Тооцох аргачлал:</u>
Ласпейрсийн биет хэмжээний индексийн томьёо:

$$I_{LQ} = \frac{\sum (Q_t \cdot P_0)}{\sum (Q_0 \cdot P_0)} \cdot 100 = \sum \left(\frac{Q_t}{Q_0}\right) \cdot W_0 \cdot 100$$

$Q_t$- Бүтээгдэхүүний тайлант үеийн биет хэмжээ

$Q_0$- Бүтээгдэхүүний суурь үеийн биет хэмжээ

$P_0$- Бүтээгдэхүүний суурь үеийн үнэ

$W_0$- Жин

<u>Тайлбар:</u>
ААНБ-ын мэдээнд суурилсан гүйцэтгэл
Нүүрсэн шахмал түлш, чулуун нүүрс, угаасан ноолуур, самнасан ноолуур, төмрийн хүдрийн баяжмалын 2021 оноос хойших мэдээлэл, хайлуур жонш, самнасан хонины ноосны 2023 оноос хойших мэдээлэл засварлагдсан.

<u>Ангилал, код</u>:
Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал
Бүтээгдэхүүн үйлчилгээний нэгдсэн ангилал

# ТЭЭВЭР

## Бүх төрлийн тээврийн орлого 2025 онд өмнөх оноос 5.9 хувиар буурлаа.

### БҮХ ТӨРЛИЙН ТЭЭВЭР

Бүх төрлийн тээврээр 2025 онд 146.5 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оноос 12.7 (9.5%) сая тонноор өссөн байна.

Энэхүү өсөлтөд авто тээврээр тээсэн ачаа 8.7 (9.9%) сая тонн, төмөр замын тээврээр тээсэн ачаа 4.0 (8.8%) сая тонноор тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

**ХҮСНЭГТ 67. БҮХ ТӨРЛИЙН ТЭЭВРИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ**

| Үзүүлэлт | Хэмжих нэгж | Жил | | | 2025* / 2024 | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 2023 | 2024 | 2025* | зөрүү | хувь |
| Тээсэн ачаа | сая т. | 107.7 | 133.7 | 146.5 | 12.7 | 9.5 |
| Зорчигчид | сая хүн | 146.5 | 153.2 | 179.8 | 26.6 | 17.4 |
| Орлого | их наяд төг | 11.9 | 12.5 | 11.8 | -0.7 | -5.9 |

Бүх төрлийн тээврээр 2025 онд 179.8 сая хүн (давхардсан тоогоор) зорчсон нь өмнөх оноос 26.6 (17.4%) сая хүнээр өссөн байна.

**ЗУРАГ 62. БҮХ ТӨРЛИЙН ТЭЭВРИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2025 онд**




Бүх төрлийн тээврийн орлого 2025 онд 11.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 745.5 (5.9%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Энэхүү бууралтад авто тээврийн орлого 1.2 (16.4%) их наяд төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна. 2025 оны 4 дүгээр улиралд, бүх төрлийн тээврийн орлого өмнөх улирлаас 612.3 (20.6%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

### АВТО ЗАМЫН ТЭЭВЭР

Авто тээврээр 2025 онд 96.5 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оноос тээсэн ачаа 8.7 (9.9%) сая тонноор өссөн байна. Энэ өсөлтөд уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлт 8.5 (10.1%) сая тонноор өссөн нь нөлөөлсөн байна.

Авто тээврээр 2025 онд давхардсан тоогоор 175.5 сая хүн тээвэрлэсэн нь өмнөх оноос 26.5 (17.8%) сая хүнээр өссөн байна. Энэ өсөлтөд нийслэлийн нийтийн тээврийн зорчигчид (давхардсан тоогоор) 26.4 (17.9%) сая хүнээр өссөн нь нөлөөлсөн байна.

## ХҮСНЭГТ 68. АВТО ЗАМЫН ТЭЭВРИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

| Үзүүлэлт | Хэмжих нэгж | Жил | | | 2025*/2024 | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 2023 | 2024 | 2025* | зөрүү | хувь |
| Тээсэн ачаа | сая т. | 71.2 | 87.8 | 96.5 | 8.7 | 9.9 |
| Уул уурхайн бүтээгдэхүүн | сая т. | 68.0 | 83.9 | 92.4 | 8.5 | 10.1 |
| Зорчигчид | сая хүн | 142.6 | 149 | 175.5 | 26.5 | 17.8 |
| Нийслэлийн нийтийн тээврийн зорчигчид | сая хүн | 140.3 | 147.0 | 173.4 | 26.4 | 17.9 |
| Ачаа эргэлт | тэрбум т.км. | 11.7 | 13.3 | 14.3 | 0.9 | 6.8 |
| Зорчигч эргэлт | тэрбум хүн км. | 1.5 | 1.6 | 1.9 | 0.3 | 16.3 |
| Шилжүүлсэн т.км | тэрбум т.км. | 12.3 | 14.0 | 15.0 | 1.0 | 7.2 |
| Орлого | их наяд төг. | 7.4 | 7.4 | 6.2 | -1.2 | -16.4 |

Авто тээврээр тээсэн ачаа 2025 оны 4 дүгээр улиралд өмнөх улирлаас 2.1 (8.1%) сая тонноор, зорчигчид 2.1 (4.7%) сая хүнээр тус тус өссөн байна.

## ЗУРАГ 63. АВТО ТЭЭВРИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, жилээр




Авто тээврийн салбарын орлого 2025 онд 6.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 1.2 (16.4%) их наяд төгрөгөөр буурсан байна.

## ХҮСНЭГТ 69. АВТО ЗАМААР ТЭЭСЭН УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮН, дүнд эзлэх хувиар

| Үзүүлэлт | 2024 | | 2025* | |
|---|---|---|---|---|
| | тоо хэмжээ, мян.т. | дүнд эзлэх хувь | тоо хэмжээ, мян.т. | дүнд эзлэх хувь |
| **Нийт** | **83 869.4** | **100.0** | **92 360.2** | **100.0** |
| Нүүрс | 81 090.6 | 96.7 | 88 608.5 | 95.9 |
| Төмрийн хүдэр | 1 073.7 | 1.3 | 1 647.0 | 1.8 |
| Жонш | 954.8 | 1.1 | 1 128.3 | 1.2 |
| Зэсийн баяжмал | 178.5 | 0.2 | 465.3 | 0.5 |
| Газрын тос | 503.5 | 0.6 | 436.3 | 0.5 |
| Бусад | 68.3 | 0.1 | 74.9 | 0.1 |

## ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВЭР

Төмөр замын тээврээр 2025 онд 49.9 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнө оноос 4.0 (8.8%) сая тонноор өссөн байна. Энэ өсөлтөд дотоодод тээсэн ачаа 3.2 (12.8%) сая тонн, дамжин өнгөрөх ачаа 646.0 (12.2%) мянган тонн, экспортын ачаа 77.2 (0.7%) мянган тонн, импортын ачаа 76.1 (2.0%) мянган тонноор өссөн нь тус тус нөлөөлсөн байна.

### ХҮСНЭГТ 70. ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

| Үзүүлэлт | Хэмжих нэгж | Жил | | | 2025* / 2024 | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 2023 | 2024 | 2025* | зөрүү | хувь |
| Тээсэн ачаа, | сая т. | 36.5 | 45.9 | 49.9 | 4.0 | 8.8 |
| Дотоодод | сая т. | 16.6 | 25.2 | 28.4 | 3.2 | 12.8 |
| Уул уурхайн бүтээгдэхүүн | сая т. | 24.0 | 32.9 | 36.8 | 3.9 | 11.8 |
| Зорчигчид | сая хүн | 2.1 | 2.0 | 1.8 | -0.2 | -10.6 |
| Ачаа эргэлт | тэрбум т.км. | 19.7 | 21.3 | 23.2 | 1.9 | 9.0 |
| Зорчигч эргэлт | тэрбум хүн км. | 0.8 | 0.8 | 0.7 | -0.1 | -13.9 |
| Шилжүүлсэн т.км | тэрбум т.км. | 20.5 | 22.1 | 23.9 | 1.8 | 8.1 |
| Орлого | тэрбум төг. | 1 369.4 | 1 652.7 | 1 880.6 | 227.9 | 13.8 |

### ХҮСНЭГТ 71. ТӨМӨР ЗАМААР ТЭЭСЭН АЧАА, дүнд эзлэх хувиар

| Үзүүлэлт | 2024 | | 2025* | |
|---|---|---|---|---|
| | тоо хэмжээ, мян.т. | дүнд эзлэх хувь | тоо хэмжээ, мян.т. | дүнд эзлэх хувь |
| **Нийт** | **36 804.9** | **100.0** | **40 112.9** | **100.0** |
| Уул уурхайн бүтээгдэхүүн | 32 939.2 | 89.5 | 36 840.7 | 91.8 |
| Барилгын материал | 1 503.7 | 4.1 | 1 762.1 | 4.4 |
| Бусад | 1 673.2 | 4.5 | 1 037.8 | 2.6 |
| ХАА-н гаралтай бүтээгдэхүүн | 170.0 | 0.5 | 174.0 | 0.4 |
| Хар төмөр (хаягдал, рельс г.м) | 201.4 | 0.5 | 152.7 | 0.4 |
| Хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүн | 229.8 | 0.6 | 90.2 | 0.2 |
| Мод, модон материал | 53.3 | 0.1 | 41.1 | 0.1 |
| Үйлдвэрийн машин, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл | 34.3 | 0.1 | 14.2 | 0.0 |

Төмөр замаар дотоодод тээсэн ачаа өмнөх оноос өсөхөд уул уурхайн бүтээгдэхүүн 3.9 (11.8%) сая тонн, барилгын материал 258.4 (17.2%) мянган тонноор өссөн нь голлон нөлөөлсөн байна.

### ЗУРАГ 64. ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, жилээр



Төмөр замын тээврээр 2025 онд 1.8 (давхардсан тоогоор) сая зорчигч тээвэрлэж, өмнөх оноос 209.0 (10.6%) мянган зорчигчоор буурсан байна. Төмөр замын тээврийн орлого 2025 онд 1.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 227.9 (13.8%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Энэхүү өсөлтөд дотоодод, дамжин өнгөрөх, экспорт, импортын тээвэрлэлт өссөн нь нөлөөлсөн байна. Төмөр замын тээврийн орлого 2025 оны 4 дүгээр улиралд өмнөх улирлаас 89.1 (18.2%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

## АГААРЫН ТЭЭВЭР

Агаарын тээврээр 2025 онд 12.5 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оноос 2.1 (20.3%) мянган тонноор өссөн байна. Агаарын тээврээр 2025 онд дотоодод тээсэн ачаа 39.7 тонн болж, өмнөх оноос 11.5 (40.6%) тонн, олон улсад тээсэн ачаа 12.5 мянган тонн болж, өмнөх оноос 2.1 (20.3%) мянган тонноор тус тус өссөн байна.

**ХҮСНЭГТ 72. АГААРЫН ТЭЭВРИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ**

| Үзүүлэлт | Хэмжих нэгж | Жил | | | 2025* / 2024 | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 2023 | 2024 | 2025 | зөрүү | хувь |
| Тээсэн ачаа | мян.т. | 8.6 | 10.4 | 12.5 | 2.1 | 20.3 |
| Зорчигчид | сая хүн | 1.7 | 2.2 | 2.4 | 0.3 | 13.0 |
| Олон улсад | сая хүн | 1.3 | 1.7 | 2.0 | 0.3 | 14.8 |
| Ачаа эргэлт | тэрбум т.км. | 24.3 | 29.0 | 28.1 | -0.9 | -3.1 |
| Зорчигч эргэлт | тэрбум хүн км. | 3.9 | 4.9 | 5.7 | 0.8 | 16.1 |
| Шилжүүлсэн т.км | тэрбум т.км. | 0.4 | 0.5 | 0.5 | 0.1 | 15.0 |
| Орлого | тэрбум төг. | 1 034.0 | 1 242.4 | 1 297.2 | 54.8 | 4.4 |

Агаарын тээврээр 2025 оны 4 дүгээр улиралд тээсэн ачаа өмнөх улирлаас 1.8 (60.0%) мянган тонноор өссөн байна. Энэхүү өсөлтөд олон улсад тээсэн ачаа 1.8 (59.9%) мянган тонноор өссөн нь нөлөөлсөн байна.

**ЗУРАГ 65. АГААРЫН ТЭЭВРИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, жилээр**










Агаарын тээврийн зорчигчид 2025 онд 2.4 сая (давхардсан тоогоор)-д хүрч, өмнөх оноос 281.1 (13.0%) мянган хүнээр өссөн байна.

Агаарын тээврээр олон улсад зорчигчид 2025 онд 2.0 саяд хүрч, өмнөх оноос 259.3 (14.8%) мянган хүнээр нэмэгдсэн байна. Энэхүү өсөлтөд Бээжин чиглэлийн зорчигчид 40.7 (14.9%) мянга, Токио чиглэлийн зорчигчид 38.9 (31.1%) мянга, Чонжу чиглэлийн зорчигчид 26.1 (2.7 дахин) мянга, Ордос чиглэлийн зорчигчид 23.8 (5.2 дахин) Хайнан чиглэлийн зорчигчид 21.6 (94.2%) мянган хүнээр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Агаарын тээврээр орон нутагт зорчигчид 442.2 мянгад хүрч, өмнөх оноос 21.9 (5.2%) мянган хүнээр нэмэгджээ.

Агаарын үндэсний тээвэрлэгчдийн орлого 2025 онд 1.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 54.8 (4.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Ойлголт, тодорхойлолт:

Ачаа эргэлт:
Нэг тонн ачааг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Ачаа эргэлт болон тээвэрлэсэн ачааны хэмжээг тээврийн төрөл тус бүр дээр ачааны төрлөөр тооцно. Ачаа эргэлтийг тонн километрээр илэрхийлнэ.

Зорчигч эргэлт:
Нэг зорчигчийг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Зорчигч эргэлтийг хүн.км-ээр илэрхийлнэ.

Шилжүүлсэн тонн километр:
Тээврээр гүйцэтгэсэн олон төрөл, хэлбэрийн ажил, үйлчилгээг тусгай коэффициентуудыг ашиглан нэг нэгжид буюу тонн километрт шилжүүлсэн үзүүлэлт юм. Энэ үзүүлэлт нь тээврийн төрөл тус бүрд харилцан адилгүй тооцогддог.

Тээврийн орлого:
Тээврийн үйлчилгээ үзүүлсний төлбөр болгож авч байгаа өртгийн нийлбэр юм. Өөрөөр хэлбэл тээврийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн буюу ачаа, зорчигч тээвэрлэлт түүнтэй холбогдсон үйл ажиллагаанаас орсон орлого юм.

# МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБОО

**Мэдээлэл, харилцаа холбооны салбарын орлого өмнөх оноос 11.9 хувиар өслөө.**

Мэдээлэл, харилцаа холбооны салбарын нийт орлого 2025 онд 3.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 407.2 (11.9%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Энэхүү өсөлтөд цахилгаан холбооны орлого 294.7 (14.2%) тэрбум төгрөг, компьютер программчлал, зөвлөгөө болон түүнд холбогдох үйл ажиллагааны орлого 96.0 (13.1%) тэрбум төгрөг, өргөн нэвтрүүлэг бэлтгэх, дамжуулах үйл ажиллагааны орлого 9.3 (2.7%) тэрбум төгрөгөөр, мэдээллээр үйлчлэх үйл ажиллагааны орлого 4.4 (6.2%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

**ХҮСНЭГТ 73.** **МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЛБАРЫН ОРЛОГО, дэд салбараар**

| Үзүүлэлт | Жил | | | 2025*/2024 | |
|---|---|---|---|---|---|
| | 2023 | 2024 | 2025* | зөрүү | хувь |
| | тэрбум төгрөг | | | | |
| Нийт орлого | 2 953.6 | 3 414.3 | 3 821.4 | 407.2 | 11.9 |
| Эх бэлтгэх, нийтлэх үйл ажиллагаа | 37.4 | 35.2 | 37.3 | 2.1 | 5.8 |
| Кино, видео, телевизийн хөтөлбөрийн үйлдвэрлэл, бичлэг хийх болон хөгжим, ая үйлдвэрлэх үйл ажиллагаа | 179.9 | 163.1 | 163.7 | 0.6 | 0.4 |
| Өргөн нэвтрүүлэг бэлтгэх, дамжуулах үйл ажиллагаа | 317.3 | 339.5 | 348.8 | 9.3 | 2.7 |
| Цахилгаан холбооны үйл ажиллагаа | 1 794.9 | 2 071.9 | 2 366.6 | 294.7 | 14.2 |
| Компьютер программчлал, зөвлөгөө болон түүнд холбогдох үйл ажиллагаа | 570.4 | 734.0 | 830.0 | 96.0 | 13.1 |
| Мэдээллээр үйлчлэх үйл ажиллагаа | 53.7 | 70.6 | 75.0 | 4.4 | 6.2 |

Мэдээлэл, харилцаа холбооны салбарын орлогын 61.9 хувийг цахилгаан холбоо, 21.7 хувийг компьютер программчлал, зөвлөгөө болон түүнд холбогдох үйл ажиллагаа, 9.1 хувийг өргөн нэвтрүүлэг бэлтгэх, дамжуулах үйл ажиллагаа, 4.3 хувийг кино, видео, телевизийн хөтөлбөрийн үйлдвэрлэл, бичлэг хийх болон хөгжим, ая үйлдвэрлэх үйл ажиллагаа, 2.0 хувийг мэдээллээр үйлчлэх үйл ажиллагаа, 1.0 хувийг эх бэлтгэх, нийтлэх үйл ажиллагааны орлого тус тус бүрдүүлж байна.

**ЗУРАГ 66.** **МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЛБАРЫН ОРЛОГО, өөрчлөлтийн хувиар**



Суурин холбооны идэвхтэй хэрэглэгчийн тоо 2025 оны эцэст 692.7 мянгад хүрч, өмнөх оноос 71.4 (11.5%) мянган хүнээр өссөн. Энэхүү өсөлтөд Улаанбаатар хотын суурин холбооны хэрэглэгчдийн тоо 59.5 (12.1%) мянган хүнээр, Өвөрхангай аймаг 1.9 (46.3%) мянган хүнээр, Сэлэнгэ аймаг 1.5 (21.7%) мянган хүнээр тус тус өссөн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Үүрэн холбооны идэвхтэй хэрэглэгчдын тоо 2025 оны эцэст 5.1 (давхардсан тоогоор) сая хүрч, өмнөх оноос 189.2 (3.9%) мянган хэрэглэгчээр өссөн байна.

Олон суваг дамжуулах үйлчилгээний идэвхтэй хэрэглэгчид 769.0 мянга болж, өмнөх оноос 15.2 (2.0%) мянган хүн, интернэт хэрэглэгчдийн тоо давхардсан тоогоор 608.6 мянгад хүрч, өмнөх оноос 62.3 (11.4%) мянга хүнээр, хөдөлгөөнт өргөн зурвасын идэвхтэй хэрэглэгчид (гэрээний нөхцөлөөр) 4.6 сая хүрч, өмнөх оноос 430.6 (11.4%) мянган хүнээр тус тус өсжээ.

**ХҮСНЭГТ 74.** **МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЛБАРЫН ХЭРЭГЛЭГЧИД, бүс, аймаг, нийслэлээр, төрлөөр, 2025 онд**

| Бүс, аймаг, нийслэл | Суурин холбооны идэвхтэй хэрэглэгчид | Үүрэн холбооны идэвхтэй хэрэглэгчид (давхардсан тоогоор), мянган хүн | Хөдөлгөөнт өргөн зурвасын идэвхтэй хэрэглэгчид (гэрээний нөхцөлөөр) мянган хүн | Интернэт хэрэглэгчид (технологийн төрлөөр) | Олон суваг дамжуулах үйлчилгээний идэвхтэй хэрэглэгчид |
|---|---|---|---|---|---|
| Дүн | 692 668 | 5 078.3 | 4 568.0 | 608 563 | 768 966 |
| Баруун бүс | 19 807 | 485.7 | 415.5 | 22 836 | 53 778 |
| Баян-Өлгий | 3 794 | 107.2 | 98.3 | 4 393 | 10 228 |
| Говь-Алтай | 3 558 | 71.9 | 60.4 | 4 232 | 8 219 |
| Завхан | 2 611 | 107.2 | 81.1 | 3 028 | 11 332 |
| Увс | 4 436 | 94.1 | 84.1 | 4 718 | 11 415 |
| Ховд | 5 408 | 105.2 | 91.6 | 6 465 | 12 584 |
| Хангайн бүс | 52 278 | 701.4 | 604.0 | 55 729 | 104 161 |
| Архангай | 4 108 | 104.9 | 85.6 | 4 594 | 13 979 |
| Баянхонгор | 6 367 | 103.4 | 87.6 | 7 223 | 13 762 |
| Булган | 2 502 | 65.9 | 57.5 | 3 537 | 9 312 |
| Орхон | 25 805 | 134.1 | 126.4 | 24 692 | 27 635 |
| Өвөрхангай | 5 887 | 124.9 | 109.6 | 7 279 | 18 198 |
| Хөвсгөл | 7 609 | 168.3 | 137.2 | 8 404 | 21 275 |
| Төвийн бүс | 54 369 | 751.7 | 695.4 | 65 289 | 95 460 |
| Говьсүмбэр | 2 067 | 22.4 | 20.6 | 2 679 | 3 266 |
| Дархан-Уул | 19 208 | 142.8 | 131.9 | 22 106 | 21 340 |
| Дорноговь | 8 040 | 119.3 | 109.3 | 9 503 | 14 698 |
| Дундговь | 2 409 | 58.7 | 48.0 | 3 240 | 7 748 |
| Өмнөговь | 10 198 | 172.2 | 168.0 | 11 638 | 15 546 |
| Сэлэнгэ | 8 444 | 115.9 | 109.6 | 10 420 | 17 813 |
| Төв | 4 003 | 120.5 | 107.8 | 5 703 | 15 049 |
| Зүүн бүс | 14 556 | 307.8 | 257.9 | 19 581 | 39 431 |
| Дорнод | 7 773 | 106.0 | 92.4 | 10 512 | 15 711 |
| Сүхбаатар | 2 892 | 83.1 | 71.8 | 3 437 | 10 510 |
| Хэнтий | 3 891 | 118.7 | 93.7 | 5 632 | 13 210 |
| Улаанбаатар | 551 658 | 2 831.7 | 2 595.3 | 445 128 | 476 136 |

## Ойлголт, тодорхойлолт:

**Эх бэлтгэх, нийтлэх үйл ажиллагаа**:
Ном, танилцуулга, сурталчилгааны хуудас, толь бичиг, нэвтэрхий толь, атлас, газрын зураг сонин сэтгүүл, нэрсийн жагсаалт, хаягийн жагсаалтын болон бусад зүйлсийн эх бэлтгэхийг хэлнэ. Түүнчлэн программ хангамжий боловсруулах үйл ажиллагаа орно.

**Харилцаа холбоо**:
Цахилгаан холбоо, радио, телевиз, мэдээллийн технологийн төрлийг ойлгоно.

**Цахилгаан холбооны үйлчилгээ**:
Цахилгаан холбооны сүлжээг ашиглан, бүх төрлийн мэдээлэл дамжуулах үйл ажиллагааг ойлгоно;

**Интернэт:**
Стандартчилсан протокол (TCP/IP)-ын дагуу мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлсэн, харилцан холбогдсон олон нийтийн болон хувийн сүлжээнүүдийн дэлхий нийтийн системийг хэлнэ.

**Өргөн зурвас**:
Өндөр хурдны интернэтийн байнгын холболтод суурилсан гурвалсан үйлчилгээ, энэхүү үйлчилгээг дамжуулах өндөр чадамжтай сүлжээ бүхий технологийн нэгдэл.

**Утасгүй суурин холбоо (WLL)**:
Харилцаа холбооны хэрэглэгчдэд энгийн утасны үйлчилгээ (POST) эсвэл интернэтийн хандалтыг хүргэхийн тулд утасгүй холбоог ашиглахыг хэлнэ.

**Интернэт протоколд суурилсан телевиз (IPTV)**
Интернэт протокол дээр суурилсан сүлжээгээрээ дамжуулсан телевиз/видео/аудио/текст/график/өгөгдөл гэх мэт мультимедиа үйлчилгээг хэлнэ.

**Газрын тоон телевиз (DTT**:
Аналоги газрын телевизээс технологийн талаасаа илүү сайжирсан, мөн олон суваг дамжуулах боломжийг олгосон үйлчилгээг хэлнэ.

**Хиймэл дагуулын үйлчилгээ (DTH):**
Хиймэл дагуулын телевизийн нэвтрүүлэг хүлээн авах чадвартай хиймэл дагуулын таваг ашиглан хүлээн авсан телевизийн үйлчилгээг ойлгоно.

**Радио**:
FM, AM, LW ба SW зэрэг радио долгио ашиглан радио нэвтрүүлгийг хүлээн авах боломжтой хэрэгслийг хэлнэ. Радио хүлээн авагч төхөөрөмж нь дангаараа болон бусад төхөөрөмжтэй нэгдсэн байж байж болно.

**Хэрэглэгч**:
Харилцаа холбооны үйлчилгээ үзүүлэх гэрээнд үйлчилгээг худалдан авах эрхтэйгээр оролцож байгаа иргэн, хуулийн этгээдийг ойлгоно.

# ДОТООД ХУДАЛДАА

## Худалдааны салбарын борлуулалтын орлого 2025 онд өмнөх оноос 2.0 хувиар өссөн байна.

Худалдааны салбарын борлуулалтын орлого 2025 онд 69.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 1.3 (2.0%) их наяд төгрөгөөр өслөө.

Худалдааны салбарын борлуулалтын орлогын 21.6 хувийг хүнсний бүтээгдэхүүн, 78.4 хувийг хүнсний бус бүтээгдэхүүний борлуулалт эзэлж байна.
Хүнсний бүтээгдэхүүний худалдаа 2025 онд 15.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 753.1 (5.3%) тэрбум төгрөгөөр, хүнсний бус бүтээгдэхүүний худалдаа 54.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 579.5 (1.1%) тэрбум төгрөгөөр тус тус өслөө.

Хүнсний бус бүтээгдэхүүний өсөлтөд барилгын материал, техник, сантехник, халаалт, ус түгээх төхөөрөмж болон тэдгээрийн туслах төхөөрөмжийн бөөний худалдаа өмнөх оноос 255.0 (9.2%) тэрбум төгрөгөөр, эм, гоо сайхан, ариун цэврийн барааны төрөлжсөн дэлгүүрийн жижиглэн худалдаа 231.9 (9.7%) тэрбум төгрөгөөр, шатахууны жижиглэн худалдаа 210.5 (2.0%) тэрбум төгрөгөөр, компьютер, түүний дагалдах хэрэгсэл, програм хангамж, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн төрөлжсөн дэлгүүрийн жижиглэн худалдаа 170.5 (10.9%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

**ХҮСНЭГТ 75.** **ХУДАЛДААНЫ САЛБАРЫН БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО[1]**

| Үзүүлэлт | 2023 | 2024 | 2025* | 2025* / 2024 | |
|---|---|---|---|---|---|
| | тэрбум төгрөг | | | зөрүү | хувь |
| Нийт | 59 975.0 | 68 019.5 | 69 352.1 | 1 332.6 | 2.0 |
| Бөөний худалдаа | 26 931.7 | 30 997.2 | 31 540.7 | 543.4 | 1.8 |
| Жижиглэн худалдаа | 33 043.3 | 37 022.3 | 37 811.4 | 789.1 | 2.1 |

[1] Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч хуулийн этгээдийн мэдээллийн санд үндэслэсэн тооцоо

Худалдааны салбарын 2025 онд борлуулалтын орлогын 45.5 хувь нь бөөний худалдаа, 54.5 хувь нь жижиглэн худалдааны салбарт ногдож байна.

**ЗУРАГ 67.** **БӨӨНИЙ БОЛОН ЖИЖИГЛЭН ХУДАЛДААНЫ БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО, сараар**



Жижиглэн худалдааны борлуулалтын орлого 2025 онд 37.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 789.1 (2.1%) тэрбум төгрөгөөр, бөөний худалдааных 31.5 их наяд төгрөг болж, өмнөх оноос 543.4 (1.8%) тэрбум төгрөгөөр тус тус өслөө.

**ЗУРАГ 68. ХУДАЛДААНЫ БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН ӨӨРЧЛӨЛТ, сараар, өмнөх онтой харьцуулснаар, хувиар**




Худалдааны салбарын борлуулалтын орлого 2025 оны 12 дугаар сард 9.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх сараас 3.3 (58.6%) их наяд төгрөгөөр өссөн байна.

**ЗУРАГ 69. ХУДАЛДААНЫ САЛБАРЫН БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН ӨӨРЧЛӨЛТ, өмнөх онтой харьцуулснаар, аймаг, нийслэлээр, хувиар**




2025 онд худалдааны салбарын борлуулалтын орлогын 86.4% нь Улаанбаатар, 3.2% нь Өмнөговь, 1.3% нь Дархан-Уул, 1.2% нь Орхон аймагт тус тус ногдож байгаа нь худалдааны салбарын нийт борлуулалтын 92.1 хувийг бүрдүүлж байна.

Ойлголт, тодорхойлолт:

Худалдааны салбарын нийт борлуулалт нь тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний борлуулалт бөгөөд тайлант хугацаанд худалдааны салбарын аж ахуйн нэгж байгууллагуудын цэвэр борлуулалтын нийлбэрээр тооцно.

# БАЙР СУУЦ, НИЙТИЙН ХООЛ

## Байр суучаар хангах салбарын орлого 2025 онд өмнөх оноос 17.5 хувиар өссөн байна.

Байр суучаар хангах салбарын орлого 2025 онд 354.1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 52.8 (17.5%) тэрбум төгрөгөөр өсжээ. Үүнд 3 ба түүнээс дээш одтой зочид буудлын орлого 24.9 (20.1%) тэрбум төгрөг, 2 одтой зочид буудлын орлого 0.1 (0.9%), тэрбум төгрөг, зэрэглэлгүй зочид буудал, амралтын газрынх 27.8 (16.5%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

**ХҮСНЭГТ 76. БАЙР СУУЦААР ХАНГАХ САЛБАРЫН ОРЛОГО, төрлөөр**

| Үзүүлэлт | Жил | | | | 2025*/2024 | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2022 | 2023 | 2024 | 2025* | зөрүү | хувь |
| | тэрбум төгрөг | | | | | |
| Нийт | 190.3 | 261.6 | 301.3 | 354.1 | 52.8 | 17.5 |
| Зэрэглэлгүй | 104.9 | 139.8 | 167.9 | 195.6 | 27.8 | 16.5 |
| 2 одтой | 7.4 | 10.3 | 9.8 | 9.9 | 0 .1 | 0 .9 |
| 3 ба түүнээс дээш | 78.1 | 111.5 | 123.7 | 148.6 | 24.9 | 20.1 |

Байр суучаар хангах салбарын орлого 2025 оны 12 дугаар сард 31.4 тэрбум төгрөгт хүрч, өмнөх сараас 7.2 (29.6%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

**ЗУРАГ 70. БАЙХ СУУЦААР ХАНГАХ САЛБАРЫН ОРЛОГО, төрлөөр, тэрбум төгрөг**




Байр суучаар хангах салбарын 2025 оны нийт орлогын 55.2 хувийг зэрэглэлгүй зочид буудал, амралтын газар, 42.0 хувийг 3 ба түүнээс дээш одтой зочид буудал, 2.8 хувийг 2 одтой зочид буудлын орлого тус тус эзэлж байна.

**ЗУРАГ 71. БАЙР СУУЦААР ХАНГАХ САЛБАРЫН ОРЛОГО, аймаг, нийслэлээр**




Байр сууцаар хангах салбарын 2025 оны нийт орлогын 72.6 хувь Улаанбаатар хотод ногдож байна.

## Нийтийн хоолны салбарын орлого 2025 онд өмнөх оноос 11.9 хувиар өссөн байна.

Нийтийн хоолны салбарын орлого 2025 онд 2.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 228.1 (11.9%) тэрбум төгрөгөөр өсжээ.
Үүнд рестор採ны орлого 134.9 (11.0%) тэрбум төгрөгөөр, кэйтерингийн орлого 42.9 (13.8%) тэрбум төгрөгөөр, цайны газрын орлого 31.9 (17.1%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

**ХҮСНЭГТ 77. НИЙТИЙН ХООЛНЫ САЛБАРЫН ОРЛОГО, төрлөөр**

| Үзүүлэлт | Жил | | | | 2025* / 2024 | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2022 | 2023 | 2024 | 2025* | зөрүү | хувь |
| | тэрбум төгрөг | | | | | |
| **Нийт** | **1 350.1** | **1 657.4** | **1 923.4** | **2 151.5** | **228.1** | **11.9** |
| Баар | 46.1 | 57.1 | 63.1 | 68.9 | 5.7 | 9.1 |
| Кафе | 85.6 | 107.3 | 136.6 | 149.1 | 12.5 | 9.2 |
| Цайны газар | 129.7 | 164.1 | 187.2 | 219.1 | 31.9 | 17.1 |
| Кэйтеринг | 235.1 | 281.6 | 312.0 | 354.9 | 42.9 | 13.8 |
| Ресторан | 853.6 | 1 047.4 | 1 224.5 | 1 359.4 | 134.9 | 11.0 |

*Урьдчилсан гүйцэтгэл

Нийтийн хоолны салбарын орлого 2025 оны 12 дугаар сард 234.2 тэрбум төгрөгт хүрч, өмнөх сараас 68.0 (40.9%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

**ЗУРАГ 72.** **НИЙТИЙН ХООЛНЫ САЛБАРЫН ОРЛОГО, төрлөөр, тэрбум төгрөг**




Нийтийн хоолны салбарын 2025 оны нийт орлогын 63.2 хувийг ресторан, 16.5 хувийг кэйтеринг, 10.2 хувийг цайны газар, 6.9 хувийг кафе, 3.2 хувийг баарны орлого тус тус эзэлж байна.

**ЗУРАГ 73.** **НИЙТИЙН ХООЛНЫ САЛБАРЫН ОРЛОГО, аймаг, нийслэлээр, тэрбум төгрөг**




Нийтийн хоолны салбарын 2025 оны нийт орлогын 81.9 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна.

__Ойлголт, тодорхойлолт__:

Нийтийн хоолны салбарт ресторан, кафе, баар, гуанз, захиалгат хоол хүргэх, үйлчлэх үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдийг хамруулна.

Байр сууцаар хангах салбарт зочид буудал, амралтын газар, хүүхдийн зуслан, түр хоноглох байруудын үйл ажиллагаа хамрагдана.

# АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ

**Хүний үйл ажиллагаатай холбоотой осол 2026 оны 1 дүгээр сард 399 удаа бүртгэгдсэн байна.**

Аюулт үзэгдэл, ослын тохиолдол 2026 оны 1 дүгээр сард 410 удаа бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 53 (14.8%)-аар өссөн байна.

Тохиолдсон аюулт үзэгдэл, осолд 2026 оны 1 дүгээр сард 20 хүн нэрвэгдэж, 4.2 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна.

**ХҮСНЭГТ 78.** **АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ**

| Үзүүлэлт | Жил | | | 1 дүгээр сар | | | 2026* I / 2025 I | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2023 | 2024 | 2025 | 2024 I | 2025 I | 2026* I | зөрүү | хувь |
| Аюулт үзэгдэл, ослын тохиолдол | 4 484 | 5 118 | 5 371 | 392 | 357 | 410 | 53 | 14.8 |
| Амь насаа алдсан хүний тоо | 320 | 336 | 306 | 22 | 9 | 20 | 11 | 2.2** |
| Учирсан хохирол, тэрбум төгрөг | 53.0 | 41.7 | 634.9 | 2 104.9 | 7.4 | 4.2 | - 3.2 | - 43.1 |

Тохиолдсон аюулт үзэгдэл, ослыг төрлөөр авч үзвэл, 2026 оны 1 дүгээр сард геологийн гаралтай аюулт үзэгдэл 9 (2.2%) удаа, биологийн гаралтай аюулт үзэгдэл 2 (0.5%) удаа, хүний үйл ажиллагаатай холбоотой осол 399 (97.3%) удаа тус тус бүртгэгдсэн байна.

**ЗУРАГ 74.** **АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ, төрлөөр**



Ойлголт, тодорхойлолт:

Аюулт үзэгдэл:
Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, аянга, газар хөдлөлт, гал түймэр, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гарах, хортон шавж, мэрэгч тархах зэргийг хэлнэ.

Гамшиг:
Аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд улс болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн дотоод нөөц, боломжоос давсан хохирол учрахыг хэлнэ.

# БҮЛЭГ

| | | Танилцуулга бэлтгэсэн: |
|---|---|---|
| | Үндсэн үзүүлэлтүүд | З.Оюундарь |
| I. | Хөдөлмөр | Т.Хишигбаяр, Б.Цэвэлмаа |
| II. | Өрхийн орлого, зарлага | Н.Хэнбиш |
| II.a. | Хөдөлмөрийн бүтээмж | Б.Цэвэлмаа |
| III. | Дотоодын нийт бүтээгдэхүүн | Э.Гэрэлт-Од |
| IV. | Мөнгө, зээл | Э.Отгонжаргал |
| V. | Үнэт цаасны зах зээл | Э.Отгонжаргал |
| VI. | Даатгал | Э.Отгонжаргал |
| VII. | Улсын нэгдсэн төсөв | Ч.Мөнхтуул |
| VIII. | Төлбөрийн тэнцэл | Д.Хонгорзул |
| IX. | Гадаад худалдаа | Д.Хонгорзул |
| X. | Үнэ | М.Нарандулам, Х.Хонгорзул |
| X.a. | Гадаад худалдааны нөхцөлийн индекс | Т.Жигжидсүрэн |
| X.b | Орон сууцны үнийн индекс | Х.Хонгорзул |
| X.c | Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ | Г.Норжмаа |
| XI.a. | Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс | Б.Энхтүвшин |
| XI.b. | Тээвэр, мэдээлэл, холбооны салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс | Б.Энхтүвшин |
| XI.c. | Барилгын өртгийн индекс | Н.Болор-Эрдэнэ |
| XI.d. | Зочид буудал, байр, сууцаар үйлчлэх, нийтийн хоолны салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс | Н.Болор-Эрдэнэ |
| XII. | Мал аж ахуй | Э.Анар |
| XIII. | Барилга | Б.Алтансувд |
| XIV. | Аж үйлдвэр | Б.Энхболд, Г.Цэвэлмаа |
| XV. | Тээвэр | Н.Уранчимэг |
| XVI. | Холбоо | Д.Буманбаяр |
| XVII. | Дотоод худалдаа | Д.Хонгорзул |
| XVIII. | Зочид буудал, зоогийн газар | Э.Отгонжарал |
| XIX. | Аюулт үзэгдэл, осол | А.Мөнхцэцэг |

**Танилцуулга бэлтгэсэн:** Н.Төгөлдөр
**Танилцуулга хянасан:** Ц.Тэгшжаргал, Д.Баасан

Авлигатай
тэмцэх газар

**Хэрэв танд:**

-Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Нийтийн албан тушаалтны хөрөнгө, орлогын болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл;

-Монгол Улсын Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан "Авлигын гэмт хэрэг"-ийн шинжтэй гомдол мэдээлэл өгөхөөр бол Авлигатай тэмцэх газарт хандана уу:

**Үүнд:**

22.1 дүгээр зүйл */Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах/;*
22.3 дугаар зүйл */Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах/;*
22.4 дүгээр зүйл */Нийтийн албан тушаалтан хахууль авах/;*
22.5 дугаар зүйл */Хахууль өгөх/;*
22.6 дугаар зүйл */Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах/;*
22.7 дугаар зүйл */Улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, үрэгдүүлэх/;*
22.8 дугаар зүйл */Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/;*
22.9 дүгээр зүйл */Төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/;*
22.10 дугаар зүйл */Үндэслэлгүйгээр хөрөнгөжих/;*
22.11 дүгээр зүйл */Дураараа аашлах/;*
22.12 дугаар зүйл */Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах/;*
22.13 дугаар зүйл */Хахууль авах/;*

## ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙН ТОО /ХҮСНЭГТЭЭР ХАРУУЛБАЛ/




# 1-110

Авлигыг мэдээлэх утас

**ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ**
Хүлээн авах суваг

**Авлигатай тэмцэх газарт ирж биечлэн**
**Утсаар:** (976)-110 /Ярианы төлбөргүй/ дугаараар
**Факс:** (976)-11-311919
**Цахим шуудангийн хаяг:** contact@iaac.mn
**Шуудан холбоогоор:** Улаанбаатар хот 14250, Сүхбаатар дүүрэг, 5 хороолол, Сөүлийн гудамж 41 хаягаар
**Веб сайт:** iaac.mn

Авлигын эсрэг НЭГДЬЕ
Үгүй гэж хэлээд өөрчилье! 110